

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-74
1.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./	9-35
2.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, /Засгийн газар 2025.03.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	35-70
3.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 94 дүгээр захирамжаар байгуулагдсан “Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судлах, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх	70-73
4. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	73-74

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 16-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 22 минутад Төрийн ордны “Их Засаг” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн,
Чөлөөтэй: Х.Баттулга,
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, Д.Энхтүвшин.

Хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээрт байгаа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ ирүүлээгүй тул, хэлэлцэх асуудлын дарааллын 5 дугаарт байгаа Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 94 дүгээр захирамжаар байгуулагдсан “Төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судлах, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэхийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн саналаар тус тус хойшлуулав

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт байгаа Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийг зөвшилцөх асуудлыг олон нийтэд хэлэлцүүлсэн байдал, Монголын хүнсчдийн нэгдсэн холбооны санал зэргийг үндэслэн хойшлуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын дарааллаас Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн

орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэхийг хойшлуулав.

Нэг.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, Хуулийн хэлтсийн дарга Г.Ганбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх Г.Өлзийбүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Батболд, Б.Найдалаа, О.Цогтгэрэл, Ж.Алдаржавхлан, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Б.Найдалаа, О.Цогтгэрэл, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, П.Сайнзориг, Р.Сэддорж нар үг хэлэв.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага авав./10:49/

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.03.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Г.Ганбаатар,

Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Цөмийн энергийн комиссын Тамгын газрын дарга Б.Баатарцогт, мөн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, “Эрдэнэс Монгол” нэгдлийн Чанар бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, мөн нэгдлийн Хяналтын асуудал хариуцсан менежер Н.Жавзанпагма, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж, мөн компанийн Санхүү, удирдлагын газрын дарга Г.Бадрах, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Н.Тэгшжаргал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, О.Батнайрамдал, Р.Батболд, О.Цогтгэрэл, Б.Мөнхсоёл, Б.Жаргалан, Р.Сэддорж, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Эрдэнэс Монгол” нэгдлийн Чанар бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Н.Тэгшжаргал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Батболд, Б.Жаргалан, О.Батнайрамдал, П.Сайнзориг, Л.Мөнхбаясгалан нар үг хэлэв.

Р.Сэддорж: 1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	8
Бүгд:	20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

Хамт өргөн мэдүүлсэн:

Р.Сэддорж: 2.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 11
Бүгд: 20
45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 2.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Р.Сэддорж: 3.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Р.Сэддорж: 4.“Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 4. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 4. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Л.Соронзонболд, Ж.Алдаржавхлан, Б.Найдалаа нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд,

О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Б.Найдалаа нар орж ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, мөн газрын мэргэжилтэн М.Тэмүүлэн, Зээлийн мэдээллийн албаны ахлах хянан шалгагч Л.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны хуралдаан давхцаж Улсын Их Хурлын гишүүдийн ирц хүрэхгүй байгаа тул хуралдааныг хойшлуулав. /13.03/

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 41 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг” танхим 09 цаг 22 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Хуралдаанд Алдаржавхлан, Батболд, Батчимэг, Батшугар, Бямбасүрэн, Ганхуяг, Мөнхсоёл, Соронзонболд, Ундраа, Найдлаа, Цогтгэрэл, Цэнгүүн, Энхцэцэг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа. Бадамсүрэн гишүүн орон нутагт томилолттой, Ж.Ганбаатар гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Энхтүвшин гишүүн эмнэлгийн чөлөөтэй.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 4 сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл. Уг төслийг Засгийн газар 2025 оны 4 сарын 4-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

2.Монгол Улс болон Евро Азийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл. Уг төслийг Засгийн газар 2025 оны 3 сарын 31-ний өдөр ирүүлсэн. Мөн зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Засгийн газраас 3 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

4.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 2025 оны 3 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, яаралтай.

5.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай.

6.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 94 дүгээр захирамжаар байгуулагдсан төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судлах санал дүгнэлт гаргах. Шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх.

7.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн Батшугар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг гэсэн ийм 7 асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр 7 хоногийн өмнө тов дараалал батлагдсан байна аа.

Үүнээс Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ХЗБХ-оос санал, дүгнэлтээ ирүүлээгүй байгаа тул өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлууллаа. Зөвшөөрөл зөвшөөрлийн тухай хууль.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан өөр саналтай гишүүд байна уу? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын даргын 2024 оны 94 дүгээр захирамжаар төр хувийн хэвшилд өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах ийм ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа.

2024 оны 12 сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын 038027 дугаарын албан бичиг ЗГХЭГ-ын даргад төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүдтэй холбоотой мэдээллийг гаргуулахаар хүсэлт явуулсан байгаа. Хүсэлтэд бол төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чиг үүрэг, санхүүжилт, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, удирдлага, албан хаагчдын цалин урамшуулал, үйл ажиллагааны төрөл, дотоод, өрсөлдөөн үүсгэж байгаа эсэх гээд мэдээллийг хүссэн боловч одоогийн байдлаар тэр мэдээлэл хангалттай мэдээлэл ирсэнгүй. Мөн Үндэсний аудитын газраас тухайн мэдээлэлтэй холбоотойгоор тодорхой асуудлуудыг нэмж гаргуулах шаардлагатай байгаа тул өчигдрийн ажлын хэсгийн хуралдаан бол яг хуралдаж чадсангүй. Бид нар хуралдааныг дахиад 7-оос хоёр 7 хоногоор хойшлуулахаар өчигдөр ажлын хэсэг дээр дүгнэлт, санал гарсан байгаа. Тэгээд тиймээс энэ ажлын хэсгийн танилцуулгыг хойшлуулах саналтай байна аа.

Ажлын хэсгийн ахлагчийн саналыг үндэслэн хойшлууллаа.

Ингээд 5 асуудлыг.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой санал Батчимэг гишүүн. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Байнгын хорооны дарга, байнгын хорооны эрхэм гишүүдийн амар амгаланг эрье ээ.

Евроазийн өнөөдрийн байнгын хороогоор хэлэлцэх Евроазийн худалдааны хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан миний бие горимын санал гаргая. Танилцуулчих уу дарга аа? Хойшлуулъя гэсэн горимын саналтай байна. Тэгвэл одоо хэлчих үү? Хойшлуулъя гээд. Та бүхний амар амгаланг эрье. Миний бие Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.8-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг дараах 2 үндэслэлээр хэлэлцэж хойшлуулах горимын саналыг гаргаж байгаа юм аа.

Нэгдүгээрт энэхүү хэлэлцээрийн төслийг олон нийтэд хэлэлцүүлсэн байдлын талаар төслийн танилцуулгад үйлдвэрлэл гадаад худалдаа эрхлэгчдийн дунд 2023, 2024 онд 2 удаа, ХАА-н салбарын оролцогч талууд болон мэргэжлийн холбоодын дунд 2025 оны 1 дүгээр сард нэг удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан байдаг юм. Энэ танилцуулга дээр дурдсан байгаа. Гэвч энэ хэлэлцээрийн төслийн талаар дотоодын үйлдвэрлэгч тэгээд гадаад худалдаа эрхлэгч нараас ямар санал ямар байр суурь илэрхийлсэн юм. Эдгээр саналуудыг худалдаа эрхлэгч нараас энэ хүлээн авч энэ хэлэлцээрийнхээ төсөлд хэрхэн яаж тусгасан тухай ерөөсөө тийм тусгаагүй тухай энэ шалтгааныг ерөөсөө олж харсангүй ээ. Тэгээд ямар ч материал байхгүй байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл дотоодын үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгч нар энэхүү хэлэлцээрийн төслийн талаар өнөөдрийг хүртэл ер нь ямархуу байр суурьтай ямар бодол санаатай байгааг мэдэх тийм боломж байхгүй байна гэж харж байна.

Тус хэлэлцээртэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн миний нэр дээр хаягласан мэргэжлийн холбоод тэрний дунд Монголын хүнсчдийн нэгдсэн холбооноос санал хүсэлт ирүүлсэн байгаа юм.

Энэ нь 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр ирүүлсэн. Энэ албан бичигт юу гэж тусгасан гэхээр энэ хэлэлцээрт холбогдох бүх талаас ерөөсөө санал аваагүй, тооцоо судалгаа үндэслэл муутай, саналын зөрүүтэй байгаагийн улмаас Монгол Улсад эдийн засгийн үр ашиггүй хэлэлцээрийг яарч сандран байгуулах гэж байна гэж дүгнэсэн байсан. Тэгээд иймээс үндэсний энэ эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой энэхүү чухал хэлэлцээрийн төслийг өнөөдөр хэлэлцэхийн өмнө Улсын Их Хурал тэгээд ялангуяа манай Байнгын хорооны зүгээс дотоодын үйлдвэрлэгч, дотоод гадаад худалдаа эрхлэгч бизнес эрхлэгчдийнхээ дунд үе шаттай ийм хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж тус хэлэлцээрийн үр нөлөө цаашид гарах үр дагаврын талаар Улсын Их Хурлын гишүүдэд олон талын эх үүсвэрүүдээс мэдээ мэдээллээр хангагдах ийм бололцоог олгох нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Хоёр дахь үндэслэл нь Улсын Их Хурлын гишүүд тус хэлэлцээрийн үр нөлөө, үр өгөөж, үр дагаврын талаар хийсэн яамны шинжилгээнээс гадна хөндлөнгийн мэргэжилтнүүд экспертүүд.

Р.Сэддорж: Батчимэг гишүүнд нэг минут өгье.

П.Батчимэг: Маш олон судалгааны байгууллагууд байдаг. Тэдгээрийн дүгнэлтүүдтэй танилцаж тэдний дүгнэлтийг сонсож олон талын эх үүсвэрүүдээс

бодит мэдээлэлтэй мэдээ мэдээлэл авах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа. Одоо тухайлбал миний гар дээр энэ МУИС-ийн дэргэдэх бодлогын судалгааны лабораториос хийсэн ийм бүрэн иж бүрэн ийм судалгаа саяхан би олж авлаа. Тэгээд энийг бүрэн гүйцэд би бүүр танилцсан. Энэ лаборатори юуны судалгаанд яасан гэхээр Монгол Улс Евроазийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны түр гэрээнд орсноор гарах эдийн засгийн үр нөлөөний ийм шинжилгээний талаар судалгаа хийсэн байгаа. Та бүхэн хэрвээ хүсвэл энэ судалгааг авч үзвэл би өнөөдөр ингээд өгье. Тэгээд энэ судалгааны дүнгээс харахад Монгол Улсаас экспортлох боломжтой маш олон төрлийн бараа бүтээгдэхүүнүүд байгаагийн Евроазийн эдийн засгийн холбоо.

Р.Сэддорж: Санал хураалт явагдана. Ингээд Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар. 2 дугаар асуудал. Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэх асуудлаас хасах санал гаргаж байна. Тийм үү?

Ингээд 2 дугаар асуудлыг хэлэлцэх асуудлаас хасах саналтай гишүүд хойшлуулах гэсэн томъёоллоор санал хураалт. 52.9 хувийн саналаар 2 дугаар асуудал хэлэлцэх асуудлаас хойшлогдлоо.

Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэх асуудлаас хойшлууллаа. Өөр саналтай гишүүд алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна аа. Сайдын микрофоныг нээе. 3 номер.

Ц.Туваан: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр 1 дүгээр асуудлаар хэлэлцэх гэж байна аа. Тэгэхээр энэ талын танилцуулгыг та бүхэнд уншиж өгье өө. Өргөн уудам нутаг дэвсгэртээ хүн амын суурьшил далайд гарцгүй манай орны хувьд агаарын тээврийн салбар нь гадаад ертөнцтэй холбогдох гол гарц болон үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйл болдог аа. Иймээс Засгийн газраас агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин ажиллаж байна аа. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан шинэ сэргэлтийн бодлогын 1 дүгээр зүйл. Боомтын сэргэлт хэсгийн 1.3-д Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа

төвийг бий болгож аялал жуулчлалын салбарыг дэмжинэ гэж тусгайлан заасан. Түүнчлэн шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд зам тээврийн салбарын болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр үндсэн 5 зорилт дэвшүүлж, Монгол Улсын хөгжил, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, агаарын зайн ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар хэрэгжүүлж ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож аялал жуулчлалыг дэмжих зорилтууд тавигдсан.

Монгол Улсад агаарын хөлгийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын 20 гадаадын 7, нийт 27 авиа компани байгаагаас 2024 оны байдлаар нийт нислэгийн тоо 91781 болж өмнөх оны мөн үеэс 44.6 хувиар олон улсын хөөрөлт буултын тоо 12990 болж 34.5 хувиар орон нутгийн хөөрөлт бууралтын тоо 10967 болж өмнөх үеийн оны мөн үеэс 6.3 хувиар тус тус өссөн бөгөөд нийт 2167300 зорчигч тээвэрлэснээс олон улсад сая 746900 зорчигч орон нутагт 420400 зорчигч тус тус зорчсон байгаа нь 2023 онтой харьцуулахад олон улсын чиглэл 25 хувь буюу 435 мянган зорчигчоор орон нутгийн чиглэл 0.25 буюу мянга гаруй зорчигчоор тус тус өссөн үзүүлэлттэй байна аа. Ачаа тээврийн хувьд 2024 оны байдлаар 10365 тонн ачаа тээвэрлэсэн нь 2023 онтой харьцуулахад мөн 21 хувиар тус тус өссөн байна. Аялал жуулчлалд эдийн засгийн идэвх нэмэгдэж байгаа нь 2028 он хүртэл зорчигч ачаа тээвэрлэлт тогтвортой өсөлттэй байх төлөвтэй байгаа бөгөөд агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2024 онд 2.2 саяд хүрсэн, 2028 онд 2.55 сая хүрэх төлөвтэй байна аа.

Өнөөгийн байдлаар манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь ОХУ-аас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал 2021 онд 27 мянган тонн, 2022 онд 38 мянган тонн, 2023 онд 61 мянган тонн, 2024 онд 70 мянган тонн хүрч тогтмол өссөн үзүүлэлттэй байна аа. Энэхүү өсөн нэмэгдэх хандлагатай агаарын хөлгийн түлшний хэрэглээг зах зээлийн боломжит доод үнээр нийлүүлснээр хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг харгалзахаас гадна иргэдэд хүрэх нислэгийн тийзийн үнэ буурахад тодорхой хувиар нөлөөлөл үзүүлэх боломжтой юм аа.

Агаарын хөлгийн тээврийн үйлчилгээ авч буй иргэд авч буй иргэдэд хүрч буй тийзний үнийн 36 хувь нь агаарын хөлгийн түлшний үнээс, харин агаарын хөлгийн шатахууны 86 орчим хувь нь кило үнээс шууд тус тус шууд хамаарч байна аа. Манай орон 2 улс, 2 хөрш улстайгаа хуурай боомтоор хиллэдэг. Далайд гарцгүй орны хувьд агаарын тээвэр нь чухал ач холбогдолтой бөгөөд агаарын хөлгийн түлшийг ОХУ-аас төмөр замаар их хэмжээгээр Улаанбаатар хот хүртэл тээвэрлэж хэрэглэдэг ээ.

Харин БНХАУ-аас онгоцны түлш худалдан авахад төмөр замын царигийн зөрөөтэй байдлаас шалтгаалан Замын-Үүд боомтоор шилжүүлэн ачих байгууламжаар дамжуулан авах бөгөөд одоогоор онгоцны түлшийг хадгалах зориулалтын сав, насос станц, дотоодын тусгай вагон, түлш дээр нь байхгүй байна аа. Мөн БНХАУ-аас нийлүүлэх онгоцны түлшний стандартын хувьд жет түлш бөгөөд өнөөдөр ашиглалтад ороод байгаа шинэ нисэх буудлын шатахуун

хангамжийн байгууламжид ТС-1 агаарын хөлгийн түлштэй хамтад нь ашиглах технологийн шийдэл анхнаасаа төлөвлөгдөөгүй байна. Цаашид дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ болон ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүний дотоод зах зээлийн нөхцөл байдалтай холбогдуулан ОХУ-ын Засгийн газраас экспортын хязгаарлалт хийх татвар нэмэгдүүлэх шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлт тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж хомсдол үүсэж болзошгүй юм аа. Иймд Монгол Улсын агаарын хөлгийн түлш, Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар агаарын хөлгийн түлшний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах Чингис Хаан ОУНБ-ын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой нийлүүлэх боломж бүрдэх юм аа.

Манай Улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын зүгээс агаарын тээврийн салбарт хамтран ажиллах талаар өмнө нь удаа дараа хүсэлтээ илэрхийлсээр ирсэн бөгөөд Монгол Улсад ОХУ-ын Ерөнхийлөгч Путины албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж Монгол Улс олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсад агаарын түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон ОХУ-ын эрчим хүчний сайд Цивилев нар урьдчилсан байдлаар гарын үсэг зураад байна аа.

Энэхүү хэлэлцээр нь Монголын талд хуульд заасан дотоодын процедурыг хангаж зохих шийдвэр гарсны дараа үйлчилж эхлэх бөгөөд тус хэлэлцээрт агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлт, татварын тогтвортой байдалтай холбоотой заалтууд орсон байх тул Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцүүлэн шийдвэрлүүлж холбогдох шийдвэр гаргуулах шаардлагатай байгаа юм аа. Оросын Холбооны зүгээс энэхүү 2 хэлэлцээр хамтдаа хүчин төгөлдөр үйлчлэх талаар мэдэгдсэн бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангахын тулд Монгол Улсад Агаарын түлш нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг төслийг танилцуулж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Хишигдалай, ГХЯ-ны Гэрээ эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Соёлмаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Ганбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх Өлзийбүрэн.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Батболд гишүүнээр тасалъя. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Р.Сэддорж: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Л.Соронзонболд: Эхлээд нэг танин мэдэхүйн шинж чанартай нэг асуулт байгаа юм. Энэ ТС-1, Жет-А гээд ийм 2 төрлийн шатахуун оруулж ирдэг юм шиг байгаа юм. Тэгээд гол нь энэ манай Чингис хаан ОУНБ-ын энэ агуулах сав нь болохоор өөр төрлийн 2 төрлийн шатахуун агуулах сав байж болдог уу гэдэг нь өөрөө ер нь цаашдаа энэ шатахууныг чинь өртгийг нь улам нэмэх юм биш үү гэдэг нэг асуулт байна. Тэгэхээр энэ тал дээр ер нь цаашдаа бид нар ямар бодлого барих юм бэ? Ер нь энэ Эрчис Ойл гээд компани чинь 2 улсын 50, 50 хувийн хөрөнгө оруулалттай компани уу? Нэг ийм асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. ОХУ-аас нийлүүлдэг онгоцны түлш ТС-1 маркийнх БНХАУ-д байдаг онгоцны түлш Жета маркийнх. Тэгээд энэ одоо Чингис хаан нисэх онгоцны буудал дээр одоогийн байдлаар энэ цэнэглэх энэ гидрант систем дотроо бид нар одоогоор 100 хувь импортоор авч байгаа ОХУ-ын ТС-1 маркийн шатахуунаар цэн цэнэглэгдчихсэн байгаа. БНХАУ-аас цаашдаа бид нар авах бодолтой байгаа. Мөн 2028 онд орох манай дотоодын газрын тос боловсруулах үйлдвэр жилдээ нэг 80 орчим мянган тонн агаарын хөлгийн түлш үйлдвэрлэх юм. Тэгэхээр бид бүхэн энэ хүртэл хугацаанд ОХУ-аас агаарын хөлгийн түлшээ авч байгаа болон цаашид авна. Мөн БНХАУ-тай авах асуудал дээр бид нар төмөр замын царигийн асуудал өөрөөр хэлбэл Замын-Үүдээр орж ирлээ гэхэд одоо вагон цистернийг сольж ачих, дээрээс нь тэнд буулгаад авлаа гэж бодоход тэнд зориулалтын вагон цистерн байхгүй байгаа.

Яагаад вэ гэхлээр агаарын хөлгийн түлш өөрөө маш тийм одоо найдвартай, аюулгүй орчин шаарддаг маш их дамжуулах вагон цистерн болон тэр системүүдийн цэвэр орчныг шаарддаг. Ийм нөхцөл шаарддаг байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар одоохондоо бэлэн байхгүй байгаа гэдгийг хэлье. Ирчис Ойл компани бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 100 хувийн хувьцаатай Монголын төрийн 100 хувийн компани байгаа гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууна.

Р.Батболд: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Ер нь яах вэ үйлдвэрлэгчтэй нь хамтарсан компани байгуулах гэж байгаа болохоор нэг талдаа зөв байж болох юм уу ер нь зөв байх л гэж бодож байна. Зүгээр энэнтэй холбоотой 2 л асуулт асуух гэсэн юм.

Нэгдүгээрт бид нар энэ 20 жилийн хугацаатай гэрээ байгуулах гээд байх шиг байна. Энэ хугацаандаа үнэ нь тогтвортой байж чадах уу гэдэг асуудал байгаа юм. Тэртээ тэргүй нэгэнт үйлдвэрлэгчтэй нь хамтарсан компани учраас.

Хоёрдугаарт энэ нисэх дээр байгаа нөгөө агуулах маань хэний мэдэлд байгаа вэ, юу төлөөд байнгын нөгөө нэг түрээс төлөөд явах юм уу эс үгүй бол Эрдэс ойлынхоо өөрийнх нь нэр дээр байна уу гэдэг ийм 2 асуудал.

Р.Сэддорж: 3 номер хариулт.

Ц.Туваан: Батболд гишүүний асуултад хариулъя, дэмжиж байгаад баярлалаа. Тийм 20 жилийн хугацаатай гэрээ байгуулахаар яригдаж байгаа. Энэ бол нөгөө үйлдвэрлэгч оронтой байгуулна. Бид бүхэн түрүүн миний үгэнд гарсан өнгөрсөн оны намар ОХУ-ын Ерөнхийлөгчийг ирэхэд энэ газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээрийг байгуулж гарын үсэг зурсан. Мөн дагалдуулж агаарын хөлгийн түлш нийлүүлэх хэлэлцээр дээр гарын үсэг зурсан байгаа. Тэгэхдээ 1 нөхцөлтэй өөрөөр хэлбэл нөхцөл нь энэ хэлэлцээр Улсын Их Хурлаар орж батлагдсан өдрөөс хойш хэрэгжихээр заасан байгаа. Тэгэхээр энэ 2 хэлэлцээр бол мөн миний үгэнд гарсан тэр хоорондоо хамааралтай буюу оросоор пакетна гээд яг хамт явахаар ийм байдалтай зурагдсан байгаа.

Тэгээд өмнө нь бол бид нар ОХУ-аас шатахуунаа авдаг хангаж ирсэн боловчиг яг ийм Засгийн газар хоорондын хэлэлцээргүй явж ирсэн. Энэ нь бол манай улсын нефть бүтээгдэхүүний импорт дээр үе үе энэ ОХУ-ын гадаад бүтээгдэхүүний экспортын хоригтой холбоотой асуудлууд үүсэж ирсэн. Тэгэхээр эндээс гарахын тулд бид бүхэн энэ хэлэлцээрийг байгуулсан. Өмнө нь төр засгийн удирдлагуудын түвшинд санамж бичиг, гэрээ, албан ёсны уулзалт болгон дээр энэ асуудлууд хөндөгдөж ирсэн. Тэгэхээр энэ хэлэлцээрийг байгуулснаар үнийн тогтвортой байдал хадгалагдана гэж үзэж болно.

Өнөөдрийн байдлаар гэхэд манай дээр Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал дээр нэг тонн онгоцны түлш 3.5 сая орчим төгрөгөөр өртгөөр цэнэглэгдэж байгаа. Энэ бол ОХУ Москвад 900 гаран доллар, мөн Бээжинд 900 гаран доллартой дүйцэхүйц бага зэрэг үнэтэй байгаа ийм үнэ байгаа гэдгийг хэлье. Цаашдаа үнэ тогтвортой байх асуултыг бид нар ярина. Нисэх дээр байгаа байгууламжийг саяхан юунд Эрчис Ойл компанийн мэдэлд ТӨХ-ны шийдвэрээр шилжүүлж Эрчис ойл компанийн дотор орж ирсэн гэж ингэж ойлгож болно. Тэгэхээр ямар нэгэн түрээс төлөхгүйгээр энэ байгууламж төрийн мэдэлд ирсэн гэж ойлгож болно. Энэ компани байгуулсан тохиолдолд хамтарсан компани байгуулсан тохиолдол ямар нэгэн хөрөнгө эзэмшлийн асуудал байхгүй. Энэ дээр ашиглагдаж байгаа энэ системийг энэ компанид түрээслэх байдлаар ашиглах юм гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Энэ гэрээг нэлээн сайн үзсэн. 20 жилийн хугацаатай тэгээд нэлээн их үүрэг хүлээчихсэн. Яг ингээд асуудал үүссэн ч гэсэндээ манай биш нөгөө талын Арбитраар шийдэхээр нэг бизнесийн гэрээ ч юм шиг, улсын хэлэлцээр ч юм шиг нэг иймэрхүү л гэрээ байна лээ дээ. Тэгээд яах вэ нөхцөлүүд нэлээн хатуу тэгээд эргэлзэж байгаа юм нэг ийм байна. Туваан сайдаа энэ өмнө явж байсан ажил байна болоод л яваад байсан ямар нэгэн байдлаар.

Хэрвээ 20 жилийн хугацаатай ийм гэрээ хийчих юм бол угаасаа яах вэ авч байгаа газар нь нэг юм шиг боловч цаашдаа Монгол Улсын хувьд өөр газраас түлш авах, авах талаар бодох тэр талын чадавхыг бүрдүүлэх, энэ чинь 20 жилийн хугацаанд юу ч гарч болно шүү дээ. Тэр бүх юмыг ингээд хаачхаж байгаа

байхгүй юу. Тэгээд энэ нь ингээд бодлогын хувьд зөв юм уу? Монгол Улс ингээд бүх юмаа ингээд хайрцаглаад хайрцаглаад тэгээд ингээд явах нь зөв юм уу? 1 дүгээрт бодлогын хувьд, яг ингээд бодлогын хувьд.

Хоёрдугаарт яг ингээд өгөөж гээд байна л даа. Өгөөж дээр нь яг энэ гэрээн дээр бол ингэсэн байна. Тасралтгүй, тогтвортой, саадгүй гэсэн байгаа байхгүй юу. Нөгөө үнэ хямд ямар нэгэн давуу тал тийм санхүүгийн талаар байхгүй байна. Тэгээд энэ талаар лавлах гэсэн юм. Үнэ буурах юм уу үгүй юу? Яг нөгөө энэ түлшний үнэ. Тэгээд түлшний үнэ чинь миний ойлгож байгаагаар тийзний үнэ болон нисэх авиа компанийн онгоцны зардал бол их жинтэй хувь нэмэр эзэлдэг гэж ойлгож байгаа. Тийм болохоор түлшний үнэ хэрвээ ингэж үнэхээр бууж чадах юм бол тийзний үнэд яаж нөлөөлөх юм? Тэгээд нөгөө жуулчин гээд танилцуулга дээр баахан юм дурдчихсан байна лээ. Жуулчны нөгөө урсгал, МИАТ-ийн ч юм уу бусад компанийн өртөгт яг яаж нөлөөлөх юм. Энэ тооцоо байгаа юу? Яг энэ тооцоо бол хямд гэсэн нэг үг л байна лээ. Тэгэхдээ яг хэдээр хямд, хямд нь тэгээд гэрээндээ байхгүй зүгээр нэг эргэлзээтэй байгаа асуудал нь ингээд яахад саяын тэр тодруулах юм бол яг өгөөж нь юу байх юм бэ? Санхүү талаасаа. Түлшний үнэ буурах юм уу, буурахгүй юм уу? Буурвал хэдийн үнэ буурна гэсэн тооцоо байгаа юм.

Эсвэл зүгээр найдвартайг л хангаж байгаа юм уу?

2 дугаарт түлшнээс хамаараад баахан дурдчихсан байгаа тэр тийзний үнэ буурах хэсэг дээр яг яг ямар тооцоо байгаа юм бэ? Хэрвээ энэ ингээд урт хугацаандаа хямдрахгүй юм бол ийм хатуу гэрээтэй бусад эх үүсвэрээ бүгдийг нь хаагаад ийм гэрээ хийх нь зөв юм уу? Ийм асуулт байна аа.

Р.Сэддорж: 3 номер.

Ц.Туваан: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Бид нар бол нефть бүтээгдэхүүнийхээ импортын 96 хувийг ОХУ-аас авч байгаа. Урьд нь ч авч ирсэн, одоо ч гэсэн аваад явж байгаа. Одоохондоо бид нарт бол өөр сонголт байхгүй. Агаарын хөлгийн түвшин дээр 100 хувь авч байгаа. Тэгэхээр яг өнөөдөртөө бол бид нарт Монгол Улсын нөхцөл байдал яг л ийм л байна байгаа байдал маань. 20 жилээр гэж ярьж байгаа. Тэгэхээр бид бүхэн энэ хугацаанд 1 дүгээрт мэдээж үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Бид нар бензин тасалдахад юу болдог билээ. Уржнангийн уржнан болох гэж байна 2023 оны зудны үеэр бензиний асуудал үүссэн. Энэ үе дээр бол одоо шагийн бензин ч олдохоо больсон ийм нөхцөл байдал үүссэн. Тэгэхээр бид нарт 1 дүгээрт хангамж бол маш чухал гэдгийг хэлье.

Өгөөжийн хувьд мэдээж өгөөж байлгүй яах вэ. Энэ бид нар тогтвортой урт хугацаанд найдвартай өөрөөр хэлбэл Монгол Улсын газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад ортол болон түүнээс хойш ямар нэгэн асуудал үүссэн ч гэсэн энэ асуудал яригдаад явна. Бид нар бусад компаниудыг 100 хувь монополоор хаасан юм байхгүй. Гэрээн дээр бол 75 хувь гэж одоогийн байдлаар орчихсон ингээд явж байгаа. Үнийн хувьд бол бид нар өрсөлдөхүйц үнэтэй байгаа. Өнөөдөр нийтдээ нэг 90 хувийг нь энэ Эрчис ойл компани хариуцаад арваад хувийг нь хувийн хэвслүүд хариуцаад явж байгаа агаарын түлшний?

Тэгэхдээ ОХУ-аас үнийн хувьд бол 800-аас сая төгрөгийн зөрүүтэй. Өөрөөр хэлбэл Эрчис ойл компанийн цэнэглэж байгаа агаарын түлш тонн тутамдаа 800 мянгаас сая төгрөгөөр хямд байгаа гэж ингэж ойлгож болно. Үнэ буух уу гэдгээс илүү ер нь үнэ боломжийн хямд байгаа.

Дээрээс нь энэ хэлэлцээр Их Хурлаар орж байгаа учраас энэ дээр ямар нэгэн байдлаар цаашдаа Монгол Улсын хууль тогтоомжоор ямар нэгэн татварын бусад нэмэгдүүлэх нөхцөл хүчин зүйл үйлчлэх юм бол тогтвортой байх гэсэн энэ заалтын хүрээнд Улсын Их Хурлаар орж ирж байгаа гэдгийг танд хэлье ээ.

Р.Сэддорж: Найдлаа гишүүн тодруулж асууя.

Б.Найдалаа: Юуны хувьд энэ яах вэ танилцуулга дээр баахан юм дурдсан байна лээ л дээ. Тийзний үнэ хямдрах нөхцөл бүрдэнэ гээд. Энэн дээр зүгээр тооцоо байдаг юм болов уу?

Хоёрт нь зүгээр миний санаа зовж байгаа энэ чинь 20 жилийн хугацаатай гэрээ. 20 жилийн хугацаанд юу ч болж болно. Нөгөө нефтийн үйлдвэр гээд дурдчихъя. Нефтийн үйлдвэр ашиглалтад орж болно. 20 жил арай хүлээхгүй байлгүй дээ. Өөр юу ч болж болно шүү дээ. Тэгээд энэ хоорондоо ингээд шууд үнэхээр хямдарсан сүртэй тийм үнийн хямдралыг баталгаажуулж чадахгүй юм бол ийм том гэрээтэй ингэж айхтар орох хэрэг байгаа юм уу гэсэн зүгээр зарчмын л асуулт байна л даа энийг. Тийзний үнэ.

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Туваан сайд.

Ц.Туваан: Энэ агаар хөлгийн түлшний үнэ тийзний үнийн 36 хувийг бүрдүүлж байгаа. Өөрөөр хэлбэл тэгэхээр энэ гишүүний асууж байгаа санаа зовниж байгаа маш зөв асуудал. Бид нар сүүлийн үед маш огцом нэмэгдээд жилийн хэрэглээ маань 70 мянган тонн хүрчихсэн байгаа. Энэ цаашдаа ч нэмэгдэнэ. Зорчигч тээвэр, агаарын хөлгөөр зорчигч тээвэр бас маш огцом нэмэгдэж байгаа. Энэ аялал жуулчлалтай ч холбоотой, эдийн засгийн бусад асуудлуудаас болоод. Тэгэхээр бид нар энэ дээрээ 1 дүгээрт үнэ бас өнөөдрийн нөхцөл байдлаар би түрүүн хэлсэн. ОХУ-ын Москва Хятадын Бээжин 2-оос үл ялиг л дээгүүр байгаа. Тэгэхээр бид нар энэ үнээ бол ер нь энэ түвшинд нь нэмэгдүүлэхгүйгээр хадгалж явах эхний зорилго байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь тэр бид нар бас нэг одоохондоо газрын тос боловсруулах үйлдвэрээ ашиглалтад ортол импортлогч оронтойгоо ямар нэгэн байдлаар асуудалгүйгээр.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учраас Найдалаа гишүүн нэг минут.

Б.Найдалаа: Зүгээр энэ тодорхой асуулт биш юм даа. Зүгээр зангидаад зүгээр сарничихсан байж магадгүй. Би бол ингэж бодоод байгаа юм. Ийм их олон 20 жилийн хугацаатай ийм их энэ гэрээг унших юм бол маш их үүрэг манай тал хүлээчихсэн байгаа та бүхэн уншаад үзээрэй. Тэгээд энэнийх нь хариуд зөвхөн найдвартай тогтвортой гэх хангалтгүй санагдаж байгаа байхгүй юу. Ямар нэгэн

байдлаар эдийн засгийн өгөөж байж байж яг нэг компанид ийм монопол өгч байгаа зүйл болчхож байгаа байхгүй юу. Төрийн өмчит компани хувийн өмч нь хамаагүй шүү дээ. Тэгээд энэнийх нь хариуд яг Монгол Улс иргэд яг эдийн засагт ямар нөлөө үзүүлэх юм бэ? Хэрвээ шатахууных нь түлшний үнэ хямдарч чадахгүй юм бол ядахнаа 2 хөрштэйгөө ижилхэн хүнтэй байж чадахгүй юм бол тэгээд тийзний үнэд бодитой нөлөөлөхгүй юм бол ингэн ингэн үүрэг хүлээж ийм урт хугацааны гэрээнд орох хэрэг байгаа юм уу л гэсэн асуулт байгаа байхгүй юу.

Р.Сэддорж: Туваан сайд хариулт. 3 номер.

Ц.Туваан: Бид нар бол нэг сумаар 2 туулай буудаж байгаа гэж ойлгож болно. Тэр нь юу вэ гэхээр агаарын нийт Монгол улсын хэрэглэж байгаа нефть бүтээгдэхүүний 97 хувь нь бол нөгөө манай хэрэглэдэг Аи-80, Аи-92 дизелийн түлш байгаа. 2.6 хувь нь л агаарын хөлгийн түлш байгаа. Тэгэхээр энэ 2 гэрээ хоорондоо холбоотой буюу хамт гэж ойлгогдож байгаа нь бид нар энэ асуудал дээр тодорхой зөвшилцөлд хүрээд хангамж нийлүүлэлтээ хангаж байгаа боловч нөгөө талаараа энэ нефть бүтээгдэхүүн дээр өмнө нь байгаагүй хэлэлцээр зурснаар ОХУ-д ямар ч онцгой нөхцөл үүссэн бай тэрэнд Монгол Улс үл хамаарч нефть бүтээгдэхүүнээр 100 хувь хангагдана гэдэг ийм логик давхар явж байгаа.

Дээрээс нь бол бид нар л маш хямд үнээр буюу өнөөдрийн байдлаар 2380 төгрөгөөр жижиглэнгийн үнэ Аи-92 маркийн шатахуун хэрэглэж байгаа. Дизелийн түлш дээр гэхэд л 3060-аас.

Р.Сэддорж: Туваан сайд гүйцээгээд хариулчихъя. 3 номер.

Ц.Туваан: Тэгэхээр жижиглэнгийн үнэ дээр нэлээн хямд түлш бензин хэрэглэж чадаж байгаа, бөөний үнэ ярих юм бол бас нэлээн буураад явчихна. Тухайлах юм бол дизель түлш дээр гэхэд өнөөдрийн байдлаар нэг тонн нь 2 сая 650 мянган төгрөг байгаа. 4 сарын 20 хэднээр бид нар дахиж хэлэлцээр хийнэ. Энэ нь болохоор юу гэхээр нөгөө өвлийн түлшийг хаврынхаар солигдоод ирэхээр дизель түлшний үнэ дахиад 150-аас 200 төгрөгөөр буух ийм нөхцөлтэй байгаа.

Р.Сэддорж: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Агаарын хөлгийн түлш гэдэг нэг ийм энгийн дүү нэртэй энэ нэг айтхар л хууль харагдаж байна л даа. Ингээд уншаад үзэхээр. Монгол Улсын хувьд гуравдагч хөрш гэдэг өөрөө асар чухал. Гуравдагч хөрш рүү гарах үндсэндээ ганц зам маань агаарын зам байдаг. Тэгэхээр энэ гэрээг ингээд гэрээ хэлэлцээрийг харахаар агаарын орон зайгаа бас нэг гаднын нэг улсад тэр тусмаа ТӨК-д хэт давуу гэрээгээр ингэж гэрээ хэлэлцээр хийх гэж байгаа ийм л нөхцөл байдлууд харагдаад байна л даа. Эндээс би Туваан сайдаас нэг ганц 2 зүйл асууя. Түрүүнд хариултууд дээр гарч байх шиг байна. Тэгэхдээ би энэ хэлэлцээр дотроос олж хараагүй зүйлүүдийг жишээ нь нэг компани давуу эрхтэй ингээд 20 жилээр гэрээ хийгээд өгчих юм байна өөр газраас үнэтэй ч гэсэн хэрвээ тасалдвал үнэтэй ч гэсэн өөр газраас авах, магадгүй урд хөршөөс ийм бензин шатахууныг авах боломж бололцоо түрүүн та нэг 75 хувь энэ тэр гээд

хэлэх юм. Яг энэ гэрээ хэлэлцээр дотор чинь тийм тоо байсангүй. Тэгээд яг хэдийн хэд дээр байгааг хэлж өгөөч? Энэ чинь ингээд нэг ийм хэт нэг улсын агаарын орон зайгаа хэт нэг улсын монополд аваачаад өгчих гэж байгаа юм биш биз дээ. Одоо энэ төмөр зам гээд урагшаа хойшоо гарсан төмөр зам дээрээ бид нар өөрчлөлт шинэчлэлт хийж чадахгүй болчихсон сууж байгаа, бусдаас одоо ингээд хараат болчихоод сууж байгаа ийм нөхцөл байдалтай л байгаа шүү дээ. Тэгэхэд баахан түлш нь бусдынх тэгээд нэг ийм хэдэн онгоцны асуудал.

Агаарын орон зай маань үнэхээр нэг ийм бусдын монопол, бусдын ТӨК-ийн монопол руу орох гэж байгаа 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь дахиад та тэр манайх чинь нэг түүхий эдтэй ч билүү үгүй ч билүү. Нэг нефтийн үйлдвэр барина гээд байгаа. Тэндээс юм гарвал авна гэж хэлэх юм. Дахиад энэ гэрээн дээр чинь харин бараг тэрийг хаачихсан маягийн заалт харагдаж байгаа. Энэн дээр дотоодын үйлдвэрлэлийг нь хэрвээ бүтээгдэхүүн нийлүүлэлт олдвол тэр үед нийлүүлж болно ч гэдэг юм уу бараг тийм зүйл бараг алга. Энэ 4 дүгээр зүйлийн 5 дээр чинь Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоодын зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хуульд энэ хязгаарлалтууд үйлчлэхгүй байна гэнэ үү нэг ийм үг үсэг энэ дээр харагдаж байна. Харин тэр нефтийн үйлдвэрийн 100 мянган тонн бүтээгдэхүүн нийлүүлнэ гэсэн нэг тоонууд дээр үед харагдаж байсан. Онгоцны түлш гээд. Тэр бүхэн чинь энэнд бараг энэ гэрээ хэлэлцээрээр хаагдаж байгаа юм биш үү бараг.

Хоёрдугаарт нь би өөр газраас авч болох тухай яг энэ зүйл заалтаараа хэлж өгөөч гэсэн.

Хоёрдугаарт нь тэр дотоодын үйлдвэрийн чинь тухай яг та нарын ярьж байгаа шиг цаасан дээр бол ямар ч юм алга.

Гуравдугаарт нь Чингис хаан боодлыг цогцолбор гэж үзээд энэ хамтарсан компани нь энэ хамтарсан компанийн энэ цогцолборыг удирдах болон ашиглах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ ээ. Зөвхөн тэр дэд бүтэц биш бараг энэ Чингис Хаан зочид буудлын чинь удирдах зохицуулах үйл ажиллагааг энэ хамтарсан компани ашиглана гэсэн энэ 4.2 гэдэг заалтыг та нар хараач. Тийм утга тов тодорхой тийм утга л энэн дээр харагдаж байна. Тэгэхээр энэ чинь ерөөсөө энэ Чингис хаан буудлаа бүүр бараг онгоцны түлш биш энэ Чингис хаан буудлаа энэ хамтарсан компанид өгч байгаа юм биш үү?

Р.Сэддорж: Хариулт 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ хэлэлцээр байгуулагдсаны ар дээр хамтарсан компанийн асуудал яригдана аа. Монголын талаас Эрчис ойл, Оросын талаас Роснефть аеро гэдэг компанийн Монголын талын 60 хувьтай, ОХУ-ын 40 хувьтай ийм компани байгуулагдана. Энэ дээр нисэхийн цэнэглэх үл хөдлөх хөрөнгө тэр системүүдийг өмчлөх асуудал нэг ч байхгүй. Бүгдийг нь түрээсэлж түрээсийн төлбөр төлж ашиглана. ОХУ-ын талаас 40 хувьдаа нийлүүлэх шатахууны асуудал зарим нэг засвар үйлчилгээний асуудлыг оруулна гэдгийг хэлье. Энэ дээр гэрээн дээр байхгүй ч гэсэн өмнө нь 2022 оны 3 сарын 18-нд 2 улсын өндөр

дээд хэмжээний уулзалтын үеэр зурагдсан санамж бичиг дотор энэ энэ Роснефтьтэй хамтарсан энэ одоо агаарын хөлгийн түлш нийлүүлэх дээр 75 хүртэл хувь гэж байгаа юм. 25 хүртэл хувь нь өөр эх үүсвэрээс байж болохоор.

Энэ нь энэ хэлэлцээр дээр биш энэний өмнө байгуулагдсан санамж бичиг дээр байгаа гэдгийг хэлье. Мэдээж дотоодын бүтээгдэхүүн дээр энэ санамж бичиг дээр дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлээд гарч ирсэн тохиолдолд дотоодын талдаа давуутай байхаар заалт санамж бичигт орсон байгаа. Дотоодын манай үйлдвэр бүрэн хүчин чадлаар ашиглаж эхэлбэл жилдээ 80 мянган тонн агаарын хөлгийн түлш үйлдвэрлэхээр техникийн боломж байгаа гэдгийг хэлье. Энэ гэрээн дотор энэ Чингис хаан нисэх онгоцны буудал дээр байгаа энэ асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бол санаа зовох хэрэггүй. Бид нар Монгол хүмүүс. Энэ асуудал анх яригдаж эхэлсэн. Энэ хэлэлцээр зурагдсанаас хойш энэ асуудлыг маш нухацтай судалж үзсэн.

Монголын талд хүмүүсийн гишүүдийн санаа зовоод байгаа асуудал үүсэх юм биш байгаа гэж маш удаан нухацтай судалж үзсэн. Тэгээд энэ дээрээ ямар нэгэн тийм эрсдэл байхгүй. Энэ дээр Монголын талын компани хэрвээ асуудал үүсвэл 60 хувийнхаа хүрээнд зохицуулаад энэ компанийн удирдлагыг болон зорилтыг яаж зогсоох хүртэл арга хэмжээ авах ийм боломж үүснэ. Тэгээд энэ дээр тэр удирдах гэдэг зүйл, заалт дотор нь бол цэнэглэх энэ нөгөө нэг дотоод үйл ажиллагаа удирдах гэдэг ийм логикийн явж байгаа шүү гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Баярлалаа. Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Тэр дотоодын компаниас бүтээгдэхүүнтэй болсон тохиолдолд авна энэ тэр гэдэг дахиад өөр эх үүсвэрээс авч болно гэдэг энэ заалтуудыг чинь гол нь энэ албан ёсны хэлэлцээр дээрээ яагаад ордоггүй юм? Тэр нь нэг өөр урьд өмнөх баримт бичгүүд дээр тийм тоо байгаа. Энэ хэлэлцээр дээр гээд хамгийн гол зах зээлээ тодорхой хэмжээнд бас бид нар өөрийн бие даасан байдлаа хангах ганц ч заалт дотор чинь ерөөсөө байхгүй байна шүү дээ. Тэр нь өөр зүйл дээр байгаа. Энэ хэлэлцээр дээр бол байхгүй. Байгаа юм шигээр ингэж тайлбарлаж болохгүй шүү дээ бас. Тэгвэл яг хэлэлцээр дээрээ энэ саяын тэр зүйл заалтуудыг нэмж оруулах ёстой шүү дээ. Дотоодын бүтээгдэхүүн гарвал авна. Бид нар шаардлагатай бол үнэтэй ч байсан гадаад эх үүсвэрээс өөр эх үүсвэрээс тодорхой хэмжээнд авч болно гэдэг энэ нөхцөл байдал, ямар нөхцөл байдал үүсвэл.

Дахиад дээрээс нь сая тэр энэ хамтарсан компани нь нийлүүлэх хадгалах, цэнэглэх, борлуулах, хүргэх тээвэрлэх үйлчилгээг энэ компани хариуцна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ өөр эх үүсвэрээс авна энэ тэр гэдэг чинь энэ компанийн дэд бүтцээр.

Р.Сэддорж: 3 номер. Туваан сайд.

Ц.Туваан: Компани Монголын талын 60 хувь. Тэгэхээр та бас бизнес эрхэлдэг хүн мэдэж байгаа байх. 51, 49 гэдэг тоо яагаад байдаг юм бэ гэж. Тэгэхээр 51-тэй тал нь давуу талын шийдвэр гаргана л гэж ойлгоно шүү дээ. Бид нар 60 хувьтай компани байгуулна. Энэнтэй холбоотой асуудал үүсвэл

компанийн ТУЗ дээрээ энэ асуудлаа яриад хэлэлцээд шийдвэрээ Монголын талдаа гаргаад явна.

Дээрээс нь түрүүн хэлсэн нөгөө энэ Чингис хаан нисэх онгоцны буудлын асуудал дээр бол нэг ч тоног төхөөрөмж энэ тэр энэ компанийн өмчлөлд шилжихгүй. Энэний дээд талд байх Эрчис ойл компанийн мэдэлтэй буюу Монголын төрийн мэдэлтэй байна. Энэний доор нь энэ хамтарсан компани байгуулна аа. Таны түрүүний санаа зовсон тэр 75, 25 дотоодын үйлдвэрээс авах гэдэг асуудлуудыг гэрээ байгуулах үед онцгой анхаарч тусгаж ажиллая гэж хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Тэгээд Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тэгээд яг энэ гэрээ гэрээний 7 дугаар зүйл дээр байж байгаа юм. Энийг ингээд уншихаар энэ зөвхөн бүтээгдэхүүн нийлүүлэх урт хугацааны гэрээ төдий биш бүүр нэг манайх нэг гоёор хэлэхээр нэг тогтвортой байдал, татварын хөнгөлөлт чөлөөлөлт элдэв Монгол Улсын дараа нь Татварын хуулийн өөрчлөлт, аливаа тариф, аливаа зүйлийг энэ гэрээ хэлэлцээрийн түвшинд аливаа зүйлд өөрчлөлт оруулахгүй 20 жил энэ хөдлөхгүй ямарваа нэгэн Монгол Улсын энэ гэрээ хэлэлцээрт өөрчлөлт оруулах эрхгүй бүр ингээд маш тодорхой энэн дээр Монгол Улсын хууль тогтоомжид орж буй өөрчлөлтүүдийг ерөөсөө энэ гэрээ хэлэлцээрт тусгахгүй гэх зэргээр энэ хэтэрхий л ингээд нэг талыг барьсан эрх тэгш гэрээ биш, нэг талын нэг ийм тулган шаардлагыг нь баримт бичиг л яг зүй ёсоор л харагдаад маргаан гарвал Оросын арбитраар шийднэ. Ерөөсөө бүх зүйлд энд манай талын эрх ашиг гэдэг юм үнэндээ бараг нэг ч юм алга энэ дээр нь.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Би түрүүн бас энэний цаад талд нөгөө дам ашиг гэдэг шиг 97 хувийн нөгөө талын хамтарч хамт зурсан гэрээний асуудал байгаа гэдгийг хэлсэн.

Дээрээс нь энэ дотоодын эрх ашиг бид нар өмнө нь Петрочайна Дайчин Тамсаг компани дээр яг ингэсэн. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулчхаад л ард нь Татварын хууль өөрчлөөд л асуудал үүсчихсэн. Өнөөдөр тэднийхтэй хийн хоолойн асуудал яриад л явахад нөгөө та хэд тэр манай охины охин компанийн жижиг асуудал дээр асуудалтай гээд. Оюу Толгой дээр мөн адил. Сайн мууг нь мэдэхгүй тэгэхдээ энэ компанитай хөрөнгө оруулалтын гэрээ хийчхээд л ард нь Татварын хуулиа өөрчлөөд л тэгээд л тэрэн дээрээс дахиад асуудлууд үүссэн. Энийг чинь олон улсад харчхаад Монголчууд дандаа нэг ийм байдлаар тоглоод байна гэдэг утгаар л энэ нөгөө асуудал яригдаж байгаа.

Дээрээс нь энэ тийзний үнэ, шатахууны үнэ, агаарын хөлгийн түлшний үнэ тогтвортой байх гэдэг асуудал дээр чинь дахин дахин өөрчлөгдөөд нэмэгдээд байвал энэ тогтвортой байдал гэдэг асуудал чинь дахиад л.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: Ер нь Цогтгэрэл гишүүнтэй ер нь санал нэг байгаа юм. Би одоо ер нь эхлээд түүхээс нь асууя. Ер нь урьд өмнө энэ түлшний энэ ажлыг ямар компани хийдэг байсан юм бэ? Яг ямар шугамаар авч тендерээ ч юм уу авч хэрэгжүүлдэг байсан юм. Хэдэн жил хэрэгжүүлсэн юм гээд. Нэгд түүхийн эдийн хувьд энийг хэлж өгөөч гэж байгаа юм.

Хоёрдугаарт Орос Монголын ахиад нэг хамтарсан компани байгуулагдах юм байна л даа. Тэгээд энийг заавал ТӨК-аар хийхгүйгээр олон талын эх үүсвэрээс тийм хувийн хэвшлээ дэмжих чиглэлээр хийж болоогүй юу? Тэгээд бид нар бүх юмыг төр авч хийнэ гэдэг зүйлээсээ ангижрах ёстой л гэж би үзэж байгаа юм. Тийм учраас энэ заавал ТӨК хувийн хэвшилдээ итгэдэггүй нэг тийм сонин юм гарч ирчих гээд байгаа юм л даа. Тэгээд энэ хувийн хэвшлээр хийлгэвэл яасан юм бэ гэсэн ийм 2 дахь санал байгаа юм.

Ер нь Монголд баригдаж байгаа тэр нефтийн үйлдвэр чинь энэ түлш хийх юм уу, хийхгүй юм уу? Тэр ер нь яг ямар учиртай үйлдвэр юм бэ? Зүгээр үзэсгэлэн юм уу? Ямар учиртай юм? Тэрийг бид нарт хэлж өгөөч ээ. Ер нь бол онгоцны түлш мэдээж стратегийн том бүтээгдэхүүн байх. Гэхдээ болж өгвөл олон эх үүсвэрээс олон талаас зах зээлийн горимоор ингэж авдаг байвал нэг улс маань нэг өдөр нөгөө онгоцныхоо түлшийг чи ер нь дургүй хүргээд бай би чамд өгөхгүй гэвэл яах вэ? Тийм.

Тэгэхээр хэдүүлээ нэг ийм 2, 3 талтай харилцаатай дээр нь хувийн хэвшлээрээ тийм уян хатан менежментийг хийлгэсэн ийм чиглэл рүү явбал яасан юм бэ л гэсэн надад ийм 3 асуулт байна. Энийг хариулж өгөөч.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд хариулна.

Ц.Туваан: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Өмнө нь хувийн хэвшил хийж байсан. Компанийн нэр нь Мэргэ ван тэгээд та бүхэнд сонсогдсон байх. Тодорхой асуудлууд шүүмжлэлүүд үүссэн онгоцны түлшний үнэ бол нэлээдгүй хэмжээгээр нэмэгдсэн. Марж маш өндөртэй болсон гэдэг асуудлууд үүсээд тэгээд тэр яриа хэлэлцээний дүнд энэ хуучнаар бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 100 хувийн хувьцаатай Эрчис ойл гэдэг компанийг байгуулаад явж байгаа. Энэ байгуулагдсан цагаас хойш онгоцны агаарын хөлгийн түлшний үнэ тогтворжсон.

Дээрээс нь өнөөдрийн байдлаар хувийн хэвшлийн борлуулж байгаа үнээс 800-аас сая төгрөгийн доогуур борлуулж байгаа гэдгийг хэлье ээ. Мэдээж хувийн хэвшлээ дэмжих бодлого байлгүй яах вэ. Тэгэхдээ бид нар энэ дээр нэг онцгой нөхцөл байдал дээр төрийн гэдэг зүйл байж, тогтворжуулах хангамж, аюулгүй байдал гэдэг асуудлуудаа төр нь аваад явах асуудал бас давхар байгаа гэдгийг хэлье.

Газрын тос боловсруулах үйлдвэр яг ид ажил дээрээ явж байгаа. 2028 оны эхний улиралд энэ үйлдвэр ашиглалтад орж эхний бүтээгдэхүүнээ нийлүүлнэ. Саяхан би Энэтхэгийн Элчин сайдтай уулзсан. Магадгүй бас 2027 оны сүүлийн хагаст бүтээгдэхүүнээ гаргах ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Саяхан

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос 12 гишүүнтэй ажлын хэсэг очиж ажилласан. Энэ дотроос манай Байнгын хорооны дарга энэ тэр очиж ажилласан. Тэгээд дүгнэлт бол нэлээн эерэг гарсан. Тэр нефтийн нөөцтэй холбоотой түүхий тосны нөөцтэй холбоотой асуудал бол цэвэр манай яамны хариуцах асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар нөөц хангалттай байгаа олборлож байгаа компаниудтайгаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж 1 сая 500 мянган тонн жил олборлох асуудал руу нэлээн өндөр түвшинд бид нар яриад явж байгаа гэдгийг хэлье. Тантай 100 хувь санал нэг байгаа. Энэ олон эх үүсвэрээс өөрөөр хэлбэл үндэсний аюулгүй байдалтай холбоотой бүтээгдэхүүн юмнуудаа бол ямар ч улс орон олон эх үүсвэрээс авах ийм эрмэлзэлтэй. Манай хувьд бол хоёрхон эх үүсвэртэй дээр нь дотоодын гээд гуравхан эх үүсвэртэй байгаа. Тэгэхээр энэ гурвууланг нь бүрдүүлэхийн төлөө манай яам бодлого гаргаж ажиллаж байгаа. ОХУ-аас одоохондоо 100 хувь байна. Дотоодын үйлдвэр орох цаашдаа бид бүхэн энэ урд хөршөөсөө тодорхой хэмжээний ялангуяа энэ дизель түлшээ авч уул уурхайн өмнө бүсэд говийн бүсэд байгаа уул уурхайнуудаа хангах гэдэг ийм бодлогыг боловсруулаад явж байгаа. Тун удахгүй энэ арга хэмжээ шийдэгдээд явна. Засгийн газар дээр энэ дээр бодлого гарна. Мэдээж энэ дургүй хүрээд гэнэт энэ юмаа олгохоо больчихвол гэдгийн эсрэг энэ 2 хэлэлцээр зурагдаж байгаа гэдгийг нэмээд хэлье ээ. Баярлалаа.

Р.Сэддорж: 4 номер нэмж хариулъя. Өөрийгөө танилцуулаад. 4 номер.

Ч.Хишигдалай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Газрын тосны БХЗГ-ын дарга Хишигдалай. Энэхүү хэлэлцээрийн эхлэл нь бол 2018 онд тавигдсан. Чингис хаан нисэх онгоцны буудал ашиглалтад орохтой зэрэгцээд шатахуун хангамжийг ямар эх үүсвэрээр нийлүүлэх вэ гэдэг асуудал яригдсан. 2018 онд Дорнын эдийн засгийн форум Володивосток хотод очсон. Тэр үед Монгол Улсын Ерөнхийлөгч болон холбогдох сайд нар хамтдаа очсон. Зам тээврийн сайд ОХУ-ын Роснефть компанитай уг шатахуун хангамжийн байгууламжийг шатахуунаар хангая гэдэг анхны санамж бичгийг үзэглэсэн байдаг. Түүнээс хойш төр засгийн тэргүүнүүд өндөр дээд хэмжээний уулзалт айлчлалын үеэр энэхүү асуудал байнга ярианы сэдэвт орж яригдаж их явж байсан.

Энэ 2022 онд байгуулагдсан санамж бичиг бол яг ОХУ, Украин улс хооронд өмнө нь бол Сод Монгол компанийн.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Би ингэж дахиж асууж өгье. Өмнө энэ онгоцны түлшийг ямар компани яаж нийлүүлж ямар арга замаараа энэ эрхийг авч эзэмшиж байсан юм бэ гэдэг асуултыг та бүхэн Монголын ард түмэнд хэлээд өгчих л дөө.

Р.Сэддорж: 4 номер тодорхой хариулъя.

И.Хишигдалай: Сод Монгол компанийн охин компани Мэргэ ван компани ОХУ-ын Роснефть компанитай хамтарсан компани байсан. Тухайн үеийн

Тендерийн тухай хууль дээр Буянт-Ухаа нисэх онгоцны буудал шатахуун нийлүүлэх эрхийг авч нийлүүлдэг байсан.

Р.Сэддорж: Хариулт тодорхой гүйцэд биш гэж үзэж байна. Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Тийм. Та хэд тэгээд нэг зоригтойхон хэлчхэж бай л даа. Энэ чинь хүмүүсээс мэдээлэл авах гээд байгаа. Хэн нэгнийг буруутгах гэж байгаа юм биш. Зүгээр энэ өмнө түүх нь ингэж ямар явсан юм бэ гэж асууж байгаа юм.

Хоёрдугаарт би та бүхэнд дахин нэг захиж хэлэхэд Орос Монголын хамтарсан олон компаниуд байгаа. Одоо жишээлбэл Монголын төмөр зам гэдэг компани руу бид нар төмөр замаа огтлох гээд огтолж чадахгүй байгаа шүү дээ. Нөгөө Оросын талаасаа нэг 49 хувь эзэмшигчээсээ зөвшөөрөл авах гээд авч чадахгүй явж байгаа шүү. Тэгээд дахиад ийм нэг Оросын компани байгуулах гэж байгаа юм байна. Би Оросын эсрэг үзэлтэн биш. Зүгээр эх орныхоо төлөө аль болох олон эх үүсвэрээс аюулгүй байдлынхаа төлөө та бүгд маань сэтгэж ажиллаасай гэж хүсэж байгаа.

Тийм учраас энэ онгоцны түлш дээрээ та бүгд маань олон эх үүсвэрээс дээр нь хувийн хэвшлээрээ дамжуулж төрийн ямар нэгэн тийм гар оролцохгүйгээр энэ ажлыг уян хатан зохион байгуулах талаас нь анхаарч өгөөсэй л гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Маш олон асуулт байгаа юм аа. Энэ тавхан нүүр гэрээ. Гэрээ ч биш 2 улсын хоорондын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгаа юм. Тавхан нүүр ийм баримт бичиг боловчиг маш том салбарын асуудлыг 20 жилээр зохицуулж байгаа ийм баримт бичиг ороод ирж байгаа юм аа.

Тэгээд 1 дүгээр ас асуулт дээр бол сая хүмүүс хариулт авлаа. Тэгэхээр өмнө нь энэ агаарын хөлгийн түлш нийлүүлдэг асуудлыг хувийн хэвшлийн зарчмаар, бизнесийн зарчмаар шийдвэрлэдэг байсныг Эрчис ойл гэдэг компани байгуулаад тэгээд одоо энэ агаарын хөлгийн түлшийг 100 хувь төр хариуцаж байгаа гэж ойлголоо. Энэ Эрчис ойл гэдэг компани хэзээ байгуулагдсан ямар учиртай вэ? Захирал нь энд байгаа юм уу? Цаашид ер нь энэ ямар ямар үйл ажиллагаа эрхлэх юм? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуултын хувьд болохлоор хувь эзэмших энэ хамтарсан компанийн хувь эзэмшил чинь энэ хэлэлцээр дээрээ байхгүй юм. Та нар амаараа 60, 40 гэж яриад байгаа боловчиг тэр хувь эзэмшлийн асуудал энэ хэлэлцээрт чинь тусгагдаагүй байна аа. Тэгээд тэрийгээ ямар ямар зохицуулалтаар яаж шийдэх юм бэ гэдэг асуудал.

Гуравдугаар асуулт энэ хамтарсан компани чинь болохлоор Чингис Хаан ОУНБ-ын дэд бүтцийг удирдах болон ашиглах эрх үүрэгтэй байх юм байна аа. Түрүүн нэг цухас дурдагдлаа. Энэ дэд бүтцийн өмчлөл ер нь хаана байгаа вэ?

Японтой хийсэн Японы талтай хийсэн гэрээн дээр ер нь энэ асуудал анхнаасаа яаж туссан байсан юм бэ? Цаашид одоо ингээд нэг ийм компани удирдах юм байна. Арынх нь асуудал. Чингис хаан нисэх буудалд агаарын хөлгийн түлш худалдах, үүнд нийлүүлэх, хадгалах, цэнэглэх, борлуулах, хүргэх, тээвэрлэх үйл ажиллагааг хамтарсан компани хийж гүйцэтгэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ хамтарсан компани чинь Эрчис ойл, Роснефтийн хамтарсан компани байна аа. Тэгэхээр Роснефть зөвхөн манайд бөөнөөр бараа нийлүүлээд зогсохгүй дотоодод бас нийлүүлэлт хийх, дотоодын жижиглэнгийн худалдаанд оролцох эрхээ энэ агаарын хөлгийн түлшний салбарт авчхаж байгаа юм байна гэж ойлгож байгаа.

Тэгээд бид нар мартаагүй байгаа шүү дээ. Бас хэд хэдэн онд ч билээ тэр жил Роснефть ерөөсөө энэ нөгөө бензиний зах зээлд ормоор байна. 100 колонк энэ тэр гээд л нэг бөөн хэл ам болсон. Тэгэхээр энэ агаарын хөлгийн түлш чинь бол хувийн хэвшил явж байгаад ер нь энэ онцгой нөхцөл байдал юм байна аа, болохгүй юм байна гэнгүүтээ төрийн компани оруулчхаж байгаа юм байна. Энэ төрийн компани Роснефтьтэй хамтарсан компани байгуулаад жижиглэнгийн зах зээл дээрээ хамтарсан үйл ажиллагаа явуулах юм байна.

Таван жилийн дараа та нар дахиж орж ирэнгүүтээ одоо ер нь энэ нөгөө бензиний асуудал чинь болохоо байлаа гээд ингээд яачих гэсэн тийм болгоомжлол яах аргагүй төрж байна аа. Энэ 4 дүгээр зүйлийн 5 дугаар заалт. Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаа нь Монгол Улсын дотоодын зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу.

Р.Сэддорж: Хариулт Туваан сайд 3 номер.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад хариулъя аа. Өмнө нь хувийн хэвшил хийж байсан. Тэр талаар сая Алдаржавхлан гишүүний асуултад хариулахдаа манай газрын дарга хариулсан. Роснефть гэж компани 2020 оны 1 сарын 8-ны өдөр байгуулагдсан. УУЯ-ны 100 хувийн хувьцаа эзэмшилтэй төрийн мэдлийн ийм компани үйл ажиллагаа явуулж байгаа. Захирал нь Баянмөнх гэж хүн байгаа. Хэлэлцээр дээр энэ 60, 40 гэдэг харьцаагаа бид нар бас түрүүний нөгөө Цогтгэрэл гишүүний асуултад хариулсан шиг энэ нөгөө санамж бичиг дээрээ байгуулчхаад явж байгаа. Тэгэхээр энийгээ компани байгуулах гэрээний асуудал дээрээ оруулж тусгаж өгье өө. Энэ харьцаан дээрээ бид нар тохирсон байгаа гэдгийг хэлье.

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал бол менежментийг нь Япончууд хийгээд явж байгаа. Мөн одоо энэ цэнэглэх түлшээрээ хангах энэ асуудлаа түрүүний хэлсэн тэр борлуулах хангах, түгээх энэ цэнэглэх асуудлуудаа хариуцаад явж байсан боловч буцааж санал тавиад энийг бид нар хийж чадахгүй юм байна гээд Монголын талд буцааж өгсөн. Энэнээс дараагаар тэр Мэргэ ван гэдэг компани тендерт шалгараад хийж байгаад больсон асуудал дээр нь бол түлшний үнэтэй холбоотой нэлээн марж гарч ирж байсан учраас энэ асуудлаас болиод энэ Эрчис ойл руу ингээд орчихсон.

Тэгэхээр одоо бол Японы талд бол ямар нэгэн өмчлөлийн юм байхгүй. Энэ хамтарсан компани байгуулсан ч гэсэн Эрчис ойллын мэдэлд одоогоор ирчихсэн байгаа. Энэ дэд бүтцийн асуудал дээр бол ямар нэгэн хувь эзэмшихгүй гэдгийг хэлье. Роснефть компанитай тэр жижиглэнгийн борлуулалттай холбоотой асуудал дээр Монгол Улсад нийлүүлж байгаа шатахууны 30-аас дээш хувийг нийлүүлж байгаа компани дотоодын жижиглэн борлуулалт хийхгүй гэсэн ийм заалт бид нар оруулж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ дээр бол тэр жижиглэнгийн нөгөө 100 ШТС энэ тэртэй холбоотой асуудал орж ирэхгүй. Онгоцны түлш дээр ерөөсөө 1 их тийм олон хувийнхан одоо өнөөдрийн 70 мянгын 10 гаран мянган тонныг нь хувийнхан оруулж ирээд борлуулж байгаа. Тэгэхдээ энэ дээр гол үйл ажиллагааг Эрчис ойл компани хийгээд явдаг. Эрчим ойл компани дээр орон нутгийн болон энэ дотоодын нислэгүүдийн цэнэглэлт юмнуудаа бол хийгээд явдаг гэж хэлье.

Сүүлийн асуултыг тодруулж асуусны дараа хариулчихъя.

Р.Сэддорж: 4 номер гүйцээж хариулъя.

Ч.Хишигдалай: Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-үүдэд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2-т заасны дагуу 30-аас дээш хувийг дангаар нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээл дээр өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харьяалал хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан агаарын хөлгийн түлшнээс бусад бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно гэж заасан байдаг. Энэ дээр бол зөвхөн агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай гэрээ гэж заагдсан. Бусдаар одоохондоо бол ямарваа нэгэн хязгаарлалт юм бол байхгүй байгаа. Энэ хэлэлцээрийн гол санаа нь бол шинээр хязгаарлалт, тариф, квот тогтоогдвол үйлчлэхгүй гэдэг л тийм тогтворжуулалтын зүйл заалтууд л орж өгсөн байгаа.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Тэгэхээр чинь энэ чинь маш олон зүйлийг тогтворжуулчхаж байгаа юм. Тэгээд энэ 4.5 чинь тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх гэдэг чинь наад 30 хувь чинь үйлчлэхгүй байх гэсэн нэг тийм хардлагыг төрүүлээд байна л даа. Дараа нь тэгээд жижиглэнгийн зах зээл рүү бусад бүтээгдэхүүн дээр орж ирэх магадлалтай. Орос ажилтнууд орж ирнэ гэж байна аа. Хэчнээн хүн орж ирэх асуудал яригдаж байгаа юм бэ? Тэгээд энэ нэг ийм зөвхөн агаарын түлш биш гэсэн нэг заалт яваад байгаа. Монголын тал нь Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага Монгол Улсын ААН-тэй байгуулсан гэрээний дагуу шаардлагатай хэмжээгээр газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэхэд ижил төрлийн газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлж буй Монгол Улсын хуулийн этгээд болон гуравдагч улсын хуулийн этгээдэд тавьдаг нөхцөлөөс дутуугүй таатай нөхцөлд үйл ажиллагаа явуулах боломжийг олгох энэ тэр гээд энэ яг ямар төрлийн боломж олгох гээд байгаа юм гэдэг асуулт байна. Тэгээд үнэ ер нь цаашид яаж тогтох юм бэ? Мөн цаашид манай улс ер нь энэ Чингис хаан олон улсын буудал дээрээ жета түлш ашиглах дэд бүтэц.

Р.Сэддорж: 3 номер хариулт.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ түрүүний тэр нөгөө нэг дэд бүтцийн удирдах энэ тэр гээд байгаа. Энэ бол нөгөө нэг энэ онгоцыг цэнэглэхэд ашигладаг талбайн дотор байрладаг гидрантын ийм систем байгаа юм. Энэ систем рүү одоо нөгөө авч оруулж ирсэн энэ хамтарсан компани оруулж ирсэн түлшээ одоо цэнэглэх, байрлуулах, тэгээд хадгалах гэдэг энэ асуудлуудыг удирдах гэдэг логигоор энэ дотор явж байгаа шүү гэдгийг дотор нь хэлье.

Гэрээ рүү энэний ар дээр гэрээ рүү орно. Тэр үедээ бид нар Оросын холбооны улсын иргэд ажиллах асуудлыг ярина аа. Тэгэхээр энэ дээр яг одоо танд тоо хэлж чадахгүй байна. Түрүүний хамгийн сүүлд хэлсэн тэр давуу эрх энэ тэр гээд энэ заалтууд бол мэдээж олон улсын гэрээ хэлэлцээр дотор байдаг үгнүүд байдаг заалтууд. Мөн одоо дэлхийн худалдааны байгууллагын хяналт доор байдаг энэ олон улсын хэлэлцээрүүд дээр байдаг заалтуудыг.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Үгэн дээрээ хэлчих юм уу? Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Жаргалан гишүүнээр тасалъя. Найдалаа гишүүн ирцийн дарааллаар.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгэхээр зүгээр яг энэ гэрээ энэ хэлэлцээрийг харахаар тодорхой зүйл бол яах вэ юунаас эхэлье. Ямар ч байсан ингээд энэ онгоцны түлш нийлүүлэлттэй холбоотой энэ асуудлыг хойд хөрштэйгөө яриад хэлэлцээр хийж байгааг дэмжиж байгаа юм. Гол асуудал нь асуулт нь ер нь энд эргэлзээд байгаа яриад байгаа зүйл нь юу вэ гэхээр энэ заалтууд чинь өөрөө шударга зөв Монгол Улсад хэрэгтэй цаг үеэ олсон юм уу үгүй юм уу гэдэг асуулт байгаа байхгүй юу. Танилцуулга дээр бол зөндөө гоё юм биччихсэн байна л даа. Бүр холоос нь хамаад өргөн уудам нутагтай гэж эхлээд маш их юм байна. Гэхдээ яг Монгол Улсад яг ямар ашигтай юм гэх юм бол хайгаад хайгаад олдохгүй байна аа. Тэгэхээр энэ заалтууд дээр бол би эргэлзэж байна.

Жишээлбэл одоо тэр гэрээний хэдийн хэд байлаа 4 дүгээр зүйлийн 4 дээр байна шүү дээ. Ингэсэн байна л даа. Чингис хаан нисэх буудалд агаарын хөлгийн түлш худалдах үйл ажиллагааг хамтарсан компани хийж гүйцэтгэнэ гэж байгаа. Тов тодорхой заачихсан байна шүү дээ. Нөгөө нефтийн үйлдвэр ашиглалтад ороод өөрсдөө бид нар түлш хийсэн ч гэсэндээ Чингис хаан нисэх буудал нийлүүлэхгүй, нийлүүлүүлэхгүй шүү дээ. Тэгээд энэ ингээд хаачхаж байгаа байхгүй юу. Тэгээд Буянт-Ухаад нийлүүлэх юм уу эсвэл өөр аймагт нийлүүлэх юм уу? Ингээд энэ чинь ингээд ийм том заалт ингээд явчихсан байхад бид нар ингээд санамсаргүй хайнгадуухан ингээд явуулж болохгүй. Энэ чинь 20 жил үйлчлэх гэрээ 20 жил үйлчилнэ гэж байгаа нь 20 жил үйлчлээд тэр чинээгээрээ ингээд бизнесийн харилцааг нь ингээд соёлыг нь тогтоочихно. Өөрөөр хэлбэл цаашдаа 200 жил ингээд явна гэсэн үг.

Тавдугаар зүйл дээр нь бас адилхан. Газрын тостой холбоотой бүх зохицуулалт энэ гэрээнд энэ харилцаанд үйлчлэхгүй гэсэн заалт байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарын нөгөө нефтийн үйлдвэр барьж байгаа хараат бус болох

тэрийг ердөөсөө байхгүй болгочихсонтой адилхан ийм хариуцлагагүй заалтууд энэ гэрээнд байна.

Хоёрт нь түрүүн гишүүд зөндөө хэлж байна. Монголын талаас асар их үүрэг хүлээчихсэн. Татварын бодлогын бүх заалтуудыг тогтворжуулчихсан хэрнээ хариуд нь бид нар авч байгаа юм юу вэ гэхээр тоймтой хариулт байхгүй байна. Авч байгаа юм нь тогтвортой гэнэ, тогтвортой. Би энэ дээр ингээд Туваан сайд яг энэ ажлын хэсгийнх нь зүгээр гишүүд ч гэсэн дээ зүгээр хэлэхэд тогтвортой байдал гэж байгаа нь үндэсний аюулгүй байдлын асуудал ердөөсөө биш. Тогтворгүй байх нь харин ч эсрэгээрээ бараг тусгаар улсын угаасаа үндэс нь орчин тогтворгүй байдаг тэгэхээр энийг хэтэрхий тогтвортой байлгахын төлөө байна гэж байгаа нь бид нар үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл явдал шүү. Ямар улс ямар хот тогтвортой байдаг вэ гэхээр бусдын муж юу ч боддоггүй ямар ч асуудалгүй тийм газар л тогтвортой байдаг. Тэгэхээр тогтвортой байдлыг хангаж байгаа нь үндэсний аюулгүй байдлыг хангаж байгаа гэж хэлж байгаа нь логик том зөрчилдөөн шүү гэдгийг анхаарна уу. Тийм болохоор энэ хэлэлцээр дээр хэлэлцээр байгуулахыг уг нь дэмжиж байгаа боловч яг тэр нарийн санхүүгийн тооцоо, яг үнэ нь хямдрах юм уу хямдрахгүй юм уу? Хямдрах гэсэн үг энэ дээр ерөөсөө байхгүй байна. Хямдрахгүй юм бол ийм хэрэг байгаа юм уу? Монгол Улсаас яг юу хүлээгээд өгч байгаа юм. Хариуд нь юу авч байгаа юм гэдгийг илүү тодорхой болгох хэрэгтэй юм байна. Тэгээд яг харахад бол хэлэлцээрийг дэмжиж байгаа боловч хэлэлцээр нь ийм тэнцүү бус яаран сандран оруулсан юм шиг санагдаж байна аа. Ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ Засгийн газар дээр нэг хэдэн хүн л үлдлээ л дээ. Нэг ажил хийдэг. Туваан, Учрал гээд нэг хэдэн хүн л хүнд асуудлыг барьдаг. Тэгээд нөхцөл байдал амаргүй байж байгаа. Энэ гадаад худалдааны байдал, үнийн тарифын нэмэгдсэн өөрчлөлтүүд, геополитикийн шилжилтүүд, худалдааны болон халуун дайны нөхцөлүүд гээд. Эдгээртэй уялдаатай байж байна гэдгийг нэлээн мэдээлэл хараад сууж байхад ойлгогдож байна. Бид яах вэ тэгээд мэдээж 2 том хөршийн голд байж байгаа улс. Хөрш улсуудтайгаа хэрхэн харилцах вэ? Гуравдагч хөршүүдтэйгээ хэрхэн эдийн засгийн болон бусад хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх вэ гээд асуудлууд яригдаж таарна. Өнөөдрийн энэ асуудал дээр яагаад ГХЯ-аас төлөөлөл оролцсонгүй вэ? Энийг бас анхаарах ёстой болж байгаа юм. Тэгээд энэ дээр ГХЯ ямар байр суурьтай байгаад байгаа юм? Энэ байр суурь ойлгомжгүй байна. Хэлэлцээрийг бол одоо дэмжиж байна.

Тэгэхдээ энэ дээр саяын гишүүдийн яриад байгаачлан анхаарах асуудлууд байна. Тэр үнийн болон бусад тогтвортой байдал гэж яриад байгаа асуудлуудын цаана юу байна вэ, нэг.

Хоёрт нь тэр хамтарсан компанийн хувь хэмжээ ямар байх вэ? Тодорхой болох асуудлууд шүү дээ. Тэгээд дээр нь тэр бид нар өөрсдөө түлшний үйлдвэртэй болно гээд байгаа. Түлшний үйлдвэр баригдаад ашиглалтад ороход тэндээс нэмэлт эх үүсвэр авах асуудлыг одоо энэ гэрээндээ нөхцөл болгож нэмж

оруулж болохгүй байсан уу гээд асуудлууд гарч байна. Үүнийгээ энэ чиглэлийн яам тодорхой болгох шаардлагатай. Ер нь энэ бол энэ Эдийн засгийн байнгын хороон дээр ч байдаг юм уу энэ Эрдэс баялаг аж үйлдвэрийн яамнаас нэг санал гаргаж ирээд энэ бид нар мега төсөл гээд баталчихсан. 2025 оны төсвийг баталчихсан. Харамсалтай нь энэ гадаад нөхцөл байдал амаргүйгээс болоод хүнд байдал руу очиж мэдэхээр байна. Нүүрсний үнэ өсөх үү? Гадаадын тарифын нэмэгдэлтэй холбоотойгоор манайд орж ирж байгаа энэ импортын бараа бүтээгдэхүүний үнэд яаж нөлөө үзүүлэх вэ гээд.

Энэнтэй холбоотойгоор энэ Эдийн засгийн байнгын хорооны гишүүн нэг хаалттай байдлаар энэ асуудлаа яримаар байгаа юм. Тэгэхгүй бол бид нар чинь нэг тийм Их Хурлын гишүүд хэдэн талаас суучхаад зарим нь ч мэдэхгүй ч юм байхгүй, чадахгүй ч юм байхгүй бүгдийг мэддэг маягтай болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг нэг хаалттай байдлаар нэг яримаар байгаа юм. Аюулгүй байдлын зөвлөл дээр бодвол ярьсан юм байлгүй. Тэгээд энэ Туваан сайд энд байгаа учраас танай салбарын чиглэлээр ямар ажлууд хийгдээд байгаа юм? Яг бодитой аль нь болох юм. Энэ үнийн тариф та нарт яаж нөлөөлж байгаа юм. Энэ ханшийн өөрчлөлт яаж нөлөөлж байгаа юм? Гадаад геополитикийн шилжилт яаж нөлөөлж байгаа юм? Хүйтэн худалдааны болон халуун дайны нөхцөл яаж нөлөөлж байгаа юм. Энэ байдал маань бид нарт байгаа энэ нөгөө том мега төслүүд бид нарын мөрөөдлүүд бид нарын энэ төлөвлөгөөнүүдтэй уялдах юм уу уялдахгүй юм уу? Бид нар ингээд очоод ярьдаг нэг их сүрхий сүрхий юм ярьчихаад энд хэдүүлээ 1 талд нь нэг Туваан ажлаа хамгаалах гээд, нөгөө талд нь бид нар нэг арьсыг нь хуулах гээд байгаа юм шиг суугаад байдаг. Тэгтэл энэ нөхрийн арьс ч хуулж дуусдаггүй нөгөө ажил ч урагшаа явдаггүй тэгээд ийм байдалтай байх гээд байдаг.

Сая тэр Евроазийн хэлэлцээрийн тухайд ч тэр нэг ийм Гантөмөр сайдын үгийг нэг сонсчих ёстой байсан юм. Ер нь тэгээд хэдүүлээ нэг хэдэн жилийн өмнө нэг арай өөрөөр нэг дуугарах асуудал байна. Энэ өнөөгийн нөхцөл байдал дээр бид нар ямар байдалтай дуугарах юм? Энийг нэг тэр аюулгүй байдлын талаас нь тэр эдийн засгийн тоо баримт талаас нь тэр, хууль зүйн талаас нь тэр яриад байгаачлан нэг сонсчихмоор байгаа юм. Тэгэхгүй бол бид нар чинь нэг бүгдээрээ нэг бүгдээрээ тийм мэддэггүй юмгүй мэргэн жараахайнууд болчихоод байна шүү дээ.

Тэгээд бүгдээрээ нэг тийм таалагдах гээд гарч ирээд ярьдаг. Тэгээд энэ байдлыг нэг Эдийн засгийн байнгын хороон дарга маань сайн анхаарч үзмээр байна. Энэ яам ч гэсэн энэ дээр нэг тийм хаалттай байдлаар мэдээллээ өгмөөр байна. Тэр зарим яамдууд мэдээллээ өгдөг юм байна лээ шүү дээ. Танай яам нэг ширхэг цаасгүй бид нарт тусгай байдлаар танилцуулж өгсөнгүй энийгээ анхаарч ажиллаарай гэж захих байна.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн үг хэлнэ.

Б.Жаргалан: Монгол Улс бол ямагт олон 100 жилийн туршид, олон мянган жилийн туршид энэ 2 хөршийн дунд одоо энэ сүүлийн үед гараад байгаа хэллэгээр амаргүй нөхцөл байдалд, амаргүй геополитикийн тэр орон зайд тусгаар тогтнолоо хадгалсаар ирсэн. Тэгээд энэ хугацаанд бол бид нар дандаа

л ийм хүнд шийдвэрүүдийг гаргадаг байсан. Тэгээд сүүлийн үед ямар зүйл ажиглагдаад байна вэ гэхлээр энэ Улсын Их Хурал дээр хамтарсан Засгийн газар байгуулагдчихсан учраас хамтарсан засгийнхаа бодлогыг дэмжээч гээд л. Тэгээд л нөгөө хэдэн сайд нарыгаа улалзуулаад л ингээд л ийм асуудлыг оруулж ирээд байгаа байхгүй юу. Мэдээж хэрэг ингээд эх орныхоо эрх ашигт хамааралтай зүйлүүд дээр бол бид нар тэрийгээ л бодно шүү дээ. Гэлээ гэхдээ яг ийм бүх зүйл тодорхойгүй горимд шилжчихсэн энэ олон улсын нөхцөл байдал ингээд ийм яг л одоо, өнөөдөр, маргаашаас өөр байх тийм нөхцөл байдал дээр ийм 20 жилийн гэрээ оруулж ирээд байх ер нь шаардлага байгаа юм уу? Тэгээд сүүлийн үед манай засаг болохлоор манай урд хөрш болохлоор 3-ыг цогцоор гэдэг бодлого барьж байна гээд л энийг л бид нар биелүүлэхгүй алдагдсан боломж ийм тийм гээд л яриад л дэмжүүлчихсэн.

Тэгэнгүүт одоо манай хойд хөрш болохлоор тэр юу билээ пакетнаа гэлүү тэгээд ийм бодлого барьж байна, энийг дэмжүүлэхгүй бол болохгүй гээд л оруулж ирж байгаа юм. Тийм тэгээд хамгийн гол нь ер нь бид нар нэг ийм бие даасан бодлогоо тодорхойлдог баймаар байна аа. Тийм зүйл яг үнэндээ харагдахгүй байгаад байна аа. Тэгээд дандаа нэг ийм нэг айдас хүйдэст автуулсан дандаа нэг ийм олон талаас шахалтад оруулсан байдал дээр. Тэгээд энэ Их Хурлаа ч гэсэндээ Засгийн газар нь шахаад хамтарчхаж байж та нар яах гээд байгаа юм энэ тэр гээд. Энэ чинь ингэж засаглалынхаа тэнцлийг алдагдуулж болохгүй шүү дээ. Энэ чинь засаг чинь ингээд тодорхой зүйлүүдийг бие даагаад хийгээд явах ёстой. Магадгүй энийг заавал ийм Улсын Их Хурлаар батлуулаад байхгүйгээр та хэд засаг дээрээ ч шийдэх боломжтой шүү дээ. Тэр нэг Эрчис ойл гэдэг компанийн чинь аль дээр шийдвэр гаргаад Засгийн газрын шийдвэрээр байгуулагдаад тэр үйл ажиллагаа явуулж байгаа юм байна.

Тэгэхээр энэ чинь бид нар нэг хяналт тэнцлээ авч үлдмээр байна шүү дээ. Тэгэхээр тиймэрхүү юмаа манай Засгийн газар жаахан бодмоор байна аа. Тэгээд энд мэдээж хэрэг эх орондоо хайргүй хүн ч гэж хаана байх вэ? Тэгээд хувийн хэвшлээ ч гэсэндээ дэмжихгүй хүн гэж байхгүй болчихсон байна. Тэгэхээр 1 иймэрхүү ээдрээтэй юмнууд оруулж ирээд тэгээд айлын талаас шаардсан нөхцөлүүдийг манай сайд нар өөрсдөө яриад тэгээд ийм 20, 30 жилийн л юм ярьж орж ирдэг боллоо. Тэгээд ер нь богино хугацаандаа бид нар 20, 30 жилээр аливаа зүйл дээр шийдвэр гаргаад байх шаардлагагүй гэж харж байна. Тэгэхээр та нар засаг дээрээ шийдэх боломжтой юмнуудаа засаг дээрээ шийд л дээ. Яагаад заавал бүгдийг нь ингээд Их Хурал руу барьж гүйгээд байгаа юм?

Заавал бүгдийг нь яагаад Засгийн газар хоорондын хэлэлцээр ийм бүүр ийм өндөр дээд түвшинд аваачаад байгаа юм? Тэгэхээр тэр зүйлээ нэг жаахан бодолцмоор байна хэдүүлээ. Тэгэхгүй бол энэ янзаараа маш хүнд асуудлууд яваандаа үүсэж магадгүй байхгүй юу? 20 жилийн дараа яс юман дээрээ энэчээ хэн байх юм? Та бид нарын хэн нь ч байхгүй байж болно шүү дээ.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Яах вэ зүгээр Монгол Улс агаарын хөлгийн түлшийг найдвартай нийлүүлэгчтэй болох асуудлыг зарчмын хувьд байнга эрэлхийлэх ёстой шийдэх ёстой. Тэгэхдээ энэ дан ганц нийлүүлэгчээс хамааралтай ийм

гэрээг Улсын Их Хурлаас оруулж ирж зөвшилцөж байгаад би ерөөсөө ойлгохгүй байна. Би Жаргалан гишүүнийхтэй яг санал нэг байна. Аж ахуйн юмыг аж ахуйн түвшинд нь шийдэж сур л даа. Ажил хийж байгаа нэртэй ийм тулгалтуудыг оруулж ирдгээ болимоор байна. Хэлэлцээр гэдэг чинь өөрөө ийм текст заавал байх ёстой юм байна гэж биш. Ийм Монгол Улсад давуу байдлыг бид нар олж авахын төлөө ингэж хэлэлцээр хийгээд ийм зүйлийг орууллаа гэдэг болохоос биш олон улсын ямар загвар гэрээнүүд дээр нэг ийм юм байдаг юм байна лээ гээд би Сайд таны яг энэд чинь үнэхээр харамсаж байна шүү. Энэ хэлэлцээр хийгээгүй байна шүү дээ. Танайхан ажиллаагүй байна шүү дээ. Би энэ Засгийн газрын түвшин дээр ХЗДХЯ-нд ажиллаж байхдаа энэ ураны хэлэлцээрийг та нарт бэлэн болгоод тавьж байсан юм. Нямбаатар сайдын үед.

Ганцмод-Гашуун сухайтын хэлэлцээрийг ямар нөхцөлтэй тавьж байсныг та мэднэ дээ. Одоо яаж батлуулснаа та мэднэ. Энэ арай хэтэрхий байна шүү дээ. Аж ахуйн юмыг аж ахуйн түвшинд нь шийдэж чадахгүй Улсын Их Хурал дээр одоо ингээд нэг ийм сонин нөхцөл байдал руу түлхэж оруулж ирээд зах зээлээ хаагаад ямар ч өрсөлдөөнгүй болгоод ийм зүйлүүд орж ирж байгаадаа зүгээр бодлогын хувьд ч юм уу энэ цаашдын зүгээр жишгийн хувьд жоохон гайхал төрүүлээд байна.

Түүнээс биш найдвартай энэ саплай чэйн янз бүрийн юман дээр асуудал алга. Тэгэхдээ мэдээж энэ хэлэлцээрийн цаана яг нэг саплай нэг нийлүүлэгчтэй болсноор цаашдаа үнэ тогтвортой байж чадах уу гэдэг эрсдэлтэй л юм байна. Бас тэгээд энийгээ бодно биз. Ер нь бол нэг нийлүүлэгч бол тэгээд хүссэн үедээ тоглолтоо гартаа авна шүү дээ. Энэ гэрээ хэлэлцээрийг бид нартай цуцлах талаасаа шахалт үзүүлээд эхлэхэд бид хэд өөр нөхцөл байдал руу л орно гэсэн үг.

Тэгэхээр би бол Туваан сайд би таныг ажил хийх гээд байгааг эрмэлзэж байгааг ойлгож байна. Одоо бас энэ зарим зүйл чинь үнэхээр та бол бас Улсын Их Хурлын хэдийг нэг ийм нэг уяач сэтгэхгүйгээр нэг аргалчихдаг юмаа, эд нарыг би нэг бүлэг бүлгээр нь уяад найрчихна гэж бодоод байна уу үгүй шүү дээ. Юманд жоохон ажил хэрэгч ханд л даа. Хэлэлцээр хийгээгүй байна шүү дээ. Энэ чинь Монголын эрх ашгийг хамгаалсан юм нэг ширхэг ч алга байна шүү дээ.

Бид хэд тэр чигтээ үүрэг хүлээчихсэн байна. Тэр чигтээ энэ бүтээн байгуулж байгаа нефтийн үйлдвэрүүдийнхээ бараа бүтээгдэхүүний борлуулах орон зай зах зээлээ алдчихсан байна шүү дээ. Жижиглэнгийн зах зээл рүү орж ирэхэд бэлэн болчихсон байна шүү дээ. Ийм зүйлүүдийг оруулж ирчхээд тэгэхдээ энийг жоохон бодолцоорой. Та дүрдээ хэт итгээд байх шиг байна. Ажил хийж байгаа ганц сайд энэ тэр гээд. Одоо болно за юу. Ядаж хэлэлцээрээ хийчхээд, асуудлаа зөв асуудлаа ярьдаг болчихоод. Аж ахуйн ажлуудыг ингэж оруулж ирээд Улсын Их Хурал дээр 2 компанийн юмыг шийдчихнэ гэх шиг. Та нар эсвэл асуудал байвал тэнд нь шийдээд яв л даа. Яагаад Монгол Улсын ганц энэ агаарын хөлгийн юуг бид нар найдвартай хийнэ гэснээс ийм бүх татварын болоод бусад юмнуудыг тогтвортой байлгах юмыг хийгээд байгаа юм.

Тэр түвшинд нь хэлэлцээрийг нь хийгээд 10, 20 жилээр авна гээд 2 компанийн хооронд гэрээг нь хийгээд л тэгээд л мөрдөөд яв л даа. Ийм байж

болохгүй ээ. Би зүгээр цаана нь асуудлууд байгаа гэдгийг ойлгож байна. Тэгэхдээ та нар Монгол Улсын эрх ашгийг хамгаалж хэлэх ёстой байхгүй юу. Бид асуудлыг чинь ойлгож байна. Хөршүүдтэйгээ бид хэд яг тэгш шударгаар бизнес хийхэд бэлэн байна. Энэ асуудлыг энэ хүрээнд нь ингээд шийднэ энэ гэрээгээ ингээд байгуулаад мөрдье. Яагаад юм болгоныг энд авчирч ингээд ийм жишиг рүү орчхов оо. Энэ чинь ерөөсөө болохоо байгаад байна шүү дээ. Тэгээд одоо наад Туваан сайдыг ч гэсэн зарим хүмүүс хөөргөдгөө боль. Ганц ажил хийж байгаа гээд. Ингэж ажил хийхгүй шүү, юу болж байгаа юм.

Р.Сэддорж: Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Бид нар улс төрийн хувьд ардчилсан замыг эдийн засгийн хувьд нээлттэй зах зээлийн замыг гэж сонгоод 30 гаран жил явж байна. Уг нь энийгээ алхам тутамд жилээс жилд батжуулж бэхжүүлээд л явах ёстой байх. Одоо тэгээд нөгөө тал руу бол ингээд эргэлт буцалтгүй явчихсан. Яг тэрний нэг жишээ орж ирж байгаа. Яг энэ хэлэлцээрийн төсөл улам өрсөлдөөнгүй болгоё. ТӨК-д монопол эрх олгоё одоо бүхий л энд байж болох хувийн хэвшлийн оролцоо нь бүр өчүүхэн ч орон зайгүй болгочихъё гэдгийг л баталгаажуулсан нэг ийм хэлэлцээрийн төслүүд ингээд орж ирж байна л даа. Энэ яалт ч үгүй энийг ингээд харахаар энэ манай үндэсний аюулгүй байдал энэ үзэл баримтлалд ч гэсэн энэ нийцэх эсэхийг энэ холбогдох хүмүүс нь ярилцаж байгаа байх. Энэ үнэхээр нийцэж байгаа юм уу? Энэ.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч гэсэн би нэг өгүүлбэрийг нь харж байна. Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж өрсөлдөөнийг дэмжинэ л гэсэн байна. Ирэх жилүүдэд. Нөгөө либералчлал нь өрсөлдөөн дэмжинэ гэдэгт чинь энэ бодлого Засгийн газрын бодлогод энэ нийцэх юм уу энэ одоо жишээ нь. Тэгэхээр энэ энэ асуудлууд дээр үнэхээр ярилцах, хэлэлцэх, дахиж нэмж мэдээлэл авах ийм шаардлагууд байна аа.

Тийм учраас АН-ын бүлгээс энэ онгоцны агаарын тээврийн түлшний асуудлаарх энэ хэлэлцээрийн төслөөс ажлын 3 хоногийн завсарлага авъя аа.

Байнгын хорооны дарга завсарлага өгөхийг хүсье ээ.

Р.Сэддорж: 3 номер Туваан гишүүн.

Ц.Туваан: Сайдын биш, Их Хурлын гишүүний бүрэн эрхэд байдаг Байнгын хороонд байхгүй ч гэсэн үгээ хэлэх ч гэсэн үгээ хэлэх боломжоо ашиглая. Энэ асуудал нь өөрөө манай салбарт байгаа юм. Нефть бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт энэ бусад бүх асуудлыг нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа учраас оруулж ирж байгаа юмаа. Тэгээд ажил хийсэн болж харагдах ч гэдэг юм уу иймэрхүү зүйл байхгүй ээ. Миний оронд хэн нэгэн та нарын хэн нь ч байсан очсон яг энэ асуудлыг барьж аваад л хийнэ. ОХУ-д нэг дрон нефтийн нэг агуулах дэлбэллээ гэхэд л тэр үед миний нойр хүрдэггүй. Яагаад вэ гэхээр тэрэн дээр бид нар, манай ОХУ-аас одоохондоо 96 хувь авч байгаа. Энэ дээр өөр ямар ч гарц одоохондоо байхгүй байна. Өмнө нь ийм гарц гаргалгаа гаргаагүй байна, одоогоор алга. Тэгэхээр бид нар одоо яах юм? Та хэд маань миний оронд байсан л тийм байх байсан.

Яагаад вэ гэхлээр энэ асуудлыг шийдээч гэдэг шаардлагыг тавина. Өмнө нь зудын үед 2023 оны өвөл өвлийн зудын үеэр нефт тасалдаад юу боллоо. Тухайн үед би хүртэл Ганбаатар сайдыг энэ асуудлаа шийд гээд л огцор гээд л юм яриад л явж байсан. Одоо зовлонг нь ойлгож байгаа. Тэгэхээр өөр газраас нийлүүлэх боломжгүй байгаа энэ юман дээр 1 дүгээрт яах юм бэ гэдэг асуудал байгаа юм. Тэгээд 1 сумаар 2 туулай буудаж байгаа гэдэг нь бид нар байгуулчихсан хэлэлцээр нь тогтвортой ханган нийлүүлэх ганцхан энэ агаарын хөлгийн түлш биш.

Агаарын хөлгийн түлш бол ерөөсөө хоёр арваны зургаахан хувь байгаа юм. Тэгэхээр нийт авч байгаа бид нар 2.6 сая тонн бүтээгдэхүүний асуудал энэ цаад талд нь дам давхар явж байгаа байхгүй юу даа. Тийм учраас би их нийлүүлэлт талдаа их ач холбогдол өгөөд байгаа юм. Саяхан ҮАБЗ дээр Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын зөвлөл дээр мөн өнгөрсөн 7 хоногийн 5 дахь өдрийн даргын зөвлөлийн хуралдаан дээр бид нар энэ асуудлаа танилцуулсан.

Түрүүн бас Батсүмбэрэл гишүүний асуулт юунд гарч байна үгэнд гарч байна. Бид хэд ч гэсэн Эдийн засгийн байнгын хороо маань яг ийм асуудлыг нээлттэй хэлэлцье гээд бид хэд бэлэн байгаа. Одоо дэлхий дээр ямар нэгэн тийм тогтвортой хуучин дэг жаяг горимоор явдаг нэг ч асуудал байхгүй болж байна шүү дээ. Тэгэхээр энэ үед бид нар яг найдвартай хангалт гэдгээ хийхгүй энэ асуудал шийдэгдэхгүй орхигдоод л бид нар ОХУ экспортын хориг тавилаа гэхэд л тэгээд л бүх асуудал хаана ирэх вэ? Нөгөө Тувааныг алж дүүжил энэ муу ярьж байхгүй яасан юм, юмаа шийдүүлэхгүй яасан юм гээд л дайрна. Миний оронд та хэдийн хэн нэгэн байсан ч асуудал хариуцсан сайд руу ингээд л ярина.

Тийм учраас энэ нэлээн чухал асуудал юм аа. Бид нар Их Хурал руу яагаад оруулж ирж байгаа юм гэхээр энэ өөрөө Засгийн газар хоорондын хэлэлцээр, дотор нь татварын тогтворжуулах асуудал байгаа учраас, Их Хурлын бүрэн эрхэд байгаа учраас оруулж ирж байгаа юм. Энэ хэрвээ засаг дээр шийдэх байсан бол бид хэд Их Хурал дээр ингэж оруулж ирээд асуудал болоод явахыг мэдээж бодохгүй. Энэ гэрээ байгуулж хэлэлцээр хэрэгжиж эхэлснээс хойш янз бүрийн үүссэн, татвар нэмэгдүүлэх ч байдаг юм уу, тарифын энэ тэр асуудал орж ирвэл гэдэг заалт байгаа учраас Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд энэ асуудал орж ирж байгаа шүү. Тэгээд та бүхнийг бас хэлэлцэн шийдвэрлээд өгөхийг хүсье.

Цаг хугацааны хувьд бол бас нэлээн асуудалтай байгаа гэдгийг хэлье ээ. Тэгээд ямар нэгэн дарамтлах Их Хурлын бүрэн эрхэд халдах, тэгээд өөрөө тодрох гэсэн асуудлууд байхгүй. Тэгээд цаашдаа анхааръя гэж хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Миний хувьд үгээ хэлье. Тэгээд 2028 онд нефть үйлдвэр ашиглалтад орно. Бид сая явж үзлээ газар дээр нь. Говийн бүсийн гишүүд энэ шалгах ажлын хэсэг Мөнхбаясгалан гишүүнтэй ахалсан ажлын хэсэг үзлээ. 800 Энэтхэг ажиллаж байна, 130 монгол хүн ажиллаж байна. Бүтээгдэхүүн нь бол гэрээний дагуу тоног төхөөрөмж бараа материал нь 2 сар далайгаар

тээвэрлэгдэж Энэтхэг улсаас ирдэг юм байна. Зарим нэг бүтээгдэхүүнээ бол 2 хөршөөс авдаг юм байна. Ингээд Засгийн газраас бол 2027 оны сүүлийн улиралд гэж шахаж байгаа юм байна. Яг төлөвлөгөө бол 2028 оны эхний улиралд гэж явж байгаа юм байна. Бид нар бол ашиглалтад орчих юм байна гэж итгэл найдвартай байгаа. Тэгээд энэ хэлэлцээрийг бол би ингэж ойлгосон. Тэр нефтийн бүтээгдэхүүн, нефтийн үйлдвэр ашиглалтад ороод онгоцны түлш гаргахад шууд энэ гэрээ онгоцны түлш дотоодын үйлдвэрээсээ авч эхэлнэ гэж ойлгож байгаа. Үгүй үгүй энэ дотор нь ийм заалт байгаа байхгүй юу.

Байгаа харин би өчигдөр энэ чинь ажлын хэсэгтэй би урьдчилж уулзсан юм. Энийг бол би тийм заалт байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд гишүүдэд энэ гэрээний танилцаагүй гишүүдэд энийгээ сайн танилцуулаарай.

Хоёрдугаарт нь бол өөр дараагийн эх үүсвэр жишээ нь БНХАУ-аас яг манай цэнэглэдэг онгоцнуудад тохирох түлшийг оруулж ирвэл бас энэ гэрээндээ оруулж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд энэ бол яалт ч үгүй л бид нар цаашдаа анхаарч 3 хоногийн завсарлага авч байна.

3 хоногийн завсарлага авч байна. Тэгээд цаашдаа бол энэ 3 хоногтоо энэ гишүүдэд тайлбарлаж ойлгуулж ингээд эргээд орж ирэх юм байна гэж ойлгож байна.

Сая ингээд нэгнийгээ шүүмжилж болно. Тэгээд хамтарсан Засгийн газрынхаа үед олон тулгамдсан томоохон асуудлуудаа хамтраад шийдээд явж байна гэж бүгдээрээ баяртай байгаа. Улсын Их Хурлаар оруулж байна гэдэг илүү ард түмэндээ нээлттэй хэлэлцүүлж байна л гэж ард түмэн маань ойлгоно. Тэгээд Засгийн газар дангаараа шийдээд байхгүй Улсын Их Хурлаар оруулж байна гэдэг энэ асуудлыг илүү ард түмнээрээ ард түмний төлөөллүүдээрээ хэлэлцүүлж байна л гэж ойлгож байгаа. Тэгээд 3 хоногийн завсарлага энэ асуудлаар.

10.50 цагт

Хэлэлцэх асуудал хоёр. [Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя аа.](#)

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна аа. Сайдын микрофоныг нээе.

Ц.Туваан: Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээх талаар тусгагдсан. Үүний хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Их

Хурал 2022 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг, 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тус тус баталсан. Уул уурхайн салбар 2024 оны жилийн эцсийн байдлаар ДНБ-ий 26 хувь, аж үйлдвэрийн салбарын 72 хувь, гадаадын шууд шууд хөрөнгө оруулалтын 81 хувь, экспортын орлогын 94 хувь, төсвийн орлогын 34 хувийг тус тус бүрдүүлсэн.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 3.7 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 120.4 сая доллар буюу 3.1 хувиар буурсан байна. Экспорт импортоос давамгайлж 294 сая доллароор өссөн үзүүлэлттэй гарсан боловч экспортын орлого мөн өмнөх оны мөн үеэс 234.5 сая доллар буюу 10.5 хувиар буурч 2 тэрбум 4.9 сая ам.долларын гүйцэтгэлтэй байна аа. Одоогийн байдлаар уурхайн бүтээгдэхүүнийг свот форвард гэрээний дагуу биржээр дамжуулан арилжиж байгаа бөгөөд 2023 оны 1 сарын 12-ны өдрөөс 25 оны 3 сарын 14-ний өдрийг хүртэл 43 сая тонн уурхайн бүтээгдэхүүнийг нийт 17.07 их наяд төгрөгөөр арилжаалаад байна. Монголын хөрөнгийн бирж ХК-д бүртгэлтэй уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, 471 гэрээ байгуулсан худалдан авагчид бүртгэлтэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар хамгийн их бүтээгдэхүүн арилжсан сар нь 2024 оны 4 дүгээр сар бөгөөд нийт 55 удаагийн арилжаагаар 4.2 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 951.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна аа. Гэсэн хэдий ч дээрх эрх зүйн зохицуулалтуудын хийдэл болон хоорондын уялдаагүй байдлаас үүдэн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаа зохисгүй байдалд орох, биржийн арилжаанд оролцогч ААН-үүдийн орлогыг хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байгаа нь цаашлаад үндэсний баялгийн санг арвижуулахад бэрхшээл үүсгэх эрсдэлтэй байна аа.

Тухайлбал уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүнгээс үзэхэд тухайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөх үед арилжаа өссөн бөгөөд 2023 оны 12 дугаар сард нүүрсний үнэ 816 мянган төгрөгт хүрэх үед биржийн арилжаагаар 1.9 их наяд төгрөгийн нүүрс арилжаалагдсан байна. 2025 оны 2 дугаар сарын байдлаар нүүрсний үнэ 30 хувиар буурч, 568 мянга 800 төгрөг болоход биржийн арилжааны тоо өмнөх оны мөн үеэс 9 дахин буурсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны 1, 2 дугаар сард нийт 3.9 сая тонн нүүрсийг 1.8 их наяд төгрөгөөр арилжаалж байсан ба тухайн хугацаанд нэг арилжаанд дунджаар 6 худалдан авагч оролцдог байсан бол 2025 оны 1, 2 дугаар саруудад нийт 428,8 мянган тонн нүүрсийг 122.9 тэрбум төгрөгөөр арилжаалаад байгаа ба нэг арилжаанд дунджаар 1-ээс 2 худалдан авагчид оролцож байгаа нь эрэлт огцом буурсныг илэрхийлж байна аа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина гэж заасан бөгөөд үүнтэй холбоотойгоор төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-үүд нь дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд бүтээгдэхүүнээ борлуулах боломжгүй нөхцөл үүсээд байна аа.

Тухайлбал Эрдэнэс, критикал минералс төрийн өмчит үйлдвэрийн газар, Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК-д дээрх хүндрэл үүсээд байна аа. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь дотоодын ААН-үүдэд уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжаалах эрх зүйн орчин бүрдээгүй байгаатай холбоотойгоор 15-40 хувийн төмрийн агуулгатай 2.5 сая тонн хэмжээтэй ойролцоогоор 42 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий төмрийн хүдэр завсрын бүтээгдэхүүний овоолго үүсээд байна.

Өнөөгийн байдлаар төмрийн хүдэр завсрын бүтээгдэхүүн хадгалах агуулах талбайн дүүргэлт 87 хувьтай байгаа ба цаашид тасралтгүй нэмэгдэж үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна аа. Эдгээр үйлдвэрүүдэд 2024 онд дотоодын баяжуулах боловсруулах үйлдвэрүүдээс 1.5 сая тонн бүтээгдэхүүнийг худалдан авах захиалга ирсэн байгааг борлуулах эрх зүйн орчин бүрдүүлснээр 33 тэрбум төгрөгийн орлого олж, улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар хураамж нэмэгдэхээр байна. АМГТГ-т бүртгэгдсэнээр 2025 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй, 49 баяжуулах үйлдвэр бүртгэлтэй байгаагаас нүүрсний 11, төмрийн 19, хайлуур жоншны 19 үйлдвэр байна аа.

Мөн 2024 онд 27 баяжуулах үйлдвэр, 2025 онд 18 баяжуулах үйлдвэр үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулахаар ирүүлсэн бөгөөд эдгээр үйлдвэрүүд улс орон нутгийн төсөвт 2022 онд 12.2 тэрбум төгрөг, 2023 онд 11.7 тэрбум төгрөг, 2024 онд 2.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн нь буурсан үзүүлэлт юм аа. Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд биржийн арилжааны үнийг хил залгаа улсын хилийн боомтын үнээр зарлана. Мөн биржийн арилжааны явцад талууд биржээс зарласан үнийг зөвшөөрснөөр гэрээний үнэ тогтоно гэж хатуугаар зохицуулсан нь тус хуулийн 14.2 дахь заалтын үзэл санаатай зөрчилдөж байгаа юм аа.

Тухайлбал нүүрсний үнэ 2023 оны 7 сарын 1-ээс 2024 оны 1 сарын 1 хүртэл 47 хувь өссөн бол 2024 оны 1 сарын 1-ээс 25 оны 1 сарын 1 хүртэл 44 хувь буураад байна. Энэхүү үнийн уналтаас шалтгаалж биржээр арилжаалагдсан 727.5 сая ам.долларын үнэ бүхий 31 гэрээний 6.83 сая тонн нүүрсний татан авалт хийгдэхгүй Ганцмод боомтын агуулахад 4.3 сая тонн нүүрс хуримтлагдсан байна аа. Биржийн форвард гэрээний хэрэгжилт нэг хүртэл жил үргэлжилдэг бөгөөд тус хугацаанд үүсэх үнийн хэлбэлзэл нь худалдагч худалдан авагч аль аль талд эрсдэл үүсгэх боломжтой байна. Үнийг индексжүүлснээр зах зээлийн тусгал илүү бодитой болж талуудад үүсэх эрсдэл буурах боломж бүрдэнэ ээ.

Худалдааны нөхцөлийг нэмэгдүүлэх, үнийг индексжүүлэх боломжийг бүрдүүлснээр нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн баяжмал зэрэг бусад уул уурхайн бүтээгдэхүүнийг зах зээлийн бодит өрсөлдөхүйц үнээр борлуулах арилжааны хэмжээ нэмэгдэж гэрээний хэрэгжилт хангагдана гэж үзэж байна. Түүнчлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны худалдааны хүргэлтийн нөхцөлийг зөвхөн хил нөхцөлөөр борлуулахаар хуулиар зохицуулсан нь бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Тухайлбал Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК-д төслийн бүрэн хүчин чадлаараа хүрч ажиллахад буюу төмрийн хүдрийн баяжмалыг экспортлоход нийт 1400 орчим вагон шаардлагатай бөгөөд өнөөдрийн байдлаар тус компани 750 вагоныг түрээсэлж байгаа зэрэг нь эрдэс бүтээгдэхүүнээ худалдааны нөхцөлөөс илүү нээлттэй болгож оновчтой болгож өгөх шаардлагыг үүсгээд байгаа юм аа. Биржийн арилжааг олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулж тогтоосноор Тавантолгойн экспортын хэмжээ нь нэмэгдэж нүүрсийг дундын зуучлагчдаар дамжихгүй эцсийн хэрэглэгчдэд шууд борлуулах, мөн нүүрсний үнийг Хятадын биржийн тухайн өдрийн үнээр тогтоож төрөл бүрийн олноор борлуулах боломж бүрдэнэ ээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор харилцан ашигтай тогтвортой урт хугацаанд бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурал шийдвэрлэж болох зохицуулалтыг тусгасан.

Ингэснээр агаарын бохирдол, орон сууцжуулалт, түгжрэл бууруулах зэрэг бусад нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломж бүрдэх юм аа. Мөн цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хэлэлцээний дагуу Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын мэдээ тайланг олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлэх үүрэг хүлээсэн тул уг харилцааг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна аа.

Иймд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д энэхүү хуулийн 14.8-д заасан мэдээллийг Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэж хяналт тавина гэж, 14 дүгээр зүйлийн 14.8-д цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын талаар мэдээллийг Цөмийн энергийн тухай хуулийн 47.1.1-д заасны дагуу олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлнэ гэж тус тус нэмж тусгасан бөгөөд үүнтэй холбогдуулан цөмийн энергийн газар байгуулах зорилгоор Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Мөн хууль цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Засгийн газар зөвшөөрснөөр олгох талаар тусгасан. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, эрдэс баялгийг олон улсын стандартын дагуу ашиглаж, борлуулах, түүнээс олох орлогыг үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хангах олон тулгуурт эдийн засгийг дэмжих хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр бэлтгэн танилцуулж байна аа.

Энэхүү хуулийн төсөл нь 3 зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай тус тус нийцсэн болно. Хуультай уялдуулан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай, Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах юм аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Туваан сайдад баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан, Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Дөлгөөн СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга, Баатарцогт Цөмийн энергийн комиссын Тамгын газрын дарга, Чадраабал Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Ядамжав Эрдэнэс Монгол компанийн Нэгдлийн чанар, бүтээмж хариуцсан менежер. Танай захирал хаачсан юм? Танай захирал чинь яг энэ дээр л байх ёстой доо. Энэ асуудал чинь хамгийн том асуудал болчихоод байна шүү дээ. Жавзанпагма Эрдэнэс Монгол компанийн Нэгдлийн хяналтын асуудал хариуцсан менежер, Төгсбуйан Эрдэнэс Монгол компанийн геологи үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Мөнхжаргал Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч. Мөнхжаргал байна уу? Байна. Чагнаадорж Дарханы төмөрлөгийн үйлдвэр компанийн гүйцэтгэх захирал, Бадрах Дарханы төмөрлөгийн үйлдвэр компанийн санхүү удирдлагын газрын дарга, Тэгшжаргал Эрдэнэс критикал минералс төрийн өмчит үйлдвэрийн газрын Санхүү эдийн засгийн бодлогын газрын дарга. Энэ танай захирал чинь хэн билээ. Байгаа юм уу? Хаачсан юм? Дөлгөөн Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Мөнхсоёл гишүүнээр тасалъя. Ингээд Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна аа.

Х.Ганхуяг: Ер нь биржийн хуульд өөрчлөлт оруулахыг дэмжиж байгаа. Гэхдээ энд хэд хэдэн асуудал байна шүү.

Нэгдүгээр асуудал. Энэ 10.3 дээр та нар энэ бартераар наймаа хийх эрхээ авах гэж л байгаа юм байна л даа. Тэгээд энэ дээр Улсын Их Хурал шийдвэрлэж болноо гэж орсон нь яг ямар агуулгатай гэж ойлгох юм? Тэгээд 1 ойлгочихмоор байна.

Хоёрдугаарт яагаад энэ биржийн арилжааны дундаж үнийг баримтална гэдгийгээ яагаад хассан гэдгийг чинь нэг тодруулчихмаар байна, 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт энэ цөмийн энергийн хуулийг яагаад хөндсөн юм бэ? Цөмийн энергийн хуулийг биржийн хуультай уялдуулж нийцүүлж хөндсөн гэсэн асуудлыг сая сайд унших юм. Тэгээд энэ нэг хууль оролдохоороо ингээд л дагуулаад л агентлаг байгуулаад байдаг асуудал юу гэж байвал байгаа юм? Төсөв нь хаана байгаа юм. Энэ чинь зүгээр нэг ажлын албатай байсан комисс шүү дээ.

Нэгдүгээр асуудал. Төрийн захиргааны төв байгууллагыг байгуулах гэж байгаа 1 дүгээр асуудал. Зорилго нь юу юм? Яагаад байгуулах гэж байгаа юм? Төсөв нь хаана байгаа юм, Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хаана байгаа юм? Бүдүүвч зураг нь хаана байгаа юм? Ямар бүрэлдэхүүнтэй, хэчнээн хүн ажиллах юм? Одоо байгаа тэр ажлын албанд чинь хэдэн хүн ажиллаад байгаа юм. Одоо санхүүжилт нь хаанаас гарч байгаа юм. Тэгээд зүгээр ингээд Биржийн хууль оролдонгуутаа ингээд агентлаг байгуулна гэдэг чинь энэ чинь яг зүгээр танд ний нуугүй хэлэхэд энэ хуулийн хулгай гэдэг шүү. Тэгээд энэ хамтарсан Засгийн газар чинь одоо ингээд яагаад байх юм? Одоо ингээд л нэг юм хийгээд л, ингээд л орон тоо нэмээд л, нэг юм хийгээд л ингээд л бүтэц нэмээд л ингээд яваад байх юм уу?

Тэгээд бид нар чинь уг нь нэг цомхон засагтай байя, ухаалаг цомхон засагтай байя гээд л та нар энэ 2024-өөс 2028 оны Засгийн газрын төлөвлөгөөнд дээр чинь тэгж орсон шүү дээ. Тэгээд яг хийхдээ ингээд дандаа эсрэгээрээ орж ирнэ. Тэгээд энэ дээр нэг хариултаа авчхаад тодруулъя.

Р.Сэддорж: Хариулт 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Ганхуяг гишүүний асуултад хариулъя аа.

10.3 дээр тийм нөгөө нэг заалт тэр нь нөгөө өмнө нь батлагдчихсан байсан. Тухайн үедээ энэ нөгөө Гашуун сухайт-Ганцмодны хил холболтын төмөр замын ажлыг урагшлуулах хүрээнд Нямбаатар сайдыг байх үед энэ асуудал шинэ заалт орсон. Тэр нь болохоор төмөр замын суурь бүтэц эзэмшигч компанитай гэрээ байгуулах гэсэн заалт байсан. Энэ заалтыг хасаад оронд нь энэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий гээд томоохон төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газар өргөн мэдүүлснээр Их Хурал шийдвэрлэж болно. Тэгээд энэ дээр боо нөгөө маш олон Засгийн газрын 14 мега төсөл, дээрээс нь одоо сая бас Бүсчилсэн хөгжлийн анхдугаар уулзалт Архангайд мөн орон нутгуудаас маш олон зүйл ярьж байгаа. Энэ дотор ер нь л нийгмийн шинжтэй асуудал, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг маш яаралтай хийгээч гэдэг ийм асуудал байгаа. Манай хууль эрх зүйн хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэх боломж байхгүй. Тухайлах юм бол уул уурхайн бүтээгдэхүүнээ бид нар борлуулаад АМНАТ аваад түүнийгээ баялгийн санд төвлөрүүлээд тэндээсээ хуваарилалт хийх замаар юм уу эс үгүй бол улсын төсвөөр хийх гэсэн ийм 2 л сонголт байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бид нар гавьтай дорвитой өөрчлөлт асуудал шийдэх ийм байдал оруулж ирж чадахгүй байгаа учраас энэ асуудлыг Засгийн газар тухайлах юм бол бүсүүдийн асуудлыг эрэмбэлээд юм уу эс үгүй бол Засгийн

газар дээр 14 мега төслөөс шийдвэрлэх асуудлаа оруулж ирээд саяын Гашуун сухайт, Ганц модны хэл холболтын хэлэлцээр баталдаг шигээр Их Хурлын шийдвэрээр батлагдаад явбал илүү хэрэгжилт талдаа илүү болох юм гэдэг үндэслэлээр энэ заалтыг оруулж ирсэн. Цөмийн энергийн агентлагтай холбоотой асуудал дээр нэг зовлонтой асуудал байгаа нь энэ олон улсын атомын энергийн агентлагаас бид нараас маш олон шийдвэрүүдийг нэхдэг мэдээллүүдийг нэхдэг.

Дээрээс нь бид нар энэ саяын Рона групптэй байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ байна. Цаашлаад бид нар энэ Чехтэй хамтарсан, Хятадтай, Оростой гээд маш олон энэ цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, хамтарсан хөрөнгө оруулалтын асуудлуудыг яригдахад энэ дээр яг хэрэгжүүлэгч агентлаг зайлшгүй хэрэгтэй байгаа юм аа. Өмнө нь 103 хүнтэй агентлаг байж байгаад татан буугдаад явсан. Одоо бол Боловсролын сайдын хүрээнд байж байгаад манай эрхлэх асуудлын хүрээнд ирсэн Цөмийн энергийн хариуцсан комисс ажиллаж байгаа. Энэ комисс бол 27 хүнтэйгээр үйл ажиллагаа Комиссын ажлын алба гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхдээ бид нар энэ дээр агентлаг болголоо гээд энэ орон тоо нэмэх төсвийн боломж ч байхгүй. Яг тэр хэвээр нь хадгалаад үйл ажиллагааг нь явуулах гэсэн ийм концепцоор оруулж ирж байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл ажлын албаа агентлаг болгоод тийм 33 хүний бүрэлдэхүүнтэй. Дээрээс нь бас энэ манай яам руу энэ комисс шилжиж ирсэнтэй холбогдуулаад энэ асуудлыг хариуцсан байцаагч нар, орон тооны салбарын хяналтын 9 дээр нэмэх нь 6 гээд ийм 15 байцаагч жишээлбэл харьяалалгүйгээр одоогийн байдлаар энэ АМГТГ-т түр харьяалалтай байх гэсэн иймэрхүү асуудлыг шийдэх ийм зайлшгүй нөхцөл тулгамдаад байгаа юм гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн тодруулж асууна.

Х.Ганхуяг: Яах вэ танилцуулга дээр чинь ийм л юм яваад байна л даа. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хэлэлцээрийн дагуу Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын мэдээ тайланг олон улсын агентлагт хүргүүлэх үүрэг хүлээсэн тул уг харилцааг боловсронгуй болгох шаардлагатай гээд орсон байгаа байхгүй юу. Тэгээд таны ярьж байгаа юм чинь тэгээд энэ танилцуулга дээр байгаа 2 юм чинь хоёулаа зөрөөд байна л даа. Тэгээд асуугаад байгаа юм. Яах вэ ойлгож байна. Энийг яалт ч үгүй бид нар шинээр шинэ ордуудаа ашиглавал зөв байх л даа. Тэгэхдээ агентлаг байгуулах хэмжээний асуудал уу, үгүй юу л гэдэг дээр л эргэлзэж байна. Ойлголоо, баярлалаа.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль. Энэ дээр жоохон түүх ярих хэрэгтэй байна. Энэ хууль 2022 оны 12 сарын 23-нд батлагдаж байсан. Та бүхэн санаж байгаа бол 2022 оны 12 сард маш олон залуучууд Сүхбаатарын талбай дээр гараад -30 хэмийн градуст нүцгэн жагсаж байсан шүү. Нүүрсний хулгайтай тэмцэх. Тэр нүүрсний хулгайтай тэмцэх шийдэл нь өөрөө энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль байсан. 8 жил

гацаад явдаггүй хууль хоёрхон 7 хоногийн дотор батлагдаж байсан. Миний хувьд өөрөө Дэд сайдаар ажиллаж байхдаа энэ хуулийг Улсын Их Хурал дээр яг асуултад нь хариулаад тухайн үедээ ингэж батлуулж байсан. Энэ хууль тэгээд хэр үр дүнтэй болсон юм бэ? 2023 оноос 2025 оны 2 сарын тоогоор 16.9 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн байгаа юм. 16.9 их наяд төгрөгийн арилжаа. Тэр бирж дээр зарагдсан бүтээгдэхүүнүүдийн анхны үнэ, мөн арилжаалагдсан үнийн зөрөөгөөс 1.3 их наяд төгрөгийн нэмэлт орлого олсон байгаа юм. Тэгэхээр ер нь энэ хууль маш амжилттай явсан. Нүүрсний хулгайтай тэмцсэн гол шийдэл энэ өөрөө байсан. Тэгээд өнөөдөр ингээд нэмэлт, өөрчлөлт орж ирж байна. Энэ дээр олон маш том асуудалтай зүйлүүд байна шүү.

Дараагийн нүүрсний хулгайг гаргаж ирэх орон зай энэ хуулийн өөрчлөлт рүү орж ирж байгаа гэдгийг сануулъя. Ийм асуулт байна. Туваан сайд.

Энэ дээр ийм маш ноцтой хэдэн зүйл байна. Биржээр арилжаалагдсан гэрээн дээр гэрээний үнийг нэмэлт, өөрчлөлтөөр оруулах орон зайг нээж байна шүү дээ. Нэгэнт биржээр арилжаалсан бол тэр гэрээг өөрчилж болдоггүй юм шүү дээ энэ чинь бид нар дэлхий дээр байхгүй зүйл хийх гээд байна шүү дээ та. Юун дээр үндэслэсэн гэхээрээ нүүрсний чанар болон зах зээлийн үнийн индекс гэж байгаа юм. Нэг зүйлийг хэлье. Эрдэнэс Тавантолгойн нүүрс анх 2010 оноос зарагдсан үеэсээ эхлээд чанарын асуудал дандаа дагуулж ирсэн. Тэгэхээр чанарын одоо нэг ёсондоо зөрчил гаргаад л дураараа нэмэлтээр гэрээний үнэ өөрчилдөг ийм асуудал руу орох гэж байна шүү. Энэ бол яг дараагийн том хулгай болж гарч ирэх гэж байна.

Тэгээд энэ нэмэлт, өөрчлөлт яг үнэнийг хэлэхэд би өөрөө хууль дээрээ ажиллаж байсан учраас хэлж байна аа. Энэ дээр бол маш шүүмжлэлтэй хандаж байна. Энэ аягүй дутуу хийсэн хууль байна. Та нар хараарай. 16.4.5 аргачлал, байршил батална. Хэн батлах гээд байгаа юм? Засгийн газар батлах гээд байгаа юм уу? Эсвэл Эрдэнэс Тавантолгой батлах гээд байгаа юм уу? Хэн батлах нь ойлгомжгүй зүгээр батална гэдэг хууль оруулж ирж байгаа юм. Энэ чинь ганцхан энгийн өгүүлбэрүүд шүү дээ. Хамгийн гол асуудал энэ дээр байгаа юм.

14.1 дээр энэ хуулийн яг энэ үндэслэлтэй энэ хуулийн яг амин сүнснийг энэ дээр өөрчилж байна л даа. Олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулж тогтооно уу? Энэ юу гэсэн үг вэ гэхээрээ ам нөхцөлийг нээж байна гэсэн хуулийн гаргалгаа байж байгаа. ЭТТ-н нүүрсний хулгай юунаас гарсан гээч ам нөхцөлтэй байсан шүү дээ. Тухайн үедээ бид нар олон жил ам нөхцөл болохгүй гэж тэмцэж явсныг буцаад энэ хуулийн нэмэлт өөрчлөлтөөрөө нээж байгаа нь буцаад дараагийн нүүрсний хулгай гаргах орон зайг нээж байна шүү дээ хуулиараа.

Дахиад л нэг 5 жилийн дараа дахиад л нэг нүүрсний сонсгол хийсэн асуудал руу орохвий дээ. Олон улсын худалдааны танхимаас гаргасан 11 инкотерм гэж байгаа. Тэрний нэг нь өөрөө ам нөхцөл албан ёсоор ордог байхгүй юу. Тэгэхээр энэ ам нөхцөлөөр нүүрсээ зарж байна гэсэн үг. Нүүрсээ зарах эрх нь энэ хуулиараа нээгдэх гэж байна л даа. Тэгэхээр энэ дээр нэг ийм та таны тайлбар дээр ингээд байна л даа. Хариултаа авчхаад нэмэлтээр асууя. Миний цаг хүрэхгүй юм байна.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд хариулъя. Ам нөхцөл гэж ам гэж юу яриад байгаа юм.

Ц.Туваан: Уул уурхайн биржийн тухай хууль батлагдсан. Энэ хуулийг улам төгөлдөршүүлээд сайжруулах чиглэлээр явж байгаа нэмэлт, өөрчлөлт. Амьдрал баян учраас бас асуудлууд орж ирээд байна. Тэгэхээр сайжруулах гэдэг логиктой явж байгаа. Биржээр бол буцах биржээр арилжаалахгүй байх энэ тэр гэдэг асуудлууд байхгүй гэдгийг хэлье. Энэ дагалдаж гарч ирж байгаа энэ хуулийн өөрчлөлтийг дагалдаж гарч ирж байгаа журам, тэр нөгөө нэг байршил, дээрээс нь тээвэртэй тээвэргүй энэ тэр гээд бусад асуудлуудыг Засгийн газраар батлах журмаар зохицуулж өгөхөөр тусгаж орж ирсэн. Сая Байнгын хорооны дарга сануулж байна. Бид нар нөгөө жоохон буруу яриад сурчихсан.

Тэгэхээр энэ дээр бол одоо нөгөө нэг тээвэртэй, тээвэргүй биржийн арилжааны үнийг олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай гээд. Энэ дээр бол Эрдэнэс Тавантолгой компани бол биржээрээ ганц Эрдэнэс Тавантолгой ч биш энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниуд бирж дээр бүгд заавал бүтээгдэхүүнээ арилжих нь хэвээрээ байгаа арилжина. Харин хүргэлтийн нөхцөл дээр даф юм уу тээвэртэй юм уу, тээвэргүй юу гэдэг сонголтыг хийж өгөх нь яг өнөөдөр үүсчхээд байгаа нүүрсний борлуулалттай холбоотой үүсчхээд байгаа асуудлыг нэмэгдүүлэх ийм зорилготойгоор ийм заалтыг нэмж хийсэн гэдгийг хэлье.

Дээрээс нь тэр үнийн индекстэй холбоотой асуудлаар Монголын хөрөнгийн бичрийн захирал Дөлгөөн нэмж хариулна.

Р.Сэддорж: Микрофонгүй ярихгүй 5 номер үргэлжлүүлж хариулъя. Энэ бусад энэ ажлын хэсгийн гишүүд идэвхтэй ажиллаарай. Хариулт дээр.

Б.Дөлгөөн: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Хөрөнгийн биржийн захирал Дөлгөөн Батнайрамдал гишүүний асуултад хариулъя аа. Юуны түрүүнд энэ Ул уурхайн биржийн тухай хуулийг баталсан тухайн үед ажиллаж байсан бүх гишүүд болон оролцсон хүмүүст баярлалаа гэж хэлмээр байна. Энэ биржийн үр дүнд анхны үнээсээ өсөж зарагдсан учраас 1.3 их наяд төгрөг нэмж Монгол Улсад бол орж ирсэн байдаг. Тэгээд олон улс дээр бол энэ спот буюу яг хүргэлттэй гэрээ эсвэл фьючерс буюу үүсмэл үнэт цаас гэдэг ийм 2 хувилбараар явдаг. Манайд бол үүсмэл үнэт цаас нь бол арилжигддаггүй учир жил 6 сараар хийсэн гэрээнүүд бол тогтмол үнэтэй өмнө нь бол арилжаалж явсан. Туваан сайдын танилцуулга дээр бол өмнө нь 160, 170 доллар хүрч байсан ийм нөхцөлд 1 сая тонныг нэг жилээр авчихсан айлууд өнөөдөр 500 мянган тонноо татаж авчхаад, 500 мянган тонноо яг 1, 1-ээр нь дахиад татах гэхээр яг нэг авч байгаа тонн тутамдаа 160 доллар, 140 доллар гээд өндөр үнээр авсан энэ хэлбэрээ хадгалж авах шаардлага үүсчхээд байгаа учраас зарим гэрээнүүдэд яг бодитоор бол гацалт үүсээд зогссон ийм нөхцөлтэй байгаа. Тэгээд энэ үнэ болон чанар дээр тохируулга хийнэ гэдэг бол гэрээн дээр гэхээсээ илүү энэ агуулга нь бол ямар учиртай юм бэ гэхээр хүхэр нэг хувиар

нэмэгдэхэд 10 юаниар үнэ нь буурч ингэж дараагаар нь зохицуулалтууд хийгддэг. Энэ Даляна, Шанхай болон Австралийн биржүүд дээр ч гэсэн, төмөр дээр ч байдаг нүүрсэн дээр ч байдаг ийм заалтууд. Тэгээд яг энэ үнэ, чанар 2 той уялдуулаад гэрээний үнэд өөрчлөлт орж болно гэдэг нь энэ боломжийг бид нар бол нээж өгч байгаа болохоос өөр бол утга агуулгыг энд агуулаагүй байгаа юм аа.

Тэгэхээр та бүхэн ойлгож хүлээж аваарай гэж хүсэх байна аа? Баярлалаа.

Р.Сэддорж: Тодруулж асууя. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Нэг ёсондоо чанараа зарлаад арилжаалсан тэр дүнгээ буцаагаад дураараа гэрээн дээр өөрчилж орохоор л хууль дээр орж ирээд байна шүү дээ. Тэгэхээр 1 зүйлийг хэлье. Дараа нь энэ хууль батлагдаад зарагдсан нүүрс болгоны чанар дээр асуудал үүснэ. Тэр болгон дээр яах вэ худалдан авагч тал маргаан гаргана гэсэн үг. Гэрээнийхээ үнийг өөрчилъе гэдэг. Яг ийм ийм зүйлийг л нээх гээд байна л даа. Зах зээлийн үнийн индекс дээр тулгуурлана гэх юм бол энийг бид нар контролдохгүй учраас яах вэ энэ болж байна тиймээ. Нэг зүйл.

Хоёрдугаарт энэ үнэ өсөхөөр бирж ажилладаг, үнэ буухаар бирж ажилладаггүй гэдэг ийм яриагаа болих хэрэгтэй шүү. Бирж үнэ өссөн ч, буурсан ч, аль ч нөхцөлд ажиллах ёстой зарчимтай. Гэтэл үнэ өсөж байхад бирж болж байна гэж явж ирчхээд, одоо үнэ буухаар болохгүй байна, бирж болохоо больчихлоо. Яг ийм зүйлийг л яриад байна л даа. Нүүрсний хулгай тээврийн хулгай байсан юм шүү. Буцаад тээврийг ингээд буцаагаад нээгээд ам нөхцөлийг авч хаяхаар буцаад тээврийн хулгай руу л орно. Ийм дүр зураг л харагдаж байна шүү эндээс.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ бол үнэн. Яагаад ийм хууль оруулж ирж байгаа гэхлээр мэдээж Монгол Улсын төсвийн болон Монголд орж ирж байгаа орлогын маш өндөр хувь энэ уул уурхайн салбараас хамаардаг ялангуяа нүүрснээс. Тэгээд энэ дээр энэ биржээр арилжаалагдаж байгаа бүтээгдэхүүнүүдийн маань үнэ унаад борлуулалт муудаад ингээд гацалт үүсчхээд байгаа юм. Өнөөдөр бол бид нар энийг зайлшгүй л оруулж ирж байгаа. Тэгээд сайжруулах байдлаар оруулж ирж байгаа.

Дээрээс нь энэ үнэ дээр энэ индексжүүлдэг практик байгаа. Тэгэхдээ энэ дээр нөгөө сая таны хэлсэн чинь үнэн. Нөгөө зах зээлийн үнээ голчлон бодож индексжүүлэх асуудал байгаа. Тэгэхээр өнөөдөр бодитойгоор манай бирж дээр ийм асуудал борлуулсан нүүрс дээр ийм асуудал үүсчхээд байгаа юм. Үнэ бараг 44 хувиар үнэ уначхаад байгаа. Нөгөө 44 хувийн өндөр байх үед авсан ААН-үүд нүүрснийхээ татан авалтыг буюу тэнд буулгах талбайгаа оруулж өгөхгүй ингээд манайхаас.

Р.Сэддорж: 3 номер гүйцээж хариулъя. Туваан сайд.

Ц.Туваан: Гарч чадахгүй байгаа асуудал байгаа. Тэгэхээр энэ чанартай холбоотой зүйл дээр тантай санал нэг байна. Дараа нь гарч ирэх асуудлууд нэлээн яригдах байх? Хэрвээ зах зээлийн үнэтэй холбоотой асуудал бол яалт ч үгүй л гарч ирээд байна. Тэгээд бид нар энэ үнийг баримтлаад үнэ бууж байгаа үед нь индексжүүлээд бууруулаад явахгүй бол борлуулалт байхгүй, татан авалт байхгүй таг зогсож байгаа. Нэмэгдэж байгаа үед ч гэсэн индексжүүлээд нэмээд явбал бид нар нэг зарцаа өсчихсөн юм чинь тэр үед нь зарах байсан юм гэдэг ийм зүйлээс сэргийлэх ийм боломж бүрдэх юм.

Р.Сэддорж: 5 номер тодорхой хариулаарай.

Б.Дөлгөөн: Батнайрамдал гишүүнтэй 100 хувь санал нэг байна. Үнэ унасан ч биржээр явдаг, үнэ өссөн ч биржээр явдаг энэ тогтолцоог бүрдүүлэхийн төлөө өнөөдөр Хөрөнгийн бирж ажиллаж байна. Тэгээд олон улсад яадаг вэ гэхээр спот маркет буюу хүргэлттэй зах зээл байдаг. Нэмээд ирээдүйд 6 сарын дараа, 12 сарын дараа үнэ яаж өөрчлөхийг нь хэйжинг буюу эрсдэлийг хамгаалдаг, бууруулдаг деривитивис буюу үнэт цаасны зах зээл байдаг. Би нөгөө сая үнэтэй холбоотой, индекстэй холбоотой, чанартай холбоотой энэ тохируулгыг. Тийм тэгэхээр ийм зохицуулалт байдаг. Манайх бол одоо дараа жилээс бол үүсмэл үнэт цаасыг оруулаад ирэх юм бол дахиж энэ хүндрэлтэй асуудлууд үүсэхээргүй. Наана нь яах аргагүй энэ тохируулгын механизмыг оруулж өгөхгүй бол нөгөө өндөр үнээр авсан айлууд гацаатай байгаа.

Хэрвээ нүүрсний үнэ 44 хувиар нэмэгдсэн бол ямар нэг байдлаар ямар ч гомдол гарахгүй явах байсан гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Одоо бол Тавантолгойн бүлэг орд дээр зургаа аравны хэдэн сая тонн нүүрс борлуулчихсан авахгүй байгаа. Хилийн цаана дөрөв аравны хэдэн сая тонн нүүрс мөн хүргээд өгчихсөн цааш нь авахгүй байгаа тиймээ. Тэгээд энэ асуудлаа сайн ярихгүй өөр ганган юм яриад байвал болохгүй байна л даа. Тэгээд энэ чинь хууль чинь болохгүй болоод л орж ирж байгаа л гэж ойлгоод байгаа шүү дээ.

Батболд гишүүн.

Р.Батболд: Бас л 2 асуулт асууя. Энэ Зохицуулах хороо хөрөнгийн биржийнхнээс нэг юм асуучих уу, асуучихъя. Энэ нэг юм уу уул уурхайн биржийнхнээс. Энэ биржийн арилжаанд оролцогчийн энэ журам зөрчиж арилжаанд оролцсон арилжааг зогсооно гэхихсэн нэг заалт байна шүү дээ 14.5 гээд. Энэ дээр 14.5.1 дээр нэг сонин юм биччихсэн байх юм. Биржид тухайн үед тогтсон үнийн дээд доод хязгаараас давсан захиалга гээд. Доод хязгаараас давсан захиалга гэж байдаг юм уу? Бирж дээр. Энэ чинь бид нар чинь нэг зарласан үнэтэй тэрнээсээ дээшээ явж байвал биржийн арилжаа явдаг. Доошоо арилжаа дуудаад явна гэж байхгүй биз дээ. Энэ дээр юу биччихсэн юм бэ? Нэг ийм сонин юм байх юм. Тэгсэн мөртөө дээд үнийн хязгаарыг нь бирж нь өөрөө тогтоож өгөх гээд байгаа юм уу? Энэ ерөөсөө 1 ойлгомжгүй нэг юу байх юм. Дээд үнийн хязгаараас давсан ханшаар захиалга орж ирвэл болохгүй гэхихсэн ийм сонин юм орж ирээд байх юм. Энэ зүгээр дэнчингээрээ бид нар чинь зохицуулагдаад явах ёстой шүү дээ. Та нар наад уул уурхайн бүтээгдэхүүн

эрсдэлтэй гэж үзэж байвал дэнчинг нь өсгөөд л явуул л даа. Энэ юун дээд доод тэ хязгаар заагаад байгаа юм бэ? Тэгээд тэр гэрээгээ биелүүлэхгүй бол тэр дэнчинг нь аваад л явдаг тэр тал руугаа явахгүй юм уу? Тэр нэг сонин заалт байна. Дараагийнх нь асуудал. Энэ Батнайрамдал гишүүнтэй адилхан би энэ нэг индексийн хөдөлгөөнд тулгуурлаад өөрчлөлт оруулна гэхихсэн үнэд өөрчлөлт оруулна гээд байгаа юм. Энэ л бүүр их сонин юм санагдаад л байгаа юмдаа.

Нэгэнт бид нар чинь нэг тохирсон стандарт гэдэг юм уу чанарын тэр нүүрсийг ч гэдэг юм уу барааг. Энэ заавал нүүрс биш шүү дээ. Тэгээд энийг бид нар ингээд зарчихлаа гэрээгээ. Уул нь бол бид нар бирж чинь гэрээ л зарж байх ёстой газар шүү дээ. Ийм гэрээг ингээд зарчихлаа. Үгүй тэгсэн чинь одоо тэр чинь дараа нь нөгөө нэг чанарын өөрчлөлт гарна гэж юугаа яриад байгаа юм. Энэ нь нэг гайхалтай юм байгаад байгаа юм. Тэгээд бид нар тэр гэрээг зарсан тэр бараа бүтээгдэхүүн тэндээ байх ёстой бол тэр бүтээгдэхүүн нь тэндээ л байж л байх ёстой байх. Тэр чанар нь байж л байх ёстой байх. Энэ чинь тэр явцын дундаа уначихдаг барьчихдаг янз янзын юм байх юм уу байхгүй юм уу? Тэгээд 2 дугаарт зүгээр энэ биржээ жоохон нэг сонгодог утга руу нь явуулаад энэ нэг юу байгаад байх шиг байна. Энэ арай нэг өөр нөхцөлөөр аваад байгаа нэг 4 том компани байгаад байх шиг байна. Эд нарыг тэр талбай чөлөөл энэ тэр гэж хэлж болдоггүй юм уу? Багаар нийлүүлж болдоггүй юм уу? Бид нар 1нэг 300 мянгаар гэрээ хийж болдоггүй юм уу? Заавал 1 сая, 2 сая, 3 саяар нь хийчхээд л 6 сарын дотор татах ёстой байсан чинь та нар 3 сар болчихсон. Ингээд 3 сарын дараа үнэ нь өөрчлөгдсөн чинь цаашаа зарж чадахгүй гээд ингээд нөгөө ченжид зарж байгаа юм шиг юм яриад байх юм.

Хэрвээ ченжийн ийм юмаараа л явах гэж байгаа бол бид нар хэмжээгээ багасгаад нэг 300 мянган тонноор нь хийгээд ингээд явж болдоггүй юм уу? Талбайгаа 2, 7 хоногийн дотор чөлөөлөөд ч юм уу. Иймэрхүү байдлаар явж байсан бол наад асуудал чинь үүсэхгүй байсан юм биш үү? Одоо зүгээр ингээд 40 орчим сая тонн яг тэр овоорчихсон байгаа газраар гарч байгаа гэж тооцох юм бол наадах чинь нэг өдөрт бараг 100, 150 мянган тонн шахуу нүүрс болох гээд байна шүү дээ. Тэгээд энийгээ бид нар нэг 30 хоногийн тэр татан авалтынх нь нөхцөл байдалтай нь тохируулаад явчхаж чадахгүй ингээд бид нар чинь 6 сараар гэрээ хийдэг гээд ингээд нэг ийм сонин юм руу орчхоод л өөрсдөө тэрийгээ одоо шийдэж чадахгүй болчхоод яваад байх юм. Энэ зүгээр үнэ индексээр үнэд өөрчлөлт оруулна гэдэг ч жоохон сонирхолтой л юм. Яах вэ нөгөө бид нар ойлгож байна л даа. Би биржийг ойлгоод байна. Аль ч бирж дээр манайх тийм асуудал байгаа. Тэгээд Хятадын худалдан авагч нь яг авахгүй болохоор л биржийн үнэ нь уначихдаг. Яг зах зээлийн.

Р.Сэддорж: Батболд гишүүн нэг минут.

Р.Батболд: Яг сонгодгоор нь явуулъя гэхээр бирж дээр нэг болохгүй байгаад байгаа тал манай дээр байгаад байгаа юм. Тэрийг ойлгож байна. Тэгэхдээ ерөнхийдөө нэг жоохон энэндээ жоохон уялдуулаад тааруулаад нэг тиймэрхүү байдлаар зохицуулалт хийгээд явж болдоггүй юм уу гэдэг санаа байгаад байгаа юм.

Тэгээд одоо ингээд нөгөө 6 сарын дараа авах ёстой газар нь авч чадахаа байчихсан гээд ингээд л нөгөө талбай байхгүй болчихоод суугаад байна. Эс үгүй бол өөр талбай олоход л ийм юм бодох юм уу, яах ёстой юм. Энэ нэг талбай бөглөөд байгаа газруудаа хурдан наадхаа аваач гэж шахаж жоохон болохгүй байгаа юм уу? Ийм асуудал тавьж байна.

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Туваан сайд.

Ц.Туваан: Батболд гишүүний асуултад хариулъя аа. Энэ тийм Биржийн тухай хууль дээр засаж сайжруулах зүйлсүүд байгаа. Энэ ч утгаараа бас энэ орж ирж байгаа. Дээрээс нь бирж маань яг сонгодог биржийн байдлаараа гэрээ арилжаалдаг байдлаараа брокерууд нь үйл ажиллагаа явуулаад ингээд арилжаа хийдэг энэ байдал руугаа оруулах бэлтгэл ажлыг бид нар хангаад энэ хөрөнгийн биржтэй нэлээн яриад явж байгаа. Яг өнөөдрийн байдлаар бид нар биржийн арилжаа биш дуудлага худалдаа зохион байгуулаад явж байгаа. Тэгээд энэ дуудлага худалдаагаараа бас борлуулчихсан нүүрснүүдийн бөөгнөрөлтэй холбоотой асуудал дээр бас нөгөө мөнгөө алдаж байгаа одоо энгийнээр хэлбэл шатаж байгаа ААН-үүд цааш нь нүүрсээ татаж авч чадахгүй байна. Нөгөө бид нарын даавч нөхцөлөөр буулгаж өгөх гээд байгаа тэр терминалуудын агуулахуудыг чөлөөлж өгөхгүй. Тэд нар бас өөрсдөд байгаа боломжийнхоо хүрээнд эсэргүүцэл үзүүлээд байгаа. Энэ болгоны эцэст нь бид нарт нөгөө нэг нүүрсээ цааш нь борлуулах, биржээр борлуулах, тээвэрлэлтээ хийх, хүргэж өгөх энэ нөхцөлүүд маш хүнд байдалд орсон учраас энэ хуулийг оруулж ирж байгаа.

Тэгээд тэр чанартай холбоотой асуудал дээр бас энэ өөрөө хэлэлцэх эсэх учраас Их Хурлын гишүүдийн бүрэн эрхэд байгаа. Тэгээд хэлэлцүүлгийн шатад нь саналаа зарчмын зөрүүтэй саналууд оруулаад саналаа засаад ингээд явж болно. Бид нар бол энэ цаашдын татан авалтын асуудлыг бол дипломат шугамаар ч тэр, компаниудтай ч тэр, нөгөө урт хугацаанд гэрээ хийчихсэн байгаа 4 компанитай ч тэр биржийнх нь, компанийнх нь байнга энэ асуудлыг бол ярьж байгаа. Энэ дээр үүсчихсэн байгаа тэр 4.3 орчим сая тонн нүүрснүүд дүүрчихсэн байгаа энэ терминал дээр. Ойролцоогоор нэг 50 орчим хувь нь энэ томоохон худалдан авалт хийсэн компаниудын нүүрс бас байгаа гэдгийг хэлье.

Манай хөрөнгийн биржийнхэн нэмэлт хариулт хариулт.

Р.Сэддорж: Хэдэн номер вэ? Гараа өргөөрэй 5 номер. Өөрийгөө танилцуулаад.

Б.Дөлгөөн: Хөрөнгийн биржийн захирал Дөлгөөн байна. Батболд гишүүний асуултад хариулъя аа. Энэ таны хэлж байгаатай санал нэг байна. Одоо үүсээд байгаа асуудал энэ индексээр тохиргоо хийгээд ингээд явахад дахиж үүсэхээргүй болох юм. Тэр бол баталгаатай. Агуулахын хувьд бол өмнө нь авчихсан бараа тэнд агуулах дээр байгаа тэр бараа бол Монголын талын хөрөнгийн бирж ч юм уу эсвэл уул уурхайн компанийн эзэмшил биш болчихсон. Тэр агуулах нь бид нартай гэрээгүй. Тэгэхээр тэнд агуулагдах барааг мэдээж хамтын ажиллагааны хүрээнд бол наадхаа татан авалт хий гэж шахахаас бусдаар бол манай тал Хөрөнгийн биржийн зүгээс нэмэлт хийх үйлдлүүд байхгүй байгаа. Тэгээд чанар дээр тантай санал нэг байна.

Бид нар энэ чанарын асуудлыг оруулж ирдэг нь ямар учиртай вэ гэхээр боловсруулаагүй нүүрс жишээлбэл нүүрс дээр боловсруулаагүй баяжуулсан гэж 2 байгаа. Баяжуулсан бол чанарын хувьд маш нарийн гардаг учраас энэ дээр хэлээд байх зүйл байхгүй. Боловсруулаагүй дээр яах гээд байна гэхээр дараа нь тэр гэрээ нь бол гаальд бүртгэлтэй, татварт бүртгэлтэй, нөгөө ил тод байх үүднээс ингээд бүтэн дамжлага үүсчихсэн.

Тийм учраас энэ бүртгэлтэй гэрээнүүд дээр чанар дээрээсээ үүдээд энэ төлбөр тооцоон дээр өөрчлөлт орчих юм бол дараа нь та нар яагаад энэ үнээ ингээд авах ёстой мөнгөө бууруулаад авчхаж байгаа юм бэ гэдэг асуудал бол үүсээд байгаа юм байна лээ. Тэгэхээр энийг бол нөгөө яг чанар хүхэр нэг хувиар нэмэгдэхэд тонн тутамдаа тэдэн хувиар үнэ буурна гэдэг гэрээний зохицуулалтыг нээж өгөхийн тулд ингэж оруулж ирж байгаа.

Р.Сэддорж: Батболд гишүүн. Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Тодруулж асууя.

Р.Батболд: Үгүй ингээд байгаа юм яах вэ. Би наадах индексийг чинь нэг удаа нэг аргацаагаад зохицуулчих гээд байна гэж ойлгоод байна. Тэгэхдээ индекстэй байх ямар хэрэг байгаа юм бэ л гэж хэлээд байгаа юм. Наад багцаа жижиглэх л дээ. Тэгээд хүн нэг 14 хоногийнхоо 300 мянган тоннын нүүрс дээр ч юм уу авч байгаа 150 мянган тонн нүүрс байдаг юм уу, юу байдаг юм, зэс байдаг юм уу. Өөр ямар бүтээгдэхүүн байдаг юм? Үгүй энэ дээр нэг эрсдэл хүлээчих чадвартай байж байж тэр худалдаанд ороод цаашаа тэр чинь ченж нь тэгээд л явах ёстой шүү дээ. Энэ чинь зах зээлийнхээ шугам зарчмаар явах ёстой шүү дээ. Тэгэхгүй би нэг 10 сая тонныг авъя гэххээд өнөөдөр 5 саяыг нь аваачиж хилийн цаана аваачиж буулгаж хаячихаад. Үгүй одоо үнэ уначихсан, би тавыгаа авна, авна шүү дээ, би нэмээд авна. Тэгэхдээ миний 5 зарагдахгүй байгаа байхгүй юу хэдэн сар хүлээх юм бид нар. Тэгэхээр бид нар энэ зүгээр наад нэг багцынхаа хэмжээг жижиглээд хариуцлагыг нь өндөржүүлбэ. Хэд хоногийн дотор авсан байх ёстой юм. Цаашаа тэр талбай чөлөөлсөн байх ёстой.

Р.Сэддорж: Батболд гишүүнд нэг минут өгье. Тэрийг нэг гэрээн дээрээ тусгаад аваад явчих тийм боломж байдаггүй юм уу л гэж хэлээд байгаа юм. Тэгэхгүй 1 заавал индекс гэдэг ийм хууль руу оруулж ирчхээд тэгээд нөгөө байнгын хөдөлгөөнтэй байдаг нэг үнэ хөдөлж байдаг нэг ийм асуудал болчих гээд байна л гэж хэлээд байгаа юм. Тэр 14.5.1-ийг нэг хэлээд өгөөч, ийм заалт заавал байх юм уу байхгүй юм уу гэдэг.

Р.Сэддорж: Хариулт тодорхой хариулаарай. Нэг номероос эхэлье. Тэгээд 1, 2, 3 гээд явчихъя.

Х.Мөнхжаргал: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал байна аа. Батболд гишүүний асуултад хариулъя.

Тэр нөгөө татан авалттай холбоотой болохоор одоо өнөөдөр нөгөө Эрдэнэс Тавантолгой компани 2025 он гарснаас хойш 3 сарын 31-ний байдлаар

нийт 47 арилжаа зарласан. Энэ 47 арилжаанаас зөвхөн 12 арилжаа л амжилттай болсон. Бусад 35 арилжаа нь ерөнхийдөө амжилтгүй болсон буюу худалдан авагч, нэг ч худалдан авагч оролцоогүй. Энэний хэмжээг бол бид яг таны хэлснээр өмнө нь бол сая 500 мянга гээд их хэмжээгээр бид нар борлуулах үнэ өндөр байхад тийм компани борлуулалтын бодлого барьж байсан бол 2025 он гарсаар жижиглэсэн. Хамгийн доод талдаа 12 мянга, 24, 32 гээд жижиглээд явсан байгаа. Энэ жижиглэх процесс дээр одоо яг түрүүн хэлсэн боловсруулаагүй нүүрс буюу шууд түүхий нүүрсний арилжаа явахгүй байгаа. Энэ 12 арилжааны ихэнх нь бол манай баяжуулах үйлдвэр ашиглалтад орсонтой холбоотой. Баяжуулсан нүүрсээ бид нар зараад эхэлсэн. Баяжуулсан нүүрсний арилжаанууд ихэнхдээ амжилттай явсан. Гэхдээ яах вэ нэг 5, 6 арилжаанд бол түүхий нүүрс арилжаалсан байгаа. Энэ үнийн индекс гээд юу яагаад байгаа нь болохоор манай Хятад худалдан авагч нарын ер нь дийлэнх олонх компаниуд төрийн өмчийн компаниуд байдаг, төрийн өмчийн оролцоотой.

Тэгэхээр цаад төрийн өмчийн оролцоотой компаниуд маань өөрсдөө одоо жишээлбэл 140 доллароор худалдаж авсан гэрээ өнөөдөр зах зээлийн ханш нь 90 доллар буюу тонн тутамд 50 доллар алдаж байгаа.

Тэгэхээр цаанаасаа төлөөлөл компанийн ТУЗ буюу одоо тэр төрийн байгууллагууд нь бол энэ арилжааг зөвшөөрөхгүй байгаа юм. Үргэлжлүүлэхийг зөвшөөрөөгүй Ганцмодны талбай дээр гацсан байдалтай биржийн нүүрс. Нөгөө талдаа амны буюу урт хугацаат худалдан авагч гээд байгаа тэр худалдан авагчдын Ганцмод дахь талбай бол чөлөөтэй байгаа. Ялгаатай нь зөвхөн биржийн нүүрсийг худалдаж авсан худалдан авагчдын талбай дүүрчхээд одоо нэг ёсондоо татан авалт хийгдэхгүй эндээс түлхэж чадахгүй тийм байдал нөхцөл байдал үүсчхээд байгаа. Зөвхөн энэ үнэ огцом буурсантай холбоотойгоор. Баярлалаа.

Р.Сэддорж: 2 номер хариулт.

Б.Дөлгөөн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. СЗХ-ны үнэт цаасны газрын дарга Дөлгөөн байна. Батболд гишүүний асуултад хариулъя. Би Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 буюу биржийн арилжаанд оролцогчид тавигдаж байгаа тодорхой нөхцөл журмын шаардлага хангуулах ийм харилцааг зохицуулсан хэсэг байгаа. Энэ бол ерөнхийдөө бол зах зээлийг урвуулан ашиглах, үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх эрсдэлийг бууруулах хүрээнд бол хуулиар тодорхой зүйлсийг бол хориглож өгсөн ийм агуулгатай.

Өөрөөр хэлбэл аливаа хэлбэрээр харилцан тохиролцсон үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх гэж оролдсон мөн бодитой бус хэлцэл хийгдсэн, арилжааны яг тодорхой яг үнэ ханшид нөлөөлөх зорилгоор хуурамч мэдээлэл тараасан эрэлт нийлүүлэлтэд бас нөлөөлөх гэж оролдсон ийм тохиолдлууд байх юм бол тухайн арилжааг зогсоож шалгах ийм агуулгаар орж ирсэн буюу энэ яг зах зээлийг урвуулан ашиглах болон бусад зөрчлөөс сэргийлэх зорилготой орж ирсэн ийм утгатай ийм заалтууд явж байгаа. Манай зүгээс мөн өмнөх Батнайрамдал гишүүн болон Батболд гишүүний тодруулж байгаа энэ үнийн индекстэй холбоотой асуултаар зохицуулах хорооны зүгээс хариулахад энэхүү

заалт нь бол индексийг бол тусгаж болно буюу бүх гэрээнүүд заавал үнийн индекс дагасан байх ийм заалт бол биш байгаад байгаа.

Тухайлбал Батнайрамдал гишүүний хэлсэнчлэн яг свот форвард гэрээ буюу 2 талын яг энэ гэрээгээ хааж хийж хийж байгаа энэ нөхцөл бол манай уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон Хөрөнгийн биржийн арилжааны журамд бол хэвээрээ байгаа. Энэ хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулаад яг худалдагч тал өөрийнхөө сонголтоор ямар нөхцөлөөр бүтээгдэхүүнээ зарах вэ гэдэг асуудал буюу үнийн индекстэй байх уу, чанарт өөрчлөлт орох уу гэд гэдгийг худалдагч тал өөрөө бол гэрээгээ зориулж оруулж байгаа.

Яагаад энэ худалдагч тал өөрөө хамгийн эхэнд оруулах ёстой вэ гэвэл яг одоогийн байдлаар свот форвард гэрээнүүд бол яг дуудлага худалдааны зарчмаар явж байгаа. Тэгэхээр анхнаасаа гэрээ худалдан авагч талдаа бол бүх нөхцөлүүд тодорхой байх зайлшгүй шаардлагатай. Тэгээд энэ агуулгаараа бол үүнд хэрхэн өөрчлөлт орох вэ гэдэг асуудлыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулаад гэрээндээ тусгаж оруулах ийм зохицуулалтыг энэ заалтад оруулаад байгаа.

Р.Сэддорж: Туваан сайд хариулах уу? Болчихсон уу? Жаргалан гишүүнийг нэмээрэй. Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай үнэхээр бид нар хоёр, гуравхан жилийн өмнөх түүхээ бас эргэж саначихмаар байна л даа. Улс даяараа л 12 сард гудамжинд гараад төсвөөсөө том хулгай болчихлоо. 40, 50 их наяд том том тоо. Нийтээрээ бухимдаад энэний цаана авлигалын хэргүүд явсаар явсаар оффтейк гэрээнүүд, ирээдүйн шууд гэрээнүүд. Баахан юм болоод л жигшээд л энэний гарц гаргалгаа нь энэ Биржийн хууль нээлттэй өрсөлдөөнт худалдаа юм байна гээд явсан. Түрүүн энэ танилцуулга дээр ч харагдаж байна лээ. Анхны зарласан үнээсээ биржээр орсон арилжаа бүхний ард дунджаар дунджаар үнэ 15 хувь өсөж тогтож байсан гэх мэтийн. Ингээд сайн үр дүнгүүд зөндөө байгаа. Гэтэл одоо ингээд энэ хүрсэн түвшнээ үгүйсгээд хүрсэн түвшнээсээ ухаръя.

Нэгдүгээрт нь тэр нөгөө нэг алдартай жигшиж байсан, улс даяараа жигшиж байсан оффтейкаа хийчихье.

Хоёрдугаарт нь зүгээр оффтейк хийх биш энийгээ энэ хуулийн 10.3 дээр нь байна уу, хэд дээр нь байсан бэ энийгээ шууд энгийн хэлээр бол нөгөө бартерын худалдаа хийчихье. Бүр оффтейк хийхдээ мөнгөн дүнгээр хийхгүй юм байна. Бартераар аваачаад бүтээн байгуулалтын тэр нийгэм эдийн засгийн ач холбогдол гээд гоё зүйл тавьж байгаад бартерын худалдаа хийчихье. Тэгэхээр энэ чинь өөрөө ер нь нэг тийм бид нар урагшлаад байгаа юм уу, ухраад байгаа юм уу? Ер нь энэ хүрсэн түвшнийг чинь яаж жоохон уян хатан, яаж цаг хугацаа алддаг бол шийдвэр хөшүүн хойрго гардаг бол, тээвэр ложистик дээр асуудал гарч байгаа бол энийг шийдэх энэ хүрсэн түвшин гээд энэ дэлхийн энэ чөлөөт нээлттэй өрсөлдөөнт зах зээлийн энэ зарчим руугаа бид нар алхах ёстой болохоос биш 2 жилийн дараа эргээд нөгөө ханцуй дотроо наймаалцдаг болгочихье, өрсөлдөөнгүй болгочихье, урт хугацааны гэрээ хийчихье. Том том

дүнгээр нь хамаагүй хийчихье. Дахиад дээрээс нь бүүр бартер хийчихье гээд бүүр нэг алхам урагш, 2 алхам хойш биш нэг алхам урагш бол 10 алхам хойш ч юм уу энэ чинь бүүр хэддүгээр зууны ямар арилжаа руу ч шууд бартер хийе гэчихсэн нэг ийм хуулийн төсөл яг байж болох юм уу энэ чинь одоо. Энэ оруулж ирж байгаа хүмүүс. Энэ чинь арай хэтэрхий юм биш үү? Ер нь арай хэтэрхий юм биш үү? Үнэхээр тийм төсөв төлөвлөгөө орлого нь тасраад байгаа бол тэр тодотгол юмаа хийгээд нөхцөл байдалтай таараад хөнжлийнхөө хэрээр хөлөө жийгээд асуудлаа шийдээд явж болдоггүй юм уу? Тэр маань хэвээр тэгсэн мөртөө ингээд гоё гоё нэрээр бартер гээд гоё юм хэлнэ л дээ тэр чинь value exchange энэ тэр гээд нэг гоё нэрүүдээрээ хэлнэ.

Тэгэхдээ л тэр чинь зүгээр л мөнгөөр биш ингээд урт хугацааны асар том хаалттай гэрээнүүд л хийе л гэсэн үг шүү дээ. Энэний цаана чинь дахиад нүүрсний хулгай 2:0 дараагийн том авлига ашиг сонирхлын асар том хэргүүдийг баахан хүмүүсийг тийшээгээ түлхэх, эрүүгийн хэрэгт холбогдуулах ийм л үүд хаалга, нөхцөл бололцоо, хөрс суурийг л бэлдүүлж өгсөн нэг ийм л хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт заалтууд л орж ирж байгаа юм шиг л харагдаж байна.

Дахиад дээрээс нь энэ том гэрээнүүд дээр биржийн арилжаан дээрээ хийхдээ энэ дээр нэг ийм юм харагдана лээ. Биржийн арилжааны үнийг тогтоохдоо хуучин чинь индекс хилийн нөхцөл гээд байдаг байсан бол одоо олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулж тогтооно гэнэ үү, тэгээд биржийн анхны энэ анхдагч үнийг тогтооход чинь хуучин нэг биржийн дунджаар индекс авна гэсэн нь бүүр байхгүй. Зүгээр л дураараа үнэ тогтоох анхны суурь үнийг ер нь тэгээд дураараа л тогтооё. Энэ чинь бүүр ерөөсөө ингээд ийм утга учиргүй 2 жилийн өмнө бид нарын энэ улс даяараа хэлж байсан, ярьж байсан энэ бүх зүйлээ л үгүйсгэсэн ийм л зүйл заалт бүхий нэг ийм л орж ирж байна. Тэгээд энэн дээр хариулт авдаг л байх даа.

Р.Сэддорж: Хариулт 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Биржийн тухай хуулийг үгүйсгээгүй харин илүү сайжруулах зорилготой орж ирж байгаа гэдгээ хэлье. Тэгээд нөхцөл байдал хүнд байгаа. Ганцхан Монгол Улс ч гэлтгүй дэлхий дахинд өмнө тогтсон дэг жаяг бүгдээрээ өөрчлөгдчихөөд байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой асуудлууд Монголд аль хэдийнээ сүүдэр нь тусаад эдийн засагт нөлөөлөөд ингээд явж байгаа. Тэгэхээр Засгийн газрын зүгээс энд арга хэмжээ авах үүрэг хүлээснийхээ дагуу бас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж сайжруулах гэдэг байдлаар орж ирж байгаа гэдгийг хэлье. Тэр томоохон value exchange буюу бүтээгдэхүүн солилцооны асуудлыг оруулж ирж байгаа. Тэгээд та бүхэн бүгдээрээ иргэдтэй уулзаж байгаа ойлголт байгаа. Бүгдээрээ л дэд бүтцийн болон нийгмийн шинжтэй асуудлуудыг шийдвэрлүүлэх асуудлыг маш ихээр тавьж байгаа. Сая би жишээ авахад Архангай аймгийн анхдугаар зөвлөгөөн дээр босож ирсэн бүх сумын дарга, бүх аймгийн дарга 100 хувь энэ дэд бүтэц нийгмийн асуудлуудыг шийдэж өгөөч гэдэг ийм зүйл ярьж байгаа. Бид нар энийг бол төсвөөр хийх боломж байхгүй. Бид нар оффтейк болон концесс байхгүй тохиолдолд ийм вариант гаргалгаа байна аа. Энийг Засгийн газар өргөн мэдүүлээд Их Хурлын гишүүд нь болон Улсын Их

Хурал шийдвэл тэнд эцэслэн шийдэгдэхээр орж ирж байгаа. Шийдэгдэхгүй бол мэдээж энэ асуудал цаашдаа явагдахгүй байдлаар ингээд ярьж байгаа.

Тодотголтой холбоотой асуудал бол одоогоор бас үүсээгүй байгаа. Тэгээд мэдээж энэ дээр Их Хурлаар шийдэгдээд ингээд явахаар шууд харанхуй ханцуйн дотроо наймаалцахгүй. Мэдээж энэ дээр гэрээн дээр маш олон асуудлууд яригдана. Ялангуяа энэ жишээлбэл нүүрсээр байлаа гэхэд бид нар явж байгаа урт хугацаанд хийж байгаа гэрээнүүдтэй адилхан хөдөлдөг, тэрийг тоолдог гааль нь хил дээр тоолоод тооцоолол гаргаад, нэг дүн тохироод тэрэндээ нийцүүлэх байдлаар энэ асуудлууд явагдана гэдгийг хэлье.

Мөн энэ дээр энэ суурь үнийн асуудал бас тавигдаад биржээр арилжаалах барааныхаа суурь үнийг тогтоогоод тэрэн дээрээсээ эхлээд дуудаад явна. Биржийн арилжаагаар бол заавал арилжаалагдана.

Ганцхан энэ хууль дээр бол тэр дотоодын хүргэлтийн асуудал нь болохоор манай биржийн хууль дээр экспортын зорилгоор заавал даф нөхцөлөөр гээд орчихсон байгаа. Энийг бид нар дотооддоо дотоодын баяжуулах үйлдвэр зэрэг худалдан авахыг хүсэлт илэрхийлсэн хүмүүст борлуулж болохоор заавал даф биш байдлаар олон улсын нэршлийг ашиглаад энэ танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршил гэдэг байдал дээр тээвэртэй тээвэргүй гэсэн энэ сонголтыг л оруулж ирж байгаа. Тээвэргүй байлаа гээд биржээр арилжихгүй гэсэн ойлголт биш гэдгийг энд хэлье ээ.

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Энэ өдрийн амрыг эрье.

Тэгээд өмнөх гишүүд бас зарим асуулт давхцаж асуусан учраас товчлоод хэлье гэж бодож байна аа. Биржийн энэ бирж гэдэг механизмыг ерөнхийдөө энэ оффтейк герээ нүүрсний экспорт далд утгаараа борлуулагдахгүй байх энэ тэр гээд ил тод байдлыг нэмэгдүүлэх оролцогч талуудын боломжийг хангах байдлаар анх байгуулсан. Одоо нөгөө тоглогч оролцогчид нь өөрсдөө цөөдөөд байгаа учраас асуудал байгааг ойлгож байна. Гэхдээ гэлээ гээд Цогтгэрэл гишүүний хэлсэнчлэн ухарч бид нар болохгүй. Тэгэхээр биржээ илүү яаж идэвхжүүлэх вэ, илүү олон худалдан авагчдыг ч гэдэг юм уу оролцогчдыг бий болох уу энийгээ өдөөх тал дээр нь илүү анхаарвал зүгээр юм болов уу гэдэг ийм саналтай байгаа юм. Тэрнээс ухарч ерөөсөө болохгүй гэдэг дээр саналаа хэлмээр байгаа юм.

Тэгээд 2 дугаарт нь одоо нүүрсний экспортоос бид нар гол төсвийнхөө орлогыг бүрдүүлэх 2025 оны төсвийн тухай хууль дээр ч гэсэн энэ чиглэлээр орчихсон байж байдаг. Гэтэл 3 дугаар сарын дүнгээр нүүрсний дундаж үнэ чинь яг өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 24 хувиар уначихсан байна үнэ нь. Борлуулалтын биет хэмжээ нь болохоор бүүр 16.5 хувиар буурчихсан байна аа. Тэгэхээр өнөөдөр яг энэ биржийн тухай хууль хэлэлцэж байгаа нь яг цагаа олсон. Энэ байдал дээр бид нар яаж цаашаа анхаарч борлуулалтын хэмжээн дээр төлөвлөгөө ямар байдалтай гарсан байгаа вэ гэж давхар асууя гэж бодож байна аа товчхондоо.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Баярлалаа. Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Бид нар биржийн хуулиасаа ухрахгүй. Биржийн хууль маань энэ олон асуудлуудыг шийдвэрлэж өгсөн ил тод болгосон, тодорхой хулгайнуудыг таслан зогсоосон гээд үүргээ гүйцэтгэсэн мөн цаашид ч гүйцэтгээд явна. Тэгэхээр бид нар энийгээ улам сайжруулаад явна ухрахгүй гэдгээ хэлье. Тэгээд энэ оффтейк гээд энэ нэрлэж байгаа. Тэгэхээр би түрүүн хэлээд байгаа. Энэ сонголтыг нь гаргаж өгье. Одоо жишээлэх юм бол бид нар хамгийн сүүлийн Гашуун сухайт-Ганцмодон дээр Чайна Энержи компанитай хийж байгаа хэлэлцээр дээрээ бид нар оруулж өгсөн. Үнийн асуудлыг тохирсон шүү дээ. Үнэ тодорхой олон улсын биш Хятадын 5 биржийн үнэ дээр нэмэх нь суурь үнэ гээд энэ улирал тутам хөдөлдөг үнийг оруулж өгсөн. Энэн шиг энэ дээр ямар нэгэн байдлаар бүтээгдэхүүн солилцоо хийлээ гэхэд бид нар хийлгэж авах дэд бүтэц нийгмийн асуудлаа тохироод үнэлээд нэг үнэ гаргана. Дахиад тэндээ өгөх бүтээгдэхүүн дээрээ дахиад л үнэ тогтоогоод тэрийгээ хяналт тогтоогоод явна. Үнэ өсвөл өсгөөд, буурвал ингээд бууруулаад явдаг ийм байдлаар зохицуулна.

Таны хэлсэн яг тоонууд яг тийм. Бид нар 2025 оны төсөв дээрээ 83 сая тонн 105 доллароор төсөв дээрээ тусгасан. Тэгээд одоогийн байдлаар бол үнийн хувьд энэ баталсан үнээс 24 хувиар, гаргалт бол нэлээн 15 орчим хувиар буураад явж байгаа. Тэгэхээр бид нар энийгээ яаж гаргалгаа олох вэ гэдэг гарц олох үүднээс л энэ хуулийг оруулж ирж байгаа. Тэгээд мэдээж Биржийн хуулиа боловсронгуй болгох сонгодог байдал руу нь оруулах гэрээ арилждаг болох энэ тэр дээр бол яг өнөөдөр ингээд шилжээд хийчих боломж байхгүй байна. Энэ дээр нэлээн хугацаа жилээс жил 6 сарын бэлтгэл ажлын хугацаа нэлээн шаардлагатай байгаа гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Өнгөрсөн хугацаанд сүүлийн жилүүдэд харьцангуй нүүрсний үнэ өндөр. Тэгээд бид ч борлуулалтаа нэмж чадсан. Өөрөөр хэлбэл Засгийн газар орлого сайтай төсвийн орлого сайн бүрдэж байсан ийм цаг хугацаа байсан. Тэгээд Засгийн газар болохоор тэр цаг хугацаа мөнхийн үргэлжлэх юм шиг бодоод маш олон мега төслүүд ярьж байгаа тийм ээ. Тэгээд маш олон бүтээн байгуулалт эхлүүлнэ гэж ярьж байгаа. Тэгэхээр хэдүүлээ ер нь бол зах зээлийнхээ нөхцөл байдалтай, олон улсынхаа нөхцөл байдалтай хүлээлтүүдээ жаахан нийцүүлмээр байгаа юм аа. Угаасаа л манай улсын эдийн засаг энэ гадаад зах зээлээсээ маш их хамааралтай. Түүхий эдийн үнээс хамааралтай. Тэгээд энэ нүүрсний үнэ бол ингээд нэг унаж байгаа ийм цикл дээр ирж байна. Аз болж зэс алт харьцангуй гайгүй байна тиймээ. Тэгэхээр ингээд энэ эдийн засгийнхаа прогнозуудаа нэг аягүй зөв тооцоолоод тэгээд зарим тэр мега төслүүд энэ тэрээ жишээлбэл хойшлуулдаг санж уу, магадгүй тэр төсвөө тодотгодог ч юм уу тиймэрхүү арга хэмжээнүүд авмаар байна. Тэгэхгүй бол одоо ямар зүйл ажиглагдаад байна вэ гэхлээр Засгийн газар сандраад тэгээд нөгөө үндсэн тогтолцоогоо эвдэх маягийн юмнууд оруулж ирээд байна шүү дээ.

Жишээлэх юм бол нөгөө валют гадагшаа урсаад байна гэнгүүтээ нөгөө Зөвшөөрлийн хуульд өөрчлөлт оруулна гээд л тиймээ. Тэгээд л энэ бирийн хууль дээр бас нэг шинэ нөгөө мега төслүүдээ санхүүжүүлэхийн тулд ахиад нэг оффтейк гэрээнийхээ нэг ийм өөр нөхцөл байдлыг оруулаад ирж байх жишээтэй тиймээ. Тэгэхээр хэдүүлээ яг нэг асуудлаа бодитоор хараад тэгээд нэг шийдэлд хүрээд явбал яасан юм бэ гэсэн санаа. Яагаад вэ гэхлээр угаасаа л энэ зах зээл чинь дээш доошоо явна. Тэр тодорхой. Тэгээд Мөнхжаргал захирлаас нэг хэдэн тодорхой асуулт асууя.

Яах вэ энэ биржээр өндөр үнээр худалдаж авсан нөхдүүд нүүрсээ татахгүй байна гэж сая хэлэх шиг боллоо шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ биржээр нүүрс худалдаж авсан ААН-үүд ямар хугацаанд тэр тээвэрлэлт нь хийгддэг вэ? Нөгөө талбай руу нь. Тэгээд тэр нэг хугацааных нь гап нь хэд байна вэ гэдэг асуудал байна. Тэгээд энэ танай дээр одоо байгаа энэ урт хугацааны гэрээнүүд 10.3-т заасан өмнө нь байгуулчихсан байсан гэрээнүүд чинь ер нь одоо танай борлуулалтын хэдэн хувийг яг одоогоор эзэлж байна, эзэлж байна вэ гэдэг асуулт. Тэгээд цаашид ер нь энэ 2025 оны төлөвлөгөөний талаар танай компани дээр ер нь хийгдсэн прогнозууд байна уу? Ер нь эрсдэлүүдээ юу гэж харж байна? Тэгээд энэ төсөвт сая суусан үнүүд байна шүү дээ. 105 доллар тэ 83 сая тонн энэ тэр гээд л тэрэнтэй холбоотой ер нь яг танай компани дээр гарч байгаа тооцоонууд юу болж байна вэ гэдэг асуулт.

Р.Сэддорж: Эхлээд 3 номер, Туваан сайд. Дараа нь нэг номер.

Ц.Туваан: Засгийн газар Их Хурлаас байгуулагддаг өгөгдсөн үүргийнхээ хүрээнд асуудлуудад хандаад гаргалгаа хайгаад явж байгаа. Тэгээд мэдээж гаргалгаан дээр бол энэ оффтейкийн, концессын, бартерын гээд энэ юмнууд дээрээ бид нар бүгдээрээ ер нь энэ дэлхийд хэрэглэгддэг л санхүүгийн арга хэрэгслүүд. Тэгээд энэ дээрээ бид нар бас дандаа буруу хэрэглээд, хулгайд дагагдаад, янз бүрийн хууль бус зүйлүүд гарч ирээд ингээд энэ зүйлүүдээ ингээд нураагаад яваад байсан байна л даа. Тэгээд одоо дахиад энэ зүйлийг ярих гэхээр ярьсан хүн нь шууд буруутдаг иймэрхүү байдал руу яг ний нуугүй хэлэхэд байгаа. Тэгэхээр гаргалгаан дээр бид нар өнөөдөр валютын нөөцийн асуудал нэлээн хүндэрчихсэн. Валютын нөөц цаашдаа эрчимтэй буурах энэ рисктэй. Валютын ханш алдах ийм рисктэй зүйлүүд байгаа учраас бид нар энэ дээр валютаар худалдаж авч бүтээн байгуулалт хийдэг биш, өөрсдөд байгаа бүтээгдэхүүнүүдээрээ одоо тэр зарчим нь бартер, оффтейк, концесс маягийн энэ асуудлуудыг оруулж ирье гэдэг ийм зүйлээр хийж байгаа. Тэгээд бид нар Засгийн газар дангаараа толгой мэдэж хийх биш. Энэ асуудлыг Засгийн газар нь Улсын Их Хур Хурлын бүсчилсэн хөгжлөөс сонгогдсон болон бусад бүх гишүүдийнхээ саналыг аваад эрэмбэлж байгаад шийдвэрлэх асуудлуудыг нь хамгийн өндөр эрэмбэтэйгүүдийг нь Засгийн газар батлаад Их хурал руу өргөн бариулаад Их Хурал эцэслэн шийдэгдсэн бол гэдэг энэ концепцоор орж ирж байгаа гэдгийг хэлье. Нэмж Тавантолгой.

Р.Сэддорж: Нэг номер нэмж хариулна.

Х.Мөнхжаргал: Жаргалан гишүүний асуултад хариулья аа.

Манай энэ биржээр арилжаалагдсан нийт компанийн борлуулалтын 30 хувь нь бол 2024 оны байдлаар биржээр арилжаалагдсан борлуулалт байсан. Үүн дээр бол тэр нөгөө том биржээр арилжаалагдсан хамгийн том хэмжээтэй гэрээ бол 1.6 сая тонн, хугацааны хувьд бол 2-оос 12 сарын хугацаанд бид нар хүргэж өгөх үүрэг гэрээндээ тусгадаг. Энд бол нэг асуудал байдаг нь бол чингэлгээр бид нар нүүрсээ тээвэрлэж хүргэж өгөх ийм зохицуулалттай. Үүн дээр бол худалдан авагч тал өөрөө чингэлгээ бэлдэж өгдөг юм. Энэ бол манай компани өөрөө нэг ширхэг ч чингэлэг байхгүй. Худалдан авагч тал чингэлгээ бэлдэж өгдөг. Энэ асуудлаас болоод одоо энэ нөгөө нүүрсний үнийн бууралттай, уналттай холбоотой чингэлгээ нааш нь юу гэх юм шилжүүлэхээ больсон.

Тэгэхээр ерөөсөө энд бид нар наанаас нь хэдийгээр хүргэж өгөх үүрэгтэй ч гэсэн чингэлэг ирэхгүй бол бид нар ингээд гацаад зогсчихоод байгаа. Ерөөсөө энэ биржийн гэрээний нэг хүргэж өгч чадахгүй болох нөхцөл үүсээд байгаа гол асуудал нь энэ. Мөн компанийн борлуулалт нийтдээ энэ 2025 онд бол бид нар 35 сая тонн нүүрс борлуулна гэж төлөвлөсөн байгаа. Үүнээс бол эхний улирлын байдлаар бол 5.6 сая тонн нүүрсийг борлуулсан. Биржийн борлуулалт бол үнийн бол нэг 20-оод хувийг л эзэлж байгаа. Бусад одоо борлуулалт бол бид нар биржийн энэ үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр үнийн уналттай холбоотой доголдож зогссон, саатал үүссэнтэй холбоотой бид нар урт хугацаат гэрээнүүдээ ерөнхийдөө түлхэх түлхэх буюу түлхүү ачих одоо тийм борлуулалтын стратегийг баримталж ажиллаж байгаа. Үүний үр дүнд манай юуны экспорт уулын уурхайгаас ачих, ачилт, борлуулалт тодорхой хэмжээнд сүүлийн хоногуудад нэмэгдээд явж байгаа ийм үзүүлэлттэй байгаа.

Цаашдаа бол бид энэ биржийн бас энэ ганц мод тал дээр байгаа гацааг энэ арилгах тохиолдолд бид нар биржээрээ хэрвээ үнийн индекс гэсэн энэ тохируулгатайгаа явж чадвал бас биржээрээ нэлээн түлхүү борлуулчих боломж байгаа гэж харж байгаа. Манай худалдан авагчдын хүсэл бас яг энэ үнийн тохируулга байгаа. Үнийн индекс маань өөрөө магадгүй үнэ өсөх үед компанийг алдагдлаасаа аврах нэг хөшүүрэг болж байгаа гэдгийг та бүхэндээ хэлэх гэсэн юм аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Дөлгөөнөөс нэг юм асуугаадахъя даа. Хөрөнгийн биржийн.

Зэс, алт, төмөр, нүүрс гээд хэдэн компанийн төрийн өмчийн хэдэн компанийн хэдэн төрлийн бүтээгдэхүүн хувийн өмчийн хэдэн уурхайн, хэдэн төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдаж байна вэ?

Хоёрт нь чингэлэг тээврээр хэдэн хувь нь вэ? Энэ бараа бүтээгдэхүүнүүдийн? Задгайгаар хэдэн хувь нь явж байна вэ?

Гуравт нь бол тээврийн бизнес яагаад ийм хүнд байдалд орчих воо. Тээвэрчид маань бараг бүгдээрээ ихэнх нь маш хүнд байна. Зээлээ төлж чадахгүй байна. Дампуурлын ирмэгт ирлээ гэж ярьж байна. Энэ юунаас болоод ингэв ээ? 5 номер.

Б.Дөлгөөн: Хөрөнгийн биржийн захирал Дөлгөөн байна. Яг одоо бол 4 төрлийн бүтээгдэхүүн арилжаалж байгаа. Жонш, зэс, төмөр, нүүрс гээд. Тэгээд

нүүрсэн дотроо, жишээлбэл, дотор нь чанар ангиллаар нь ингээд хуваавал нүүрсэн дотроо дахиад 11 төрөл хуваагдаж байгаа. Манайхаар арилжаалж байгаа нэг 27 хувийн болон төрийн өмчийн компаниуд нийлээд 27 компани арилжаа хийж байгаа.

Тэгээд чингэлэг дээр бол Хятад тал руугаа гарч байгаа бүх төрлийн нүүрс бол миний ойлголтоор бол 100 хувь чингэлгээр зөөгдөж байгаа гэж байгаа байх. Энэ дээр Мөнхжаргал захирал илүү шаардлагатай нөхцөлд нэмээд хариулт хэлэх боломжтой. Яагаад дотоодын тээвэр дээр асуудал үүсэж байгаа вэ гэдэг дээр Уул уурхайн биржийн тухай хуулиараа бол нөгөө хилийн боомтын үнэ гээд хилийн боомтын үнэ нь бол цаад талдаа Ганц модны жишээлбэл Ханги Мандалын цаад талын Мандал боомт эсвэл Эрээн боомт гээд ингээд хилийн цаад талын боомтын үнээр арилжаалагдаж байгаа. Тэгээд хилийн цаад талын боомтын үнээр арилжаалагдаж байгаа учраас тээврийг нь зарж байгаа этгээд хариуцаж байгаа.

Энэ дээр бол яг тээвэрчид орж ирж байгаа нь бол уулын уурхайн компаниас бол нэмээд хариулах байх.

Р.Сэддорж: 1 номер.

Х.Мөнхжаргал: Сэддорж даргын асуултад хариулъя. Манай компани ер нь бол өөрөө тээвэр эрхэлдэггүй компани. Ерөнхийдөө бид нар тээврийн биржийн хүргэлтийнхээ тээврийг бол өөрсдөө зохион байгуулж байгаа юм. Сонгон шалгаруулах энэ процессыг бол төрийн худалдан авах агентлаг дээр хийгддэг. Тэнд шалгарсан компаниуд дээр бид нар ерөнхий гэрээ байгуулаад тээврийн чиглэл бүр дээр нь сонгон шалгаруулалтаа зарлаад үнийг тааз үнээс доошоогоо уралдуулах зарчмаар өнөөдөр компаниа сонгож гэрээ байгуулаад явж байгаа. Тэгээд энэ дээр бол ерөнхийдөө компани бол борлуулалт, биржийн борлуулалт тодорхой хэмжээнд бол муудсантай холбоотойгоор тээврийн компаниудад манай тээвэрчдэд маань нөгөө зөөх ачаагүй болсон. Одоо яг өнөөгийн нөхцөл байдал тийм байгаа. Манай урт хугацаат худалдан авагч нар бол тээврээ өөрсдөө зохион байгуулдаг. Тэгэхээр тэр урт хугацаат худалдан авагч нар руу бол манай энэ тээвэрчид орох тийм хүсэл сонирхол сүүлийн үед их явж байгаа. Яагаад гэвэл биржийн борлуулалт буурсантай холбоотой энэ асуудал үүсээд байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: 3 номер нэмж хариулна. Туваан сайд.

Р.Сэддорж: Байнгын хорооны даргын асуултад нэмж хариулъя. Энэ юу яаж байгаа юм. Хуульдаа ерөөсөө 100 хувь биржээр. Тэгээд хил нөхцөл гээд шууд заагаад өгчихсөн. Тэгэхээр тэрэн дээр мэдээж эднийх сая хэлж байгаагаар тендерээ зарлаад явна. Тендерээ зарлахаар мэдээж олон машинтай томоохон компаниуд л орно. Нөгөө жижгүүд ялангуяа одоо энэ дээр чингэлэг тээвэр задгай гээд энэ чинь саяхан ийм шилжилт явчихлаа шүү дээ. Тэгэхээр чингэлэг тээвэр чинь нэг удаадаа 4 чингэлэг ачаад явах ийм шинэ техникүүд ингээд ороод ирэхээр өөр задгайгаар ачдаг хүмүүст орон зай байхгүй болчихоод байна.

Тэгэхээр нөгөө хувийн орон нутгийн өөрсдөө задгай ачааны хуучин тээвэртэй тэрийгээ худалдаад авчихсан арай гэж өөрийн болгочихсон байгаа хүмүүс маань энэ тээвэрлэлтэд оролцож чадахгүй байгаагаас болоод энэ таны асууж байгаа тээвэртэй холбоотой иргэдийн асуудал, жолооч нарын асуудал хүндрээд байгаа. Энэ хуульд орсон нөхцөлөөр буюу тээвэртэй тээвэргүй гэдэг нөхцөлийг хуульчилж өгөх юм бол аман дээрээс авсан хүн яаж өөрсдөө ачаад явна уу, юундаа ачаад явна уу хэн хамгийн хямдаар нь тээвэрлүүлэх вэ энэ тэр гэдэг энэ асуудлаа шийдээд явах бололцоотой учраас тээвэрчдийн асуудал бол ялангуяа орон нутгийн тээвэрчдийн асуудал бол эергээр шийдэгдэнэ гэж харж байгаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Монгол Улс 2025 оны эхний 3 сарын байдлаар 128 улстай гадаад худалдааны харилцаатай явж байна. Яах вэ одоогоор гадаад худалдааны тэнцэл нэг их алдагдалд ороогүй байна. Тэгэхдээ уурхайн гаралтай бараа бүтээгдэхүүн нийт энэ экспортын 94 хувийг эзэлж байна. Тэр дундаа нүүрс нь 39 хувиар буурчхаад байна. Эдийн засаг тийм амаргүй цаг үе рүү л орж ирж байна л даа. Тэгээд аливаа асуудлыг шийдэх хамгийн зөв хувилбар бол үнэнээ хэлэх. Аргалах биш. Бид хэд яах вэ зүгээр нүүрсний хулгайнаас биржээс хууль баталж байж тодорхой ил тод болгосон гээд цаг үеэ гүйцэтгэсэн энэ хууль би үгүйсгэхгүй. Тэгэхдээ үнэнээ хэлэх. Энэ хууль үнэхээр болж байгаа юм уу? Яг ингэж аргалаад асуудалд хандахад бол хэцүү л байгаа байх.

Дээрээс нь яах вэ зүгээр би энэ хуулийн төсөлтэй холбоотой 3, 4 юмыг асуумаар байна. Тэгэхээр энэ бодлогын түвшинд яг үнэхээр энэ хууль энэ уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж чадаж байгаа юу гэдэг зүйл дээр бас яг үнэнээ хэлмээр байна. Үнэнээ хэлмээр байна. Тэгээд бирж гээд нэг компаниар дамжуулаад байдаг. Тэрэн дээр бүх урьдчилгаа төлбөрүүд нь гацчихсан.

Хятадууд нь урьдчилгаа төлбөрүүдээ хаяад явж байгаа. Сүүлдээ энийг нь хөрөнгийн бирж өөрөө дансандаа авах ч хэцүү, улсын орлого болгох ч хэцүү. Хятадууд нь ямар нэгэн байдлаар угаасаа юм үлдээгээд явна гэж байхгүй. Энэ чинь угаасаа хүссэн хүсээгүй хэзээ нэгэн цагт яриа хэлэлцээр яагаад манай ААН байгууллагуудыг хохиролгүй болго гэдэг шахалтыг угаасаа л шат шатандаа үзүүлдэг юм. Дандаа ийм сонин түншүүдээ бид нар хулхиддаг, худлаа хэлдэг. Ийм зүйл рүү явж байгаадаа Монгол Улс хэн бизнес хийх юм. Энийгээ ил тод хэлмээр байна. Хуулийн төсөл дээр ганц юм байна аа. Уул уурхайн бүтээгдэхүүн чанараас болж үнийг өөрчлөх энэ асуудал байхгүй шүү. Энэ бол сая Дөлгөөн захирал асар худлаа юм ярьж байна.

Энэ өөрөө эргээд гарч байсан практик. Эргээд энэ нүүрсний чанарын асуудлуудыг Хятад нэлээн өндөрсгөж байгаа. Ямар сайндаа Эрээнээр гарч байсан тодорхой нүүрснүүд дээр тодорхой агууламж дахь бодисын хэмжээ их байна гээд зогсоогоод явж байсан. Энэ орох юм бол харин манай нүүрс жинхэнэ ёстой чанарын асуудлаа Өвөр Монгол руу гаргах чанарын нүүрсний чанарын асуудлаа өндөрсгөөд бид хэд ёстой элгээрээ хэвтэх ч юм руугаа орж байна. Объём ихэснэ. Үнэ бол навс унана. Тэгэхээр ийм байдлаар энэ хууль орж ирж

байгаа гэдэг асар том эрсдэл байна аа. Энэ ерөөсөө байж боломгүй. Энийгээ хэлэлцүүлгийн үед засаарай гэж бодож байгаа.

Хоёрдугаарт яах вэ зүгээр уул уурхайн компаниуд оператор компаниудтайгаа яриад явж байсан бизнесийг тээврээ хийе гэдэг эрсдэлийг нь үүрүүлсэн. Нүүрсээ ачаад эрсдэлээсээ гарчих юман дээр тээврийн асуудал дээр нь орооцолдоод хил нөхцөл нь Ганцмодны цаана гараад асуудал үүссэн.

Ганцмодны цаана нафтын талбайн түрээс өдөрт 20 мянган төгрөг байгаа шүү дээ. Тонн тутамд. Тэгээд дүүрчихсэн татан авалт байхгүй. Гэтэл наад талын Цагаан хад дээр талбайнууд байгаа. Манайх бол тонн тутамд ачих буулгаад ачих хүртлээ 7 мянган төгрөг л байдаг байсан. Одоо юу болж байгаа юм би мэдэхгүй байна. Ингээд бид нар хурдтай маневрлаад нүүрсээ яг үнэтэй үед нь өөрийнхөө эрсдэлээс гаргачих юмыг ачилтыг нь ч хийлгэхгүй, таталтыг нь ч хийлгэхгүй байж байгаад одоо ингээд 140 доллароор зарсан нүүрсээ 90 доллар болсны дараа өөрсдийгөө ингээд арчаагүй зангаараа эрсдэлээ үүрч байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Уул уурхайн биржийн хуулийнхаа яг бодит юмыг хийе гэж Уул уурхайн сайддаа хэлье. Тэрнээс хэдүүлээ нэг уянгалахдаа биш. Нүүрсний хулгайтай энэ би бол итгэхгүй байна шүү. Энэ төр засгийн ажлыг чинь ингэж Улсын Их Хурал дээр орж ирж бодит үнэнээ хэлж шийдэл гаргадаг болохоос биш уянгалж одоо нэг ийм бараг биржээс эсрэг юм ярьчихвал бүгд нүүрсний хулгайч болно л доо. Тэгэхдээ энэ чинь бодит ажиллаж байгаа юм уу гэдэг зүйлийг хэлмээр байгаа байхгүй юу. Үнэнээ хэлэх. Энэ хамгийн сайн чанар. Энэ хамгийн зөв шийдэл. 140 доллароор зарсан нүүрстэй бид тэр дор нь.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн нэг минут.

П.Сайнзориг: Ачуулаад гаргаад эрсдэлээ худалдан авагч талдаа өгчихсөн бол ийм асуудал ярихгүй шүү дээ. Тэгж байтал ийм нөхцөл байдал байгаа юм. Тэгээд ер нь зүгээр хил нөхцөлийг тогтоож байгаа юмнууд байна аа. Ингээд худалдан авагчийн эрсдэлийг бид нар ингээд энд үүрээд Монгол Улс үүрээд Монгол Улсын төсөв үүрээд байж байгаад би ерөөсөө харамсаж байна. Энэ дандаа ингээд бодлогууд дандаа буруу явж байна. Дандаа сюрприз барьдаг. Тэгээд хоёрхон жилийн бодлого чинь уначихлаа шүү дээ одоо ингээд. Ийм л зүйлүүд байна. Тэгээд би дараа нь энэ нүүрсний асуудал гэдэг чинь бохирдолтой, хорогдолтой ийм заваан юмыг энэ уул уурхайн лиценз эзэмшдэг компаниуд буюу оператор компаниудад үүрүүлж болохгүй ээ. Энийг тээврийг нь тусдаа гаргаад нэг талдаа гаргахгүй бол энэ ерөөсөө явахгүй шүү. Тэгээд асуудал бол байна. Энэ дотоодын биржээр дотоодын баяжуулах боловсруулах үйлдвэр дэх асуудлыг Уул уурхайн сайд хуульчлаад горимоор гаргана гээд боль л доо. Бизнес болгоныг сайдаас асуух юм уу? Ингээд ухралт хийгээд байх юм. Тэгээд биржийн асуудал дээрээ бүр хаа хамаагүй валью эксченжийг нэмээд ороод ирж байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа. Энэ биржийн хууль дээр бол янз бүрийн өнцгүүд байгаа. Би бас нуулгүй хэлье. Биржийн хууль. Энд хориг саад болоод байна гэж ярь ярьж явж байсан хүмүүсийн нэг мөн, үнэнээ хэлэхэд. тэгээд яах вэ судлаад үзэхээр мэдээж бас энэ чинь нэг зүйл дээр хүрэхийн тулд бас бид нарт ингээд муйхарлаад зүтгэх биш ярилцах, хэлэлцэх, гаргалгаа гаргах гэдэг ийм вариантуудаар энийг энэ хүрээнд нь сайжруулаад явж болох юм гэдэг ийм бодлого дээр ирээд Засгийн газар дээр нэгтгэгдээд ярилцаад энэ хуулиа сайжруулаад нэмэлт, өөрчлөлт оруулаад явъя гэдэг ийм зүйлийг гаргалгааг гаргасан. Урд талаас бол яг энэ Биржийн хуулийн бойкот бол явж байгаа. Урд талын компаниудаас тодорхой. Энийг болиулах тэгээд дээрээс нь тэр одоо бүр тодорхой байгаа шүү дээ. Нөгөө даф нөхцөлөөр хүргээд өгөхөөр терминалаа нээж өгдөггүй, чингэлгээ суллаж өгдөггүй. Дахиад бүүр яаж байна гэхээр 4 чингэлэг ачаад явдаг машиныг замын нөхцөл байдал гээд ганцхан чингэлэг ачиж явдгаар зохицуулалт хийгээд энэ нөгөө овоолгыг багасгахгүй гэдэг энэ бодлого чинь бойкотны бодлого чинь яваад л байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар тэрэнд нь тааруулж гэдэг шиг энэ биржийн хуулиа ингээд үйлчлэлийг нь зогсоох энэ асуудал биш. Тэгээд ямар ч байсан нөхцөл байдалтайгаа уялдуулаад сайжруулах гэдэг асуудал. Хэлэлцүүлгийн шатад энэ мэдээж зарчмын зөрүүтэй саналаар. Энэ чанартай холбоотой асуудал дээр тантай санал нэг байна. Өмнө нь энэ дээр гишүүд ярьсан.

Тэгэхээр энэ дээр өөр байдлаар үнэтэй үнийн хэлбэлзэлтэй байдлаар ч юм уу ийм байдлаар оруулж өгөх асуудлыг ярьж болно. Энэ өөрөө бас яг л гацаатай нөхцөл байдлыг яаруу маш хурдан хугацаанд шийдвэрлэх гэдэг үндсэн дээр энэ хуулийн гол прагматик хэрэглээ нь, оруулж ирэх хэрэглээ нь энэ дээр үүссэн гэдгийг хэлье.

Тээвэр дээр бол энэ хууль батлагдвал тээвэртэй тээвэргүй гэдэг сонголт орж ирээд энэ сонголтынхоо үндсэн дээр яг таны хэлсэн шиг хүн бирж дээр тээвэргүй нүүрс худалдаад авбал тэр хүн авахгүй байна уу, юундаа ачаад явна, тэмээндээ ачаад явна уу, машиндаа юм уу, чингэлэгтээ ачаад явна уу яаж гаргах гэдэг тэнд сонголтыг нь үлдээж байгаа асуудал учраас борлуулалтыг нэмэгдүүлэх ийм үр дүнтэй гэдэг байдлаар энэ заалтыг орж ирсэн.

Тэгээд бас зарим асуудал дээр ингээд илэрхийлж ярихдаа хэтэрхий тийм нэг уянгын халилтай зүйл ярьж байгаа бол хүлцэл өчье. Валью эксченжийг оруулж ирсэн 13 дугаар заалтыг та сайн мэдэж байгаа. Энэ заалт бол Нямбаатар сайдын үед төмөр замын суурь бүтэц эзэмшигч компанид эрхийг олгох гэдэг энэ заалт орж ирсэн. Энийг бид нар солиод энэ бүтээгдэхүүн солилцоо буюу валью эксченж гэдэг ойлголтоор оруулж ирж байгаа. Тэгээд ер нь бол яах вэ бас хэлэлцэж батлагдах шийдвэр гаргах гэдэг утгаараа бас тойрч байгаа асуудлууд нуулгүй хэлэхэд байгаа. Агуулгын хувьд бол түрүүний гишүүдийн хэлсэн концесс, бартер, оффтейктой бол ижил агуулгатай зүйл энд байгаа. Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар валютын нөөц валютаараа шууд төлөөд бүтээн байгуулалт хийх энэ тэр гэдэг асуудал маш хүнд болсон байгаа учраас бид нар энэ аргыг сонгож хуулийн заалт болгож оруулж ирж байгаа.

Дахиад Худалдан авах ажиллагааны тухай хууль дээр энэ заалтаа мөн давхарлаж удахгүй оруулж ирэхээр яригдаж байгаа гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн тодруулж асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Туваан сайд яг энийгээ л хэлмээр байгаа юм. Түрүүн Мөнхжаргал захирал хэллээ шүү дээ. Жишээ нь Эрдэнэс Тавантолгойн нийт борлуулсан нүүрсний хорьхон хувь нь бирж шүү дээ. Тэгээд бирж их супер байгаа гээд. Ингээд олон нийтэд өгөөд бүх зүйл ингээд ийм сайхан болчихоод байгаа гээд. Энэ чинь ингээд сүүлдээ асуудал ингээд хүндрээд ирэхээр ийм нөхцөл байдал руу л орж байгаа юм. Тэгээд би яах вэ зүгээр энэ Валю эксченжийг дэмждэг. Тэгэхдээ ингээд хууль зүйн техникийн хувьд танд хэлээд байгаа нь энэ уул уурхайн биржийн асуудал биш ээ. Биржийн тухай хуулийн зохицуулах асуудал биш байхгүй юу. Энийг тэр ТӨК-ийн хууль дээр нь байдаг юм уу дээрээс нь эсвэл магадгүй Засгийн газрын хууль дээр нь байх юм уу эсвэл тэр худалдан авах ажиллагааны хууль байх юм уу эсвэл бие даасан анхдагч хууль байх юм уу? Нэг юм оруулж ирэхгүй бол хэдүүлээ ингээд асуудлуудыг шийдэх гэж оролдож байгаа мэт ингээд буруу харилцаануудыг энэ дотроо явахаар наадах чинь явахгүй. Тэгэхээр энийгээ ингээд анхаараач. Би ингээд юмыг эсэргүүц гээд байгаа юм биш зүгээр ингээд энэний хууль зүйн бодлого, техник гэж юм ерөөсөө яригдахаа ч болилоо. Сая ингээд Жаргалсан гишүүн тэр Зөвшөөрлийн хуулийг эш татаад ярьж байгаа байхгүй юу. Тэгээд ийм нөхцөл байдал руу орлоо. Тэгээд ер нь зүгээр нэг тийм.

Р.Сэддорж: Хариулт хариулт хэн байна? 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Яг тийм. Яг энэ асуудлыг зохицуулах үүднээс энэ тээвэртэй тээвэргүй сонголтыг оруулж ирж байгаа. Тэгээд бирж дээр бол нөхцөлийг нь заагаад арилчихна энэ даф нөхцөлөөрөө арилжих нь. Тээвэргүй нөхцөлөөр арилжих гэдэг энэ байдлаар сонголттой арилжаалагдана. Тэгээд худалдан авсан компани өөрсдөө тээврээ хариуцахаар орж ирэхээр саяын таны ярьж байгаа болон мөн Байнгын хорооны даргын ярьж байгаа асуудлууд эергээр шийдэгдэнэ.

Дээрээс нь энэ дээр нөгөө нэг түрүүний хэлсэн 2-оос 12 сарын хугацаанд гэрээгээр хүргэх гэдэг асуудал дээр компани өөрсдөө шийдээд явбал маш хурдтай маневр хийх боломж өөрсдөө, хүн өөрөө, өөрийнхөө асуудлыг шийдэх гэж байгаа учраас зохицуулалт нь нэлээн хурдсаад энэ нь борлуулалтад эергээр нөлөөлнө гэдэг үндэслэлээр оруулж ирж байгаа.

Р.Сэддорж: Би Сайнзориг гишүүнтэй санал их нэг байна. Тэгээд энэ уурхайчдад уурхайд энэ тээвэр ер нь ямар хамаа байна аа? Тэгээд энэ хуулийн өнгөрсөн хугацаанд энэ дээр л их олон тээврийн компаниудыг хүнд байдалд оруулсан шийдвэр бол энэ байсан юм болов уу. Тэгээд сонголттой болох гэж байгаа юм байна. Тэгээд багц нь хэтэрхий томдсон байна. 500 мянгаар нь. Би зөвхөн нүүрс нүүрсний юун дээр л ярьж байна шүү дээ тиймээ. 500 мянга саяыг авах урьдчилгаа хийх компани чинь тэр хамгийн том төрийн өмчийн компани л байгаа шүү дээ. Тэгээд жижиг бүх худалдан авагч нар байхгүй болчихсон болгочихсон байна. Тэрэн дээрээ алдсан байна. Би энэ цөмийн энергийнхнээс асууя. Хэн нь хариулах юм байгаа юм. Нэг нь хариулж байгаа юм. Энэ хууль дээр

одоо яг товч тодорхой ард олонд ямар заалтууд ороод яаж шийдэх гээд байна вэ?

Хоёрдугаарт нь Эрдэнэс Монголоос энэ Биржийн хуульд өөрчлөлт орсноор танай нийт орлогын хэмжээнд танай нийт хүндрэл бэрхшээлийн шийдэх чухал заалтууд энэ Ядамжаваас асуучихъя. Энийг нэг тодорхой хэлээд өг.

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийнхэн танайх хэдэн хэдэн тонныг энэ биржээр борлуулчихаад байна. Өнгөрсөн онд, энэ онд. Энийгээ хариулчихаарай. Эрдэнэс критикал Тэгшжаргал даргаас энэ хуулийн өөрчлөлттэй холбоотой ямар зохицуулалтууд орж байна вэ гэдэг дээр энэ хүмүүс хариулчих.

4 номер уу? Цөмийн энерги 4 номер.

Э.Нямдаваа: Байнгын хорооны дарга гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Нямдаваа. Цацраг идэвхт ашиглалттай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалтыг маш өндөр түвшинд хийх шаардлагатай байдаг. Тэгээд үйлдвэрлэсэн, бүтээгдэхүүн, тэгээд худалдаалсан бүтээгдэхүүн тэгээд экспортын тоо хэмжээг олон улсын атомын энергийн агентлагт зайлшгүй ийм мэдээлэх ийм шаардлагатай байдаг. Тэгээд эдгээр зохицуулалтыг ерөнхийдөө боловсронгуй болгох зорилгоор Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ дагалдах хуулийг оруулж ирсэн байгаа. Цөмийн энергийн тухай хууль дээр бол цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх энэ тусгай зөвшөөрлийг Засгийн газрын зөвшөөрснөөр цөмийн энергийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага олгоно гэсэн зохицуулалтыг оруулж байгаа. Мөн Цөмийн энергийн комиссын ажлын алба тэгээд төрийн захиргааны төв байгууллага гэсэн зарим заалтуудыг цөмийн энергийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэсэн ийм өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан байгаа.

Р.Сэддорж: Дараагийнх нь гараа өргөөд яваад байгаарай. 2 номер.

Н.Тэгшжаргал: Өрийн мэнд хүргэе.

Эрдэнэс критикал минералын Тэгшжаргал гэж хүн байна. Хуулийн өөрчлөлттэй холбоотой манай давуу тал гэх юм бол энэ индексийн үнийн өөрчлөлт нь манайд бас нэлээн давуу тал болж байгаа. Өнөөдрийн байдлаар биржийн хуулиар яг энэ 7 хоногийн 4 сарын эхний байдлаар манайх бол биржийн юун дээр арилжаад үнийн уналтаас болоод биржийн арилжаа амжилтгүй болсон. Тэгээд энэнээс шалтгаалаад энэ үнийн индексийн өөрчлөлт оруулж байгаа нь манайд давуу тал.

Хоёр дахь давуу тал нь гэвэл дотоодын ААН-үүдэд үйлдвэртээ нэмүү өртөг шингээсэн хажуу үйлдвэрүүдэд бүтээгдэхүүнээ биржээр борлуулах ийм зохицуулалт орж ирж байгаа.

Р.Сэддорж: 5 номер.

Б.Чагнаадорж: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Дарханы төмөрлөгийн захирал Чагнаадорж байна. Манайх 2024 онд биржээр сая 670 мянган тонныг арилжаалахаас сая 310 мянган тонныг арилжаалсан байгаа. 2025 онд сая 970 мянган тонныг арилжаалахаар төлөвлөснөөс өнөөдрийн гүйцэтгэлээрээ сая 670 мянган тонныг арилжаалаад байна аа. Энэ нь бол эргээд бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл бол экспортын баяжмал 2 сая 600 мянган тонн, завсрын бага агуулгатай бүтээгдэхүүн 2 сая 500 мянган тонны үлдэгдэлтэй байна аа.

Р.Сэддорж: Ядамжав 5 номер.

Д.Ядамжав: Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн дотоодын ААН-үүдэд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаалах эрх зүйн орчны гацаа гарах ийм хүлээлттэй байгаа. Одоогоор энэ асуудалтай холбоотойгоор 15-аас 40 хувийн төмрийн агуулгатай 2.2 со сая тонн хэмжээтэй ойролцоогоор 42 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий төмрийн хүдэр завсрын бүтээгдэхүүний овоолго үүссэн байгаа.

Өнөөдрийн байдлаар бол төмрийн хүдэр завсрын бүтээгдэхүүн агуулах талбайн дүүргэлт бол 87 хувьтай байгаа. Цаашид тасралтгүй нэмэгдэж үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа явуулахад бас хүндрэлтэй байгаа. Эдгээр хувийн хэвшлийн баяжуулах үйлдвэрүүд нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-үүдэд бүтээгдэхүүнээ заавал биржээр арилжаална гэсэн биржийн арилжааны үнийг хил залгаа улсын хилийн боомтоор зарлана гэж тус тус зааснаас шалтгаалж түүхий эдийн хомсдолд орсон, үйл ажиллагаа нь доголдсон, экспортын орлого бүрдүүлэхэд бол тодорхой хүндрэл үүсэж байгаа ийм зүйлүүд байгаа.

Монгол Улсын Засгийн газраас гарсан тогтоолоор Эрдэнэс Монгол нэгдэлд энэ жил валютын орлогын нөөцийг 1 тэрбумаас багагүй доллароор нэмэгдүүлэх ийм үүрэг хүлээсэн байгаа. Тэгээд биржийн арилжаатай холбоотой энэ хуулийн доголдолтой холбогдож экспортын бүтээгдэхүүний хэмжээ буурсан валютын нөөц хомсдолд орох ийм эрсдэл хүлээгдэж байгаа.

Тийм учраас энэхүү гацаа ялангуяа Эрдэнэс Тавантолгой компанитай холбоотой нүүрс тээврийн гацаа арилснаар тодорхой бизнес төлөвлөгөөнд туссан орлогууд нэмэгдэх ийм хүлээлттэй байгаа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Нэрсээ өгөөрэй. Соронзонболд гишүүнээр тасалъя. Ирцийн дарааллаар эрэмбэлээрэй.

Соронзонболд гишүүн нэг номерт гарч ирж байна. Соронзонболд гишүүн үг хэлнэ.

Л.Соронзонболд: Энэ хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа.

Ер нь бол зах зээлийн нөхцөл байдал хэзээ ч яаж ч өөрчлөгдөж болно. Тэгэхээр манай энэ уул уурхайн биржийн үйл ажиллагаа нь өөрөө уян хатан борлуулалт хийж байгаа хүмүүс маань ч гэсэндээ борлуулалт хийх болон хангалттай ийм нөхцөлтэй байх ёстой гэж харж байгаа юм. Зүгээр анхаарах зүйл юу байна вэ гэхээр энэ 14.6 дээр энэ уул уурхайн бүтээгдэхүүний чанар энэ зах зээлийн индексээс хамаарсан гэдэг дээр олон шалтгаан байгаа. Жишээлбэл уурхайн бүтээгдэхүүний чанар бол худалдан авагч хэрвээ тээвэрлэлтээ хийхгүй байгаагаас болоод удсанаас болоод чанар муудвал хэн хариуцлагыг нь хүлээх вэ тиймээ. Худалдагчаас хамаарсан байж болно. Эсвэл тухайн бүтээгдэхүүнийг хадгалж байгаа агуулахаас хамаарсан байж болно. Угаасаа гуравдагчаас хамаарсан байж болно. Тэгэхээр энэ шалтгаан бүрд нь тохирсон энэ үнийн хэлбэлзлийг тогтоохдоо тэрийг анхаарах ёстой гэж зориуд цохож тэмдэглэж хэлмээр байна. Энийг анхаарах ёстой.

Дараагийн асуудал болохоор энэ олон улсын худалдааны гэрээ хэлцлийн нөхцөлийг энэ бүх байршил дээр ашиглаж эхлэх гэж байгаа нь зүйтэй. Гэхдээ энэ дээр болохоор одоо энэ Эрдэнэс Тавантолгой компанийн энэ борлуулалтын гэрээнүүдийг харахаар маш их хэмжээгээр урт хугацаатай гэрээ байгуулчихсан энэ хооронд нь зах зээлийн үнэ нь хэлбэлзчихдэг үүнээсээ болоод нөгөөдүүл нь авах сонирхолгүй болчихдог ийм асуудлууд байгаад байна.

Тийм учраас энэ ашиглаж байгаа гэрээнийх нь хийж байгаа худалдаанууд илүү богино хугацаатай тодорхой богино хугацаанд татах боломжтой байхаар ингэж арилжаагаа зохион байгуулахгүй бол энэ асуудал чинь энкотермоор хийчихдэг энко тоормос чинь бүр илүү хатуу нөхцөлтэй шүү дээ. Хэрвээ дунд нь банк ашиглагдаад эхлэх юм бол банкнууд нь энкотермосын чанарын нөхцөл хангагдаагүй гээд буцаах энэ тэр гээд зөндөө асуудлууд байгаа.

Тийм учраас энэ дээр ийм олон улсын өнөө худалдааны санхүүжилтийн нөхцөлүүдээ сайн анхаараарай гэж хэлмээр байна.

Р.Сэддорж: Батболд гишүүн үг хэлнэ. Ренчиндоржийн Батболд.

Р.Батболд: Уул уурхайн биржийн хуульд өөрчлөлт оруулж байгааг ер нь яах вэ дэмжээд байгаа юм. Тэгэхдээ энэ дээр энэ биржтэй холбоотой асуудал чинь энэ дээр хэлэлцэх явцад нэг засвар оруулчих юмнууд байгаад байна. Энийг энэ уурхайн биржийнхэн ч тэр яамныхан, хөрөнгийн биржийнхэн ч гэсэндээ жоохон дэмжлэг үзүүлээд энийг засаж сайжруулах тал дээр нь анхаарч ажиллаарай л гэж хэлье. Ер нь бол хуулийн өөрчлөлтийг дэмжиж байгаа.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн үг хэлнэ.

Б.Жаргалан: Сая хэлэлцүүлгийн дунд бартер гэдэг зүйл яригдсан болохлоор зүгээр нэг товчхон санал хэлэх гэсэн юм. Ерээд онд манай улсын

эдийн засаг маш их хүндрээд гадаад валютын орох урсгал хумигдаад, манай бараа бүтээгдэхүүн олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадваргүй байх цаг үе. Бартер гэдэг үгтэй бүгдээрээ болсон байхгүй юу. Тэгээд тэрийг би маш сайн санадаг юм. Тэгээд яах вэ энэ бол ямар нөхцөлд хийдэг зүйл вэ гэхлээр харин тийм өрсөлдөх чадвар муутай яг тийм нөхцөлд хийдэг зүйл. Тэгэхээр бол бид цаашид бол энэ манай энэ уул уурхайн түүхий эдийн зах зээл дээр бид өрсөлдөх чадвараа сайжруулмаар байна.

Тэгээд энэ чинь бол яг ингээд бодит валют орж ирэх ёстой салбар байхгүй юу. Тэгэхээр энэ чинь ингээд нөгөө бүтээгдэхүүн солилцох гэрээ байгуулна гэдэг чинь аргаа ядсан асуудал болчхож байгаа байхгүй юу. Тэгээд бид нар бодит валют олж ирээд тэр валютаа юунд зарахаа өөрсдөө шийдмээр байна шүү дээ энэ чинь. Тусгаар тогтносон улс байна даа. Тэгэхээр цаашдаа бодлогын асуудлуудаа бол ийшээгээ л чиглүүлмээр байна хэдүүлээ. Тэгэхгүй бол яг л нөгөө ерээд он чинь давтагдаад нөгөө бартерынхаа систем рүү ороод нөгөө валют нь ч олдохоо байгаад сая ингээд л нөгөө валютын ханш гээд л ярьж байна шүү дээ. Өнгөрсөн хугацаанд бол одоо энэ доллар еврогийн ханш ёстой айхтар хэлбэлзэж байна шүү дээ энэ чинь тэгээд л ер нь манай эдийн засгийн дархлааг л унагаагаад л байна. Манай худалдаач нарт аягүй сөргөөр нөлөөлж байна. Тэгэхээр энэ зүйл рүүгээ та бүхэн маань анхаараач. Өрсөлдөх чадвараа хэдүүлээ сайжруулъя. Саяын яригдаад байгаа наад тээвэр гэх мэтчилэн энэ бусад асуудлууд дээрээ маш тийм оновчтой тогтолцоотой больё энэ асуудлуудаа арай өөрөөр харъя аа. Тэгэхгүй бол ер нь цаашдаа бол эдийн засгийн нөхцөл байдлууд улам хүндэрч магадгүй. Тэрийг бид нар мэдэхгүй шүү дээ тийм ээ? Тэгэхээр бид нар аливаа нөхцөл байдалд бэлэн л байх ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол түүнээс биш яг жаахан үнэ унаад ирэхлээр сандралдаад л янз бүрийн юм руу ороод байх шаардлага байхгүй.

Тэгэхээр тийм ийм л санал энэ бодлого тодорхойлж байгаа яамныхандаа хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн үг хэлнэ.

О.Батнайрамдал: Сая 1 үг гарч байна. Доголдол гэнэ ээ, хуулийн доголдол. Үгээ бодож хэлэх хэрэгтэй байх аа. Энэ хуулийн доголдол уу, менежментийн доголдол уу? Өнөөдрийн тулгамдаж байгаа асуудал чинь цоо шинэ ерөөсөө биш. Ковидын үеэр 2020 онд Цагаан хадан дээр овоолго дүүрчихсэн, яг адилхан бид нар асуудалдаа тулгамдаж л байсан. Тэгэхээр ерөөсөө цоо шинэ биш байхгүй юу даа. Асуудал гараад ирэнгүүт нь гэнэт хууль болохгүй байна, хуулийн доголдол байна, хуулиа өөрчилъё, менежментээ өөрчлөөгүй юм уу тэгээд. Менежментээ өөрчилнө гэсэн яасан юм. Засгийн газар Эрдэнэс Тавантолгой дээр гадаад менежмент тавина гээд л яриад байсан шүү дээ. Тэр хаана байна. Цаашдаа нөхцөл байдал улам хүндрэх юм бол бид нар хуулиа хэчнээн өөрчлөөд асуудлаа шийдэж чадахгүй шүү. Тэрийг хэн шийдэх вэ гэх юм бол менежмент шийдэх ёстой байхгүй юу. Менежментийн асуудал шүү. Олон улсын хэллэгээр энэ технологи оперэйшнс менежмент тоон гэж ярьдаг юм. Ерөөсөө энийгээ шийдэх ёстой байхгүй юу. Бид нарын тулгамдаж байгаа асуудал цоо шинэ биш.

Эрдэнэс Тавантолгой дээр гадаад менежментээ авах ёстой бол тэрийгээ яаралтай ав. Цаашдаа асуудал улам хүндрэх нь ойлгомжтой байна. Энийгээ өнөөдөр бид нар энэ хуулийн таны хэлж байгаагаар хуулийн доголдлоороо энэ нэмэлт, өөрчлөлт оруулахаар хамаг асуудал шийдэгдэж байгаа юм шиг юм юм яриад энэ асуудал шийдэгдэхгүй шүү. Бирж үнэ өсөхөөр ямар ч асуудал хэн ч яриагүй үнэ буурсан чинь Биржийн хууль доголдол болчихлоо. Ингэж ярьж болохгүй. Тээвэрлэлттэй холбоотой зөндөө энэ дээр тээвэрлэлтээс гадна зөндөө асуудлууд байгаа. Одоо тэр сая багцын асуудал ярьж байна. Багцаа яагаад жижиглэхгүй байгаа юм бэ? Энэ бүх компанид хамааралтай шүү. Эрдэнэс Тавантолгой, Дарханы төмөрлөг. Сая хариулсан Дарханы төмөрлөг танайд бүр илүү хамааралтай шүү. Багцаа жижиглэхгүй болохоор өрсөлдөгчид байдаггүй. Бирж чинь ерөөсөө өрсөлдөөнийг гаргаж ирэх гэсэн гол концепт байхгүй юу.

Багцаа томруулчихаар тэрийг барьцаагаа тавьж чадах ганц хоёрхон компани ганц хоёрхон компанитай нугалаа үүсгэх амархан. Тэгэхээр энэ багцын асуудлыг яаралтай шийдэхгүй бол энэ том асуудал болж хувирна шүү. Менежментийн асуудал байхгүй юу. Дандаа менежментийн асуудал. Тэгэхээр энэ нэг хуулийн өөрчлөлтөөр бүх асуудлаа шийднэ гэдэг хариулт байж болохгүй. Яах вэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль нэг арай хэрэгжээд 3 жил болоогүй юм байна. Дахиад нэмээд өөрчлөх гэж байна. Яах вэ сайжруулъя гээд тэгж байгааг ойлгож байна. Ганц тэр дотоодын баяжуулах үйлдвэрүүдтэй холбоотой тэр асуудлууд байна. Яах вэ шийдэх ёстой асуудал мөн. Тэгэхээр энэ хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжиж байна. Гэхдээ Засгийн газрын энэ өргөн барьсан энэ нэмэлт, өөрчлөлт дотроос засах юм маш их байна. Фундаментли буюу бүүр тэр чигээр нь засах асуудлууд зөндөө байна шүү. Олон улсын худалдааны танхимын инкотерм гэж ярьж байна л даа. Тэгээд сая Соронзонболд гишүүний хэлсэн үг зөв шүү олон улсын худалдааны танхим гэдэг гоё үгээр хаацайлаад ам нөхцөлөө бий болгож байна гэж ойлгосон чинь олон улсын худалдааны танхимын нөхцөл чинь өөрөө маш хатуу нөхцөл байдаг байхгүй юу. Тэрийгээ шалгасан уу? Бид нар буцаад нөгөө талдаа ямар том олон улсын худалдааны зарчмын дагуу гэрээ хийхээс өөр гарцгүй болж байна гэдгээ энэ дээр бодох ёстой байгаа юм.

Тэгэхээр нэг гоё үгээр халхлаад энийг оруулчихна гэж ойлгож байгаад өөрсдөө бүр том асуудалд бүдрэх вий дээ. Тэгэхээр энэ ер нь бол тэр аргачлал олон зүйл батлахыг зүгээр батална гээд орхиод байна л даа. Тэгэхээр хэн батлах нь ойлгомжгүй Засгийн газар батлах юм уу, Эрдэнэс Тавантолгой батлах гээд байгаа юм уу? Эрдэнэс Монгол батлах гээд байгаа юм уу гэх мэтчилэн энэ хууль ерөөсөө төв түүхий орж ирж байна л даа.

Тэгэхээр ажлын хэсэг гараад энийг нэлээн сайжруулж өөрчлөхгүй бол энэнээс гарах үр дагавар нь буцаад Монгол Улсад маш том эрсдэлийг дагуулна шүү дээ. Хамаг хулгай, хамаг болохгүй зүйл нүүрсэн дээр гардаг. Ойлгомжтой яагаад гэх юм бол нүүрсэн дээр хамгийн том бизнес эрхэлдэг байхгүй юу. 2024 онд бид нарын орлогын 9 тэрбумыг нүүрс дангаараа биелүүлж байсан.

Р.Сэддорж: Дэмжиж үг хэлж байна. Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Байнгын хороо бас дэмжээд Улсын Их Хурлын чуулган дээр хэлэлцэх эсэхийг дэмжээд гаргасан тохиолдолд ажлын хэсэг гаргаж ажиллах нь зөв өө. Энэ дээр ажлын хэсэг гаргаасай гэж хүсэж байна аа. Энийг 1 дүгээрт хэлье.

Хоёрдугаарт яг энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаагүй валью эксченжийн асуудлыг оруулж ирж байгаа. Энэ асуудлаа анхааръя. Энийгээ харин яг байх ёстой хууль дээр нь оруулж ирээд Улсын Их Хурлынхаа хяналтад тодорхой ямар нийгмийн болоод энэ улс орны эдийн засгийг түргэтгэх төслүүдийг тодорхой энэ загвараар явуулж болох юм бэ гэдгээ шийддэг байх. Тэр хувилбар луугаа явах нь зөв. Тэгэхээр энэ дээр хуулийн төсөл оруулж ирж байгаа энэ Засгийн газрын баг хамт олон анхаараач.

Нэг юм руу л ингээд бүх юмыг чихдэг нэг ийм үзэгдэл бий болчихлоо.

Хоёрдугаарт би Батнайрамдал гишүүний хэлж байгаатай санал нэг байна аа. Менежментээ сайжруулах. Гэхдээ өнөөдрийн Монгол Улсын нөхцөл байдал чинь тээвэр, логистикийн нөхцөл байдал чинь угаасаа багтаамжтай хүчин чадалтай. Энэнээс мянга давж бид нар менежмент хийхэд бурхан бууж ирсэн ч хийж чадахгүй. Энэ тээврийнхээ хүчин чадал байгаа, 2 дугаарт энэ жижиглэнгээр явсан ч гэсэн өдөр өдөрт нь угаасаа хилийн цаана гаргаж өгөх ямар ч бололцоо байхгүй эсвэл богино хугацаандаа гаргаж өгөхгүй учраас энэ алт, зэс гаргах гэж байгаа биш байхгүй юу. Энэ нүүрс чинь өөрөө хорогддог, шатдаг, бохирддог, чанар алдагддаг ийм төрлийн бизнес байхгүй юу. Тэгээд энэ бол нэг их тийм одоо нэг савлагаатай бүтээгдэхүүн биш.

Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ яг бодит зарим үнэнээ хэлээд ийм зүйл байна. Би одоо хүртэл жижиг Тавантолгой дээр нэг БЭТ-ээр ажиллаад 6 сар яаж байхад уурхайн амнаас гарч байгаа тээвэрлээд явж байгаа автомашинаас хорогдолтой очдог байхгүй юу. Уурхай дээрээс хэмжилт нэг байдаг. Нафтын талбай дээр буухад нэг байдаг. Авто зам нь ямар билээ. Тэгээд сүүлдээ яг энэ нэг менежмент буюу гүйцэтгэх захирал дунд нь зогсоож байгаад шанагадаад авчихсан юм шиг юм яригддаг байхгүй юу.

Тэгээд Уул уурхай, эрдэс баялгийн яамнаас тухайн үедээ энэ хорогдлын асуудал дээр нэг тийм аргачлал гаргаж өгөөч гэсэн одоо хүртэл байхгүй. Тэгээд энэ дээр чинь ямар менежмент явах юм. Ийм байхаар тэгэхээр энийг нөгөө бодит нэг энэ ажлыг нь ойлгож байж энэ зөв зүйлийн менежментийг бодоорой. Би яах вэ тийм уул уурхайчин хүн биш. Тэгэхдээ бодит байдал дээр нь нэг 6 сар үзсэн. Нүүрс тээврийн асуудлыг дагаад тэр Цагаан хад хүртэл нь дагаж явж үзсэн. Үнэхээр тэр аймшигтай замаар нүүрс бүтэн очдоггүй юм байна лээ. Цагаан хадан дээр тэр хил гаалийнхаа нөхцөл байдал ачааллаасаа болоод нүүрснүүд хорогдоно, эрсдэлүүд үүснэ. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг уг нь уурхай буюу энэ уурхайн бизнесийг хийж байгаа хүмүүс биш эрсдэлийг нь худалдан авагч тээврийн компани 2 хоёулаа юмаа зохицдог. Энэ рүүгээ л илүү бодлогоо оруулаад бид хэд үнэтэй үедээ үнэтэйгээрээ хурдан зараад авчихмаар байна.

Сүүлдээ энэ чинь ингээд явсаар байгаад тээвэрлэж ч өгч чаддаггүй компани. Яг олборлоод л зарангуут нь энэ чинь тэр хэмжээгээрээ оператор компаниуд чинь нүүрснүүдийг чинь.

Р.Сэддорж: Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Энэ хуулийг батлахад улс төрийн нөхцөл байдал үнэхээр хүнд байсан үе л дээ. Бас их шоу драмтай байсан үе. Засгийн газрыг огцруулна гэсний дараагаар нүүрсний хулгай гэдэг 44 их наядын айхтар хэргийг Доржханд Чимэдийн Хүрэлбаатар нар зарлаж 17 хүний нэрийг жагсааж өнөөдрийг хүртэл тэр хүмүүсийнхээ ихэнхийг нь ажил амьдрал, алдар хүндээр нь тоглосон тэр үед энэ хуулийг баталсан юм аа. Тэр 17 дотор нэр дурдагдсан 5-аас 6 гишүүн өнөөдөр энэ Их Хурал дотор байна аа. Байнгын хороо даргалаад сууж байна аа. Ийм нөхцөл байдалд пи ар нь давамгайлж энэ хууль баталсан.

Тэгэхээр энд алдаа байлгүй яах юм. Байгаа.

Тэгэхээр энэ хуулийг өөрчлөх гээд оруулж ирж байгаа ажлын хэсгийнхнийгээ хулгай хийх гэж байгаа юм шиг битгий тэгж ярьцгаагаач ээ. Энэ хүмүүс хулгай хийх гээд энд ингээд бөөнөөрөө сууж байгаа биш. Аливаа хууль болохгүй байвал засаж болно засаад л яв. Зах зээлдээ тохируулаад. Би дэмжиж байна. Ялангуяа 10.3-ыг дэмжиж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, нийгэм эдийн засгийн ач холбогдолтой гэж үзэж байвал энэ нүүрсээр яагаад бартер хийж болохгүй гэж. Бүтээгдэхүүн солилцохоор. Энэ заавал дээр үед хийдэг орчин үед хийдэггүй юм биш шүү дээ. Энэ 14 мега төслүүдээ тэгээд яаж хөдөлгөх юм. Энэ нүүрсийг юунд нь харамладаг юм. Түүхийгээр нь тэгээд бартер хийх ёстой бол хийгээд гаргаад нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой том мега төслүүдээ хөдөлгөх нь зөв өө. 6,5 сая тонн гацсан байна гэж байна. Килийн үнээр гээд. Үнэ нь буучихсан. Энийг тэгээд яах юм байлгаад байх юм уу? Нүүрсний үнэ өсгөхийг хүртэл бид нар хараад байх уу? Үгүй шүү дээ, өөрчлөөд л явах хэрэгтэй шүү дээ.

Дээрээс нь энэ дотоодын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүд бүтээгдэхүүний хомсдолд орчихсон яахаа мэдэхгүй сууж байна. Ашигт малтмалын тухай хуулиуд дээр баяжуулах болон өөрчилсөн шинэчилсэн найруулга дээр энэ үйлдвэрүүдэд тусгай зөвшөөрөл өгөх хуулийн төсөл ороод ирчихсэн байгаа. Болохгүй байгаа юмыг зах зээлийнх нь нөхцөл байдалд тохируулаад засаад явах нь зөв өө.

Энд байгаа ажлын хэсгийнхэн яг үнэнийг хэлж чадахгүй байна л даа. Яагаад гэвэл хамаагүй үнэнийг нь хэлчихвэл нүүрсний хулгайч болж харагдчих гээд байгаа учраас үгээ залгиад байна. Эд нарын буруу биш л дээ. Тэгэхээр бид хэд тухайн үеийн пи ар тухайн үеийн улс төрд гаргасан алдааг хүлээн зөвшөөрөөд тэрийг нь засаад хуулиа оруулчихсан нь зөв гэж бодож байна. Дахиж харин ийм улс төр хийгээд, хууль батлаад тэр нь пи арын шинж чанартай болоод хоёрхон жил бололгүй тэр нь амьдрал дээр буцаад л гараад ирж байгаа байхгүй юу. Тэгвэл бид нар 126 засаад л явчихъя. Энэ дээр аймаар их маргаад байх шаардлага байхгүй. Сайнзориг гишүүнтэй санал нэг байна.

Сайнзориг гишүүн бид 2 санал нийлэх юмтай өдөр ирдэг л юм байна, талархаж байна.

Р.Сэддорж: Ингээд гишүүд маань дэмжиж ер нь ихэнх нь дэмжиж тэгээд сайжруулах талаар үг хэллээ. Тэгээд тээврийн сонголттой болгож байгаа нь сайн байна. Төрийн өмчийн компаниуд тээвэр нь тусдаа байх тээврийн сонголттой байх нь зөв байх. Яг хувийн уурхайтай компаниуд бол өөрийн гэсэн машинуудтай учраас болоод байгаа байх. Тэгэхээр энэ төрийн өмчийн компаниуд чинь бол энэ олон тээврийн хэрэгсэл тээврийн компаниудыг дэмжиж, уян хатан ажиллаж, тэр худалдан авагчид нь тээврээ хийгээд явах тэр нь бараг дээр байх аа. Тэгээд энэ сонголттой болгож байгаа нь зөв байна. Хөрөнгийн бирж их анхаарч байгаа байх. Тэгээд багц нь томдоод байна. Тэгээд том том харилцагч нартай харилцах гээд байгаа юм уу, тэр худалдан авагч нараа, худалдан авалтаа нэмэгдүүлэх бодлого барих гээд байгаа юм уу. Энийгээ бас цаашдаа анхаарч залхуурахгүйгээр арилжаагаа хурдан хурдан хийх ийм шаардлагатай байна.

Тэгээд энэ чинь төмрийн хүдэр ч дүүрчхээд байгаа юм байна, агуулах нь дүүрчхээд байгаа юм байна. Нүүрс ч дүүрчхээд байгаа юм байна жонш яаж байгаа юм? Тэгээд энэ юмнууд дээрээ яаралтай анхаарахгүй болохгүй нь. Валью эксченжийг дэмжиж байна. Хангайн бүсийнхэн сая дэмжсэн байна. Маш зөв.

Тэгээд тэр бүс нутгийг бүс нутагт байгаа тулгамдсан бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтуудыг тэгээд өөрийн бүс дээр байгаа тэр уул уурхайгаасаа валью эксченж хийгээд хөгжүүлж байвал тэгээд л улс оронд л хэрэгтэй. Энэ дээр манай гишүүд бүрэн дэмжиж байгаа юм байна аа.

Эрдэнэс Монгол компанийнхан тэр говийн бүсэд байгаа тэр нэг хос зам тавьж байгаа компани байгаа тиймээ. Цогтцэцийгээс Гашуунсухайт руу чиглэсэн тэр зам одоо болтол ашиглалтад орох гээд концессын зам. Тэр зам ашиглалтад ороогүйгээс олон хүний амь нас эд хөрөнгө тэнд сүйдэж байна. Тэр хос зам яагаад ашиглалтад орохгүй байгаа юм. Яагаад тэр компани хийхгүй байгаа юм. Орон нутаг нь дэмжээд байхад яагаад өдий болтол ашиглалтад орохгүй байна. Тэр зам ашиглалтад орсон бол өдийд ямар олон хүний амь нас үрэгдэхээс сэргийлэх байсан бол. Ямар олон машин техник эвдрэхээс сэргийлэх байсан бол. Дотоодын үйлдвэрүүдээ энэ хуулиар дэмжиж байгаа юм байна.

Аргагүй энэ биржийн хуулиас болоод дотоодын үйлдвэрүүд түлшгүй болчихсон. Коксжих нүүрс хэрэглэдэг олон үйлдвэрүүд байгаа. Эд нар зам юу нь ажлынх нь гарц нь нээгдэж байгаа юм байна гэж ойлгож байна аа. Дэмжиж үг хэлж байна.

Гишүүд үг хэлж дууслаа.

Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

55 хувь бүртгэлийн санал хураалт дэмжигдэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтууд үргэлжилнэ дагасан хуулиудын.

2.Хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Батсүмбэрэл гишүүн горимын санал Батсүмбэрэл гишүүн горимын санал гаргаж байна.

Н.Батсүмбэрэл: Сая техник дээр алдаа гарлаа. Саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүний санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн цөмийн хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Батсүмбэрэл гишүүн горимын санал гаргаж байна.

Н.Батсүмбэрэл: Техник дахин одоо ажилласангүй ээ. Тэгээд дахин санал хураалт явуулж өгнө үү?

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт.

Алдаржавхлан гишүүн горимын санал гаргаж байна.

Ж.Алдаржавхлан: Хурууны төхөөрөмж ажилласангүй. Дахиж санал хураалгаж өгөөч ээ.

Р.Сэддорж: Энэ хурууны төхөөрөмжүүд үнэхээр ажиллахгүй байгаа юмаа. Алдаржавхлан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт.

60 хувиар санал дэмжигдэж санал хураалт хүчингүй боллоо.

Дахин санал хураалт. 4.Одоо санал хураалт. Сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн.

Одоо үндсэн саналаа дэмжих эсэх дээр. Хамт өргөн мэдүүлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалт.

Найдлаа гишүүн горимын санал гаргая.

Б.Найдалаа: Энэ үнэхээр ажиллахгүй байгаа учраас санал хураалтыг хүчингүй болгоод дахин хурааж өгнө үү.

Р.Сэддорж: Гишүүд анхааралтай байя. Энийг дэмжье гэсэн саналаа анхааралтай өгөөд сүүлийн Найдалаа. Гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Найдалаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт.

Санал хураалт хүчингүй боллоо. Санал 60 хувиар дэмжигдлээ.

Ингээд санал хураалтыг дахиж явуулъя. Хамт өргөн мэдүүлсэн Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүд идэвхтэй санал хураалтад оролцоорой.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын

төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд унших танилцуулах хүн гараа өргөөрэй манай гишүүд. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна аа.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дуус дууслаа.

12.52 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Байнгын хорооны тогтоол гишүүд байж байгаарай. Хоёрхон санал хураалт байна.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Соронзонболд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд Батболд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

Байнгын хорооны дарга.

Гишүүд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж санал ирэх хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Техник гацаад байх шиг байна. Жуковын Алдаржавхлан гишүүнээр тасалъя.

Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Ажлын хэсгийг дэмжиж байна, тогтоолыг. Тэгээд бүрэлдэхүүнд нь нэмж орох саналтай байна аа.

Р.Сэддорж: Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Ажлын хэсгийн ахлагчаас асуучихъя. Ер нь зүгээр ямархуу ажил хийхээр төлөвлөж байгаа юм. Зорилго чинь яг юу юм. Ямар өргөн цар хүрээнд ажиллах юм. Хэдий хэмжээний хугацаанд ажиллах юм гээд энийг хариулт өгчихье.

Тэгээд эндээс одоо таалагдах юм бол орж ажиллая.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн хариулна.

Л.Соронзонболд: Энэ 2020 оны Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоол маань өөрөө энэ зээлийн хүүг бууруулах стратегийг баталсан. Энэ баталсан стратегийн дагуу хавсралт байгаа. Хавсралтын дагуу болохоор төрийн байгууллагууд хийх ажлууд байгаа. Зөндөө ажлууд байгаа юм байна лээ. Тэгэхээр ямар ч байсан ажлын хэсэг маань энэхүү стратегийн хавсралтын дагуу хийх ёстой ажлаа тухайн байгууллагууд хийсэн юм уу гэдэг 1 дүгээр асуудал байгаа.

Хоёрдугаарт болохоор энэ зээлийн хүүг бууруулах стратегийн асуудал зөвхөн Монгол банк СЗХ-ны асуудал биш ээ. Энэ бол бас Эдийн засгийн хөгжлийн яам болон бусад байгууллагууд оролцож байж энэ нээрээ ажлын үр дүн гарах ёстой ийм ажил байгаа.

Тийм учраас энэ талаар нэлээн хүрээг нь өргөтгөж авч үзнэ гэж үзэж байгаа болох уу?

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Найдлаа гишүүнд микрофон нээж өгье.

Б.Найдалаа: Тэгье. Энэ их чухал ажлын хэсэг. Энэний хэрэгжилтийг дүгнэх юм бол дараагийн шатын тодорхойлоход чухал байх. Тэгээд би энэн дээр өмнө нь ажиллаж байсны хувьд бас орчихвол зүгээр санагдаад явчихлаа. Уг нь хөндлөнгөөс нь дэмжье гэснээс дотор нь орсон нь ер нь зөв юм шиг байна. Тэгээд би орох саналтай байна аа ажлын хэсэгт.

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж, асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дахин уншиж танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Батболд, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл Улсын Их Хурлын гишүүн Найдалаа нараар бүрэлдэхүүнийг нэмлээ. Ингээд Алдаржавхлан гишүүнийг нэмж байна.

Ингээд санал хураалтыг явуулж эхэлье ээ.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Ажлын хэсгийг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

12.57 цагт

Дараагийн асуудалдаа оръё. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол банкны Хууль, эрх зүйн газрын захирал Аюуш, Итгэлсүрэн СЗХ-ны ББСБ-ын газрын дарга, Баттулга Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны дарга, Мөнх-Ундрах Монголбанкны Санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал. 4 хүн байна уу? 3 хүн байна уу? Нэг нь хаана байна? Дуудаарай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье ээ.

Мөн зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналын томъёоллуудыг уншиж танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 дахь хэсгийг баримтлан гишүүдээс бичгээр ирүүлсэн бүх саналуудыг танилцуулсны дараа ирүүлсэн дарааллаар нь санал хураалт явуулна аа.

Хамгийн эхэлж дэмжигдсэн саналыг Байнгын хороо дэмжсэнд тооцож бусад саналаар санал хураалт явуулахгүй ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 4 саналын томъёолол ирүүлсэн байна.

Гишүүд байнгын хорооны хуралдаанууд давхцаад санал хураалтын ирц хүрэлцэхгүй байгаа учраас даргын дэргэдэх зөвлөл дээр дахин хуралдах цагийг зарлая.

Ингээд хуралдааныг хойшлуулж байна. Санал хураалтыг хойшлуулж байна. Хэлэлцэх асуудлыг хойшлуулж байна. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

13.03 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА